

**Мэдлэг, хандлага, дадлын  
асуулгын судалгааг  
Хүүхэд хамгааллын  
салбарт хэрэглэх нь**

МХД-ын асуулгын судалгааг хүүхэд хамгааллын  
салбарт хэрэглэх алхамчилсан зөвлөмж





**Мэдлэг, хандлага, дадлын  
асуулгын судалгааг  
Хүүхэд хамгааллын  
салбарт хэрэглэх нь**

**МХД-ын асуулгын судалгааг хүүхэд хамгааллын  
салбарт хэрэглэх алхамчилсан зөвлөмж**

Энэхүү зөвлөмжийг боловсруулахад санал өгсөн бүх хүний үнэт цаг, чин сэтгэлд тусгайлан талархаж байна. Хүүхэд хамгааллын салбарт мэдлэг, хандлага, дадал (МХД)-ын асуулгын судалгааг анхлан хийж, шинэ зам гаргасан Либери болон Сьерра-Леоне дахь Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн ажилтнуудаар бахархахын зэрэгцээ энэхүү зөвлөмжид зориулан өөрсдийн туршлагаа харамгүй хуваалцсанд нь талархъя. Түүнчлэн Либерид хийсэн МХД-ын асуулгын судалгааны протокол боловсруулж, судалгааг удирдсан МкГилл их сургуулийн Моника Руйз-Касарест энэхүү зөвлөмжийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэнд зохиогчийн зүгээс талархаж байна. Мөн НҮБ-ын Хүүхдийн Сангийн төв удирдах газрын статистик, хяналт-шинжилгээний албаны ажилтан Клаудиа Каппад, Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгааны талаар мэдлэг туршлагаа хуваалцсанд нь зохиогчийн зүгээс талархал илэрхийлье.

**Боловсруулсан:** Абигейл Холман (бие даасан зөвлөх)

**Төслийг удирдаж, зохицуулсан:** Сара Лиллей (Их Британийн Хүүхдийг Ивээх Сан), Хүүхэд хамгааллын санаачилгын Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хэсэг

**Төслийн менежмент:** Денайс Стакеибрук, Мери Горхмазьян, Розита Д.Соуза

**Орчуулагч:** Клауде Вехбе (Араб), Марсела Сариего (Испани), Мариа дел Пилар Ганез (Испани), Сиди Габар Фол (Франц)

**Монгол хэлнээ хөрвүүлсэн:** Загирын Тогтохмаа

**Орчуулгыг хянасан:** Энхбатын Цолмон, Энхболдын Жаргал

**Редактор:** Эвелин Садио (Франц), Инес Гимоно (Испани), Жумана Забане (Араб), Карине Буйссет (Франц), Луйса Лосовиз (Испани)

**Бүтээлийн менежмент:** Майкл Антони

**Дизайн:** Куо Бангкок ХХК

**Хэвлэсэн:** Хүүхэд хамгааллын санаачилга, Хүүхдийг Ивээх Сан

**Зургийн эрх:**

Нүүр: Карин Биате Ностеруд

Хуудас 2: Луца Клеве-Рууд

Хуудас 4: Луца Клеве-Рууд

Хуудас 7: Тери Пенгиллей

Хуудас 8: Женна Нассаче

Хуудас 10: Хүүхдийг Ивээх Сан

Хуудас 13: Карин Биате Ностеруд

Хуудас 16: Жоанне Оффер

Хуудас 21: Луца Клеве-Рууд

Хуудас 22: Пиерс Бенатар

Хуудас 23: Женна Нассаче

Хуудас 24: (дээд тал) Женн Варрен

Хуудас 24: (доод тал) Родриго Ордонез

Хуудас 29: Матс Лигнелл

Хуудас 30: Шафикүл Алам Кирон

Хуудас 33: Алехандро Кирчук

Хуудас 34: Хүүхдийг Ивээх Сан

Хуудас 35: Кейт Холт

Хуудас 37: Кулвадее Сумналоп

Хуудас 38: Мадур Дасс

Хуудас 41: Алехандро Кирчук

Хуудас 42: Женна Нассаче

Хуудас 44: Луца Клеве-Рууд

Хуудас 45: Хүүхдийг Ивээх Сан

Хуудас 46: Прашант Вишванатан

Хуудас 49: Мадур Дасс

Хуудас 50: (дээд тал) Хүүхдийг Ивээх Сан

Хуудас 50: (доод тал) Пер-Андерс

Петтерссон

Хуудас 52: Хүүхдийг Ивээх Сан

Хуудас 57: Майсиэ Кров

Хуудас 58: Женн Варрен

Хуудас 59: Хүүхдийг Ивээх Сан

Хуудас 60: Кулвадее Сумналоп

Хуудас 62: Женна Нассаче

Хуудас 64: Лингрид Лунд

Хуудас 65: Луца Клеве-Рууд

Хуудас 66: Себастьян Рич

Хуудас 67: Кейт Холт

Хуудас 68: Кулвадее Сумналоп

Хуудас 70: Стюарт Бамфорт

Хуудас 72: Кулвадее Сумналоп

Хуудас 75: Луца Клеве-Рууд

Хуудас 76: Мадур Дасс

Хуудас 79: Хүүхдийг Ивээх Сан

Хуудас 81: Брендан Баннон

Хуудас 82: Луца Клеве-Рууд

Хуудас 85: Варрик Пейж

Хуудас 95: Жейн Ханн

2021 оны 12-р сард хэвлэв.

# Агуулга

<b>Өмнөх үг</b>	<b>2</b>
<b>Хураангуй</b>	<b>4</b>
<b>Удиртгал</b>	<b>7</b>
<b>АЛХАМ 1: Асуулгын судалгааны зорилгыг тодорхойлох нь</b>	<b>21</b>
1.1. Хоёрдогч мэдээллийг судлах	22
1.2. Асуулгын судалгааны зорилго, зорилтуудыг тодорхойлох	23
1.3. Судлах асуудлуудыг тогтоох	26
1.4. Судалгааны гол асуултуудыг тодорхойлох	27
1.5. Асуулгын судалгааны зорилтот хүн амыг тогтоох	29
1.6. Түүврийн төлөвлөгөө гаргах	32
<b>АЛХАМ 2: Асуулгын судалгааны протокол боловсруулах нь</b>	<b>35</b>
2.1. Асуулгын судалгааны протоколын гол бүрэлдэхүүн хэсгүүдийг боловсруулах	36
2.2. Ёс зүйн зөвшөөрөл авах, хүүхэд хамгааллын бодлого гаргах	37
2.3. Ажлын төлөвлөгөө гаргах	43
2.4. Төсөв боловсруулах	44
<b>АЛХАМ 3: Судалгааны асуулга боловсруулах нь</b>	<b>45</b>
3.1. Асуулга боловсруулах	46
3.2. Асуулгыг бүтцэд оруулах	52
3.3. Асуулгыг орчуулах	55
3.4. Мэдээллийн менежмент, дүн шинжилгээ хийх төлөвлөгөө гаргах	55
3.5. Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг турших, эцэслэх	56
<b>АЛХАМ 4: МХД-ын асуулгын судалгааны мэдээлэл цуглуулах нь</b>	<b>59</b>
4.1. Мэдээлэл цуглуулах хугацаа, өдрийг сонгох	60
4.2. Асуулгын судалгааны баг бүрдүүлэх	61
4.3. Асуулгын судалгааны багийн гишүүдийг сургах	62
4.4. Мэдээлэл цуглуулах	64
4.5. Мэдээллийн чанарыг баталгаажуулах	65
<b>АЛХАМ 5: Мэдээллийн менежмент, дүн шинжилгээ хийх нь</b>	<b>67</b>
5.1. Мэдээллийг программд оруулах, цэвэрлэх	68
5.2. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх төлөвлөгөөг хэрэгжүүлэх	70
5.3. Үр дүнг тайлбарлах, танилцуулах	73
5.4. Мэдээллийн чанарыг баталгаажуулах	73
<b>АЛХАМ 6: Асуулгын судалгааны үр дүнг хэрэглэх нь</b>	<b>75</b>
6.1. Үр дүнг танилцуулах, хэрэглэх	76
6.2. Үр дүнг хөтөлбөрийн төлөвлөлтөд хэрэглэх	77
6.3. Үр дүнг түгээх	78
<b>Нэмж судлах материал</b>	<b>79</b>
<b>Нэр томъёоны тайлбар</b>	<b>85</b>
<b>Хавсралт</b>	<b>95</b>
<b>Ном зүй</b>	<b>117</b>

Өмнөх үг





Хүүхдийг Ивээх Сан нь “хүүхэд хамгаалал” гэдгийг аливаа хэлбэрийн зүй бус харьцаа, үл хайхрах байдал, хүчирхийлэл, мөлжлөгөөс хүүхдийг урьдчилан хамгаалах арга хэмжээ, хариу үйлчилгээ, бүтэц – зохион байгуулалт хэмээн тодорхойлдог. Энэхүү “арга хэмжээ, бүтэц – зохион байгуулалтын” нэг цөм бүрэлдэхүүн хэсэг нь хүүхэд хамгааллын асуудалтай холбогдох олон нийтийн мэдлэг, хандлага, зан үйл юм.

Хүүхдийг Ивээх Сангийн хувьд хүүхэд хамгааллыг сайжруулахын тулд хүүхэд, асран хамгаалагч, бусад насанд хүрэгч болон төрийн байгууллагын хандлага, зан үйлийг өөрчлөхөд хүүхэд хамгааллын хөтөлбөрийнхөө томоохон хэсгийг чиглүүлдэг. Бидний үйл ажиллагааны ихэнх нь нийгмийн хэм хэмжээнд нөлөөлөх, бүх хэлбэрийн хүчирхийлэл, үл хайхрах байдал, зүй бус харьцаа, мөлжлөгөөс хүүхдийг хамгаалахын тулд нийгэмд өөрчлөлт авчрахад чиглэсэн байдаг. Бидний хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд өргөн хүрээтэй боловч хүүхэд хамгааллын ажлын энэхүү хэлбэрийг хянаж шинжлэх, үнэлэх, улмаар үйл ажиллагаа маань нийгмийн хэм хэмжээ, дадлыг хэрхэн өөрчлөн сайжруулж байгааг түншүүдтэйгээ хамтран тодорхойлох чиглэлээр сорилттой тулгарч байна.

Хүүхдийг Ивээх Сан 2009 онд хүүхэд хамгааллын хөтөлбөрүүдийн цар хүрээг өргөтгөх, чанарыг сайжруулах зорилгоор Хүүхэд хамгааллын санаачилга (ХХС) хэмээх дотоод механизмыг бүрдүүлсэн. Хүүхдийг Ивээх Сан зорьж буй үр дүндээ хүрэх гол элементүүдийн нэг нь манай хөтөлбөрүүдийн хүүхдийн амьдралд үзүүлж буй үр нөлөө, дэвшлийг хэмжих бидний өөрсдийн чадвар билээ. 2010 оноос хойш хүүхэд хамгааллын хөтөлбөрүүдийг төлөвлөх, хянаж шинжлэх улс орны хөтөлбөрүүдийн чадавхыг сайжруулахад чиглэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний хэд хэдэн механизмыг арга хэрэгсэл, удирдамжийн хамт хэрэгжүүлэхийг хичээж ирлээ.

Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад цуглуулсан мэдээллийн чанарыг сайжруулах үүднээс хүүхэд хамгаалалд мэдлэг, хандлага, дадлын судалгааг хэрэглэх энэхүү зөвлөмжийг боловсруулаад байна. Ялангуяа энэ нь бидний судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын чанарыг бэхжүүлэхэд туслахаас гадна нэн чухлаар тавигдаж буй баримт нотолгоонд суурилсан хүүхэд хамгаалалд нэг алхам өөрчлөлт оруулах Хүүхдийн Ивээх Сангийн хувь нэмрийг бодит болгоно.

Энэхүү зөвлөмж нь үүнийг зохиогч Абигейл Холманы нөр их хүчин зүтгэл, мэдлэг туршлагагүйгээр бий болохгүй байсныг тэмдэглэхийн зэрэгцээ Их Британийн Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн гүйцэтгэх захирал Сара Лиллейд гүнээ талархаж байгаагаа илэрхийлье. Зөвлөмжийн талаарх санал хүсэлтээ ХХС ба Хяналт-шинжилгээ үнэлгээний ажлын хэсэгт эсвэл [cpi.me@rb.se](mailto:cpi.me@rb.se) хаягаар ирүүлнэ үү.

### **Лена Карлссон**

Хүүхэд хамгааллын санаачилгын захирал  
Хүүхдийг Ивээх Сан



# Хураангуй



Мэдлэг, хандлага, дадал (МХД)-ын асуулгын судалгаа нь тодорхой бүлгийн хүн ам тодорхой сэдвийн талаар ямар мэдлэгтэй байгаа, тэр талаар юу мэдэрч, бодож байгаа, ямар хариу үйлдэл үзүүлж байгаа тухай мэдээллийг багтаасан тоон судалгаа юм. МХД-ын асуулгын судалгаа нь хүүхэд хамгааллын хөтөлбөрийн төлөвлөлт, дизайн, нөлөөлөл, нийгмийн хөдөлгөөн, нөхцөл байдлын үнэлгээ, үр дүнгийн үнэлгээг сайжруулахад хэрэглэж болох үнэ цэнтэй мэдээллийг цуглуулах боломж олгодог.

Хүүхэд хамгааллын талаарх хүмүүсийн мэдлэг, зан үйлийг тоон хэлбэрээр илэрхийлэх нь хамгааллын ажлын цар хүрээг ойлгох, үндэсний хүүхэд хамгааллын тогтолцоо, бодлого, практикийн дэвшлийг хүчин төгөлдөр баримтаар нотлоход тун чухал үүрэгтэй. Иймэрхүү мэдээллийг бүрдүүлэх хэрэгцээ тун их байгаагаас гадна хүүхэд хамгаалалтай холбоотой мэдээлэл цуглуулах найдвартай, баталгаажсан арга зүй, аргачлал хомс байна. Энэхүү хэрэгцээнд үндэслэн суурь үзэл баримтлал, зарчим, алхмуудаас гадна зөвлөгөө, арга хэрэгсэл, нөөц, кейс судалгаа бүхий МХД-ын асуулгын судалгааны уг зөвлөмжийг гаргав. Зөвлөмжийг хүүхэд хамгааллын хөтөлбөрт МХД-ын асуулгын судалгааны арга зүйг амжилттай хэрэгжүүлсэн Хүүхдийг Ивээх Сангийн үйл ажиллагаа хэрэгждэг хоёр улс (Сьерра-Леоне, Либери)-ын туршлагад үндэслэн боловсруулсан бөгөөд МХД-ын асуулгын судалгааг хэрэглэж буй бусад салбарын туршлагыг зөвлөмжид мөн багтаасан болно.

**Хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлаар мэдлэг, хандлага, дадлын тоон мэдээлэл хэрэгтэй байгаа хүүхэд хамгааллын хөтөлбөрийн бүх ажилтанд зориулан энэхүү зөвлөмжийг гаргав.**

**Энэхүү гарын авлагын зорилго нь:**

- **Хүүхэд хамгаалалд МХД-ын асуулгын судалгааг хэрэглэх үзэл баримтлалыг танилцуулах;**
- **Хүүхэд хамгааллын хөтөлбөрт хэрэглэх мэдээллийг цуглуулахад МХД-ын асуулгын судалгаа тохиромжтой эсэхийг тогтооход хэрэглэгчдэд туслах;**
- **Үйл явцын үе шат бүрд үнэ цэнтэй зөвлөгөө өгөх, хэрэгжилтийн явцаас сурсан зүйлээ хуваалцах замаар МХД-ын асуулгын судалгааг бэлтгэх, хэрэгжүүлэх, үр дүнг хэрэглэх талаар дүрслэн харуулах;**
- **МХД-ын асуулгын судалгааны мэдээллийн чанарыг баталгаажуулах, судалгааны ялгаатай үе шатуудад хүүхдийн оролцоог хангах талаарх аргачлалыг нэмж танилцуулахад оршино.**

Энэхүү зөвлөмж нь судалгааны арга зүйн хувьд цогц хэрэгсэл, нөөц биш боловч уг судалгааг хийхэд шаардлагатай суурь мэдээлэл, ойлголт өгөх ач холбогдолтой. Хэдийгээр энэхүү арга зүй нь энгийн мэт боловч мэдлэг, хандлага, дадал нь олон талтай бөгөөд мэдээллийн чанар, найдвартай байдлын хувьд заавал анхаарч үзэх ёстой асуудлууд бий. Тиймээс эдгээр бэрхшээлийг урьдчилан харах, зохицуулах чадвар бүхий туршлагатай судлаач МХД-ын асуулгын судалгааг төлөвлөх шатнаас нь эхлэн удирдах нь нэн чухал. Хүүхдийг Ивээх Сангийн улс орнуудын хөтөлбөрүүдийн олонх нь МХД-ын асуулгын судалгааг удирдан хэрэгжүүлэх зөвлөхийг гаднаас урьж ажиллуулах боломжтой бөгөөд энэхүү зөвлөмж нь тэрхүү зөвлөх болон бусад ажилтнуудад үнэтэй нөөц болох юм. Асуулгын судалгааг дотоодын эсвэл гадны зөвлөх удирдан хэрэгжүүлэхээс үл хамааран хяналтаа тогтоох, зөв асуулт тавих, асуулгын судалгааны зорилгыг хангах, хөтөлбөрийн ажилтнууд, хамтрагчид, нэн ялангуяа хүүхэд энэхүү үйл явц, үр дүнгийн эзэн байхад чиглэсэн шийдвэр гаргахад хөтөлбөрийн ажилтнуудад тусална.

Энэхүү зөвлөмжийн удиртгал хэсэг нь МХД-ын асуулгын судалгааг зохион байгуулах эхний шийдвэр, түүнчлэн хэрэгцээ болон байгаа нөөцөд суурилан мэдээлэл цуглуулах хамгийн зохистой аргыг сонгох явцыг харуулна.

Зөвлөмжийн үлдсэн хэсгүүд нь МХД-ын асуулгын судалгааг төлөвлөх, хэрэгжүүлэх дараах алхмуудыг багтаана:

**АЛХАМ 1: Асуулгын судалгааны зорилгыг тодорхойлох**

**АЛХАМ 2: Асуулгын судалгааны протокол боловсруулах**

**АЛХАМ 3: Асуулга боловсруулах**

**АЛХАМ 4: Мэдээлэл цуглуулах**

**АЛХАМ 5: Мэдээллийг оруулах, цэвэрлэх, шинжлэх**

**АЛХАМ 6: Мэдээллийг тайлагнах, хэрэглэх**

Асуулгын судалгааны үе шат бүрд хүүхдийн оролцоог хэрхэн хангах, сайжруулах тухай санал зөвлөмж, боломж бололцоог энэхүү зөвлөмжид тусгасан болно. Түүнчлэн энэхүү зөвлөмжид судалгааны үндсэн арга зүйгээс гадна нэн ялангуяа хүүхэд хамгааллын хөтөлбөрт нэн чухал байж болох дараах хоёр сэдвийн хүрээнд мэдээлэл, санал зөвлөмжийг багтаасан:

- I. Хүүхдээс судалгаа авах нь:** Асуулгын судалгаанд хүүхдийг оролцогчоор хамруулж байгаа тохиолдолд анхаарах шаардлагатай ёс зүйн хийгээд арга зүйн тусгай асуудлуудыг энэхүү сэдэвт багтаасан (Алхам 2-т үзүүлсэн).
- II. Мэдээллийн чанарын баталгаа:** Асуулгын судалгааны үе шат бүрд гарч болох мэдээллийн чанарын эрсдэл, түүнтэй холбоотой асуудлаас урьдчилан сэргийлэх болон бууруулахад чиглэсэн арга хэмжээг энэ хэсэгт багтаасан (Алхам 5-д үзүүлсэн).

Түүнчлэн зөвлөмжид мэргэжлийн нэр томъёоны бүрэн **тайлбарыг** оруулснаас гадна **нэмж судлах материал, нөөц** болон тухайн улс орны хөтөлбөрийн онцлогт тохируулан хэрэглэж болох загвар, арга хэрэгсэл бүхий **хавсралтуудтай**.



# Удиртгал

Зөвлөмжийг хэнд зориулсан бэ?

Зөвлөмжийг хэрхэн ашиглах вэ?

МХД-ын асуулгын судалгаа ба хүүхэд  
хамгаалал

Хүүхэд хамгааллын салбарт МХД-ын  
асуулгын судалгааг яагаад хэрэглэх ёстой вэ?

МХД-ын асуулгын судалгааг сонгох нь:  
Тохиромжтой арга мөн үү?

МХД-ын асуулгын судалгааг хэзээ хийх вэ?

Гол алхмууд

Нөөцөө тооцох нь

Дүгнэлт, шалгалт



# Удиртгал

Мэдлэг, хандлага, дадал (МХД)-ын асуулгын судалгаа нь хүүхэд хамгааллын хөтөлбөрийн төлөвлөлт, нөлөөлөл, хөгжлийн хөтөлбөр дэх олон нийтийн оролцоо, нөхцөл байдлын үнэлгээ, үр дүнгийн үнэлгээг сайжруулахад хэрэглэж болох чухал тоон мэдээллүүдийг цуглуулдаг. Энэхүү зөвлөмжийг судалснаар хүүхэд хамгааллын хөтөлбөрт МХД-ын асуулгын судалгааг хэрэглэхтэй холбоотой суурь үзэл баримтлал, зарчим, алхмуудаас гадна практик зөвлөгөө, арга хэрэгсэл, нөөцийн талаар тойм ойлголттой болно.

**МХД-ын асуулгын судалгаа гэдэг нь тодорхой бүлгийн хүн ам тодорхой нэг сэдвээр ямар мэдлэгтэй, юу бодож, мэдэрдэг, ямар үйлдэл үзүүлдэг талаарх мэдээллийг цуглуулдаг тоон судалгаа юм.**



Хүүхэд хамгааллын талаарх хүмүүсийн мэдлэг, зан үйлийг тодорхойлох тоон мэдээлэл нь хамгааллын асуудлын цар хүрээг ойлгох, үр дүнтэй хариу арга хэмжээг тодорхойлоход чухал үүрэгтэй. Иймэрхүү мэдээллийн хэрэгцээ тун их байгаагаас гадна хүүхэд хамгаалалтай холбоотой мэдээлэл цуглуулах найдвартай, баталгаажсан арга зүй, аргачлал хомс байна. Энэ нь эргээд хүүхэд хамгааллын тогтолцоог хөгжүүлэх, бодлого, практикийг боловсронгуй болгох, дэлхий нийтээр хүүхдийн хамгаалуулах эрхийг хангахад ихээхэн саад учруулж байна.

МХД-ын асуулгын судалгааг олон улсын хөгжлийн хийгээд тусламжийн байгууллагууд анхан шатны эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн хөтөлбөрүүдэд хэрэглэх мэдээлэл цуглуулах зорилгоор 1960, 1970-аад оноос хэрэглэж эхэлсэн байна. Өдгөө энэхүү МХД-ын асуулгын судалгаа нь сайтар боловсрогдсон, өргөн хэрэглэгддэг арга зүй болжээ. Хэдий тийм боловч тоон судалгааны бусад аргатай нэгэн адил МХД-ын асуулгын судалгаа нь хүүхэд хамгаалалд харьцангуй шинэ хандлага юм.

Энэхүү зөвлөмж нь үзэл баримтлал, зарчим, алхмуудаас гадна зөвлөгөө, арга хэрэгсэл, нөөцийг санал болгох замаар хүүхэд хамгааллын салбарт дутагдаж буй тоон мэдээллийг бүрдүүлэхэд тусална. Уг зөвлөмжийг хүүхэд хамгааллын хөтөлбөрт МХД-ын асуулгын судалгааг амжилттай хэрэгжүүлсэн Хүүхдийг Ивээх Сангийн үйл ажиллагаа хэрэгждэг хоёр улс (Сьерра-Леоне, Либери)-ын туршлагад үндэслэн боловсруулсан бөгөөд МХД-ын асуулгын судалгааг хэрэглэж буй бусад салбарын туршлагыг мөн багтаасан болно.

## Зөвлөмжийг хэнд зориулсан бэ?

Хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлаар мэдлэг, хандлага, дадлын талаарх тоон мэдээлэл хэрэгтэй байгаа хүүхэд хамгааллын хөтөлбөрийн ажилтнуудад зориулан энэхүү зөвлөмжийг боловсруулсан. Түүнчлэн хүүхэд хамгаалалд МХД-ын асуулгын судалгааг хийхээр улс орны хөтөлбөрүүдийн сонгосон зөвлөхүүд энэ зөвлөмжийг эх сурвалж болгон хэрэглэж болно.



Энэхүү гарын авлагын зорилго:

- Хүүхэд хамгаалалд МХД-ын асуулгын судалгааг хэрэглэх үзэл баримтлалыг танилцуулах;
- Хүүхэд хамгааллын хөтөлбөрт хэрэглэх мэдээллийг цуглуулахад МХД-ын асуулгын судалгаа тохиромжтой эсэхийг тогтооход хэрэглэгчдэд туслах;
- Үйл явцын үе шат бүрд үнэ цэнтэй зөвлөгөө өгөх, хэрэгжилтийн явцаас сурсан зүйлээ хуваалцах замаар МХД-ын асуулгын судалгааг бэлтгэх, хэрэгжүүлэх, үр дүнг хэрэглэх талаар дүрслэн харуулах;
- МХД-ын асуулгын судалгааны мэдээллийн чанарыг баталгаажуулах, асуулгын судалгааны ялгаатай үе шатуудад хүүхдийн оролцоог хангах талаарх аргачлалыг нэмж танилцуулах

Энэхүү зөвлөмж нь ярилцах чадвар, чиглүүлэг, сургалт, мэдээлийн дүн шинжилгээ гэх мэт судалгааны арга зүйн хувьд цогц хэрэгсэл, нөөц биш боловч уг судалгааг хийхэд шаардлагатай суурь мэдээлэл, ойлголт өгөх ач холбогдолтой. Зөвлөмжийг а) судалгааны аргуудын талаар суурь мэдлэгтэй, түүнчлэн МХД, хүүхэд хамгааллын чиглэлээр тодорхой зөвлөгөө, арга хэрэгсэл хайж буй; 2) асуулгын судалгааг удирдах эсвэл дэмжих үүрэгтэй гаднын зөвлөхийг авахаар төлөвлөж буй хүүхэд хамгааллын хөтөлбөрийн ажилтнууд болон тэрхүү зөвлөхөд зориулсан билээ.

Хэрэв зөвлөх авахаар төлөвлөж байгаа бол энэхүү зөвлөмж нь Танд хэрэгцээ болон сонирхож буй зүйлээ зөв тодорхойлох, нөөцөө хянах, зөв асуулт тавих, мэдээлэлтэйгээр шийдвэр гаргахад туслах бөгөөд ингэснээр судалгааны зорилго хангагдах, хөтөлбөрийн ажилтнууд болон түншлэгчид асуулгын судалгааны үйл явц, үр дүнгийн өмчлөгч, эзэн байх боломжийг бүрдүүлнэ.

## Зөвлөмжийг хэрхэн ашиглах вэ?

Хүүхэд хамгааллын хөтөлбөрт МХД-ын асуулгын судалгааг хийх гол алхмуудыг кейс жишээ, практик зөвлөгөөний хамт энэхүү зөвлөмжид тусгасан болно.

**Зөвлөмжийн удиртгал хэсэгт МХД-ын асуулгын судалгааг хийх шийдвэр анхлан гаргахад анхаарах асуудлаас гадна хэрэгцээ, байгаа нөөцийг харгалзсаны үндсэн дээр мэдээлэл цуглуулах тохиромжтой арга мөн эсэхийг хэрхэн тодорхойлох талаар оруулав.**

Зөвлөмжийн үлдсэн хэсэг нь төлөвлөлт, дизайн, хэрэгжүүлэлт, дүн шинжилгээ, хэрэглээ, түгээлт гэсэн бүлгүүдэд хуваагдана. Үе шат тус бүр нь тухайн үе шатанд хийх үйл ажиллагаа, үр дүнгийн жагсаалтаар эхлэх бөгөөд тэдгээр үйл ажиллагаа тус бүрийг тайлбарласан. Зөвлөмжид анхаарах ёстой зүйл, зөвлөгөө, кейс жишээг шигтгээ болгон хайрцаглаж оруулав. Мөн МХД-ын асуулгын судалгааны үйл явцын ялгаатай үе шатуудад **хүүхдийн оролцоог хангах боломжуудыг** онцлон тэмдэглэсэн болно. Зөвлөмжийн төгсгөлд уг зөвлөмжид хэрэглэсэн **мэргэжлийн бүхий л нэр томьёог** тайлбарласан. Нэр томьёоны жагсаалтад байгаа мэргэжлийн нэр томьёог энэхүү зөвлөмжид анх удаа хэрэглэхдээ тод хараар тэмдэглэв. Судалгааны дизайн эсвэл мэдээлэлд дүн шинжилгээ хийхээр судлаачид, статистикчидтай хамтран ажиллах явцад гарах статистикийн олон нэр томьёог уг нэр томьёоны тайлбарт мөн оруулсан болно.

Зөвлөмжийг хэт нүсэр, хүнд биш байхаар боловсруулсан бөгөөд нэмэлт материал, эх сурвалж, арга хэрэгсэл болгон хэрэглэх зориулалт бүхий **нэмж судлах материалын** жагсаалтыг зөвлөмжид багтаасан. Зөвлөмжийн төгсгөл хэсэгт буй **хавсралтуудад** тухайн улс орны хөтөлбөрийн онцлогт тохируулан хэрэглэж болох загвар, хэрэгслийг орууллаа.

Судалгааг төлөвлөх, хэрэгжүүлэх алхмуудыг хийхээс өмнө энэхүү зөвлөмжийн удиртгал хэсэгтэй сайтар танилцахыг зөвлөж байна. **Үүний учир нь хэрэгцээ, байгаа нөөцөө бодолцсоны үндсэн дээр МХД-ын асуулгын судалгаа хэрэгжүүлж буй хөтөлбөрт тань үнэхээр тохиромжтой арга мөн байж чадах уу гэдгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт бүхий шалгах асуултууд энэхүү удиртгалын төгсгөлд буй.** Олон тохиолдолд МХД-ын асуулгын судалгааг тоон мэдээлэл цуглуулах хурдан хийгээд энгийн хувилбар хэмээн андуурдаг. Асуулгын судалгааны чанартай мэдээлэл цуглуулна гэдэг бол дизайн, төлөвлөлт, бэлтгэлийн шатуудад зарцуулах цаг хугацаа, хөрөнгө мөнгө, энерги, үр чадвараар хэмжигдэх хөрөнгө оруулалтыг шаарддаг зүйл. Нэн ялангуяа хүүхэд хамгаалал шиг тоон мэдээлэл хомс салбарт МХД-ын асуулгын судалгаа нь олон чухал үр дүнг илрүүлэх бөгөөд төслийн нөөцийг зохистойгоор хэрэглэх боломж олгодгоороо чухал.

## МХД-ын асуулгын судалгаа ба хүүхэд хамгаалал

МХД-ын асуулгын судалгааг нийгмийн эрүүл мэндийн салбарт, жишээ нь ДОХ-ын халдварын эрсдэлд хувь хүнийг оруулж болох итгэл үнэмшил, дадлын талаар мэдээлэл цуглуулах эсвэл хумхаагаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийн үр өгөөжийг дээшлүүлэх гэх мэт зорилгоор өргөн хэрэглэдэг бөгөөд уг судалгааны хэрэглээ бусад салбарт ч нэмэгдсээр байна. Хүүхэд хамгааллын хөтөлбөрт энэхүү МХД-ын асуулгын судалгаа нь дараах асуудлуудыг ойлгох, үнэлэхэд тустай байж болох юм:

**Мэдлэг** – Тодорхой сэдвийн талаарх хүүхдийн болон насанд хүрэгчдийн ойлголт, мэдлэгийн түвшин

Жишээ нь: хүүхдийн хамгаалуулах эрхийн асуудлууд, тэднийг хамгаалах хууль эрх зүй эсвэл бусад нөөцийн талаарх хүүхдүүд болон асран хамгаалагчдын ойлголтын түвшин; хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, шилжилт хөдөлгөөн, бие махбод, сэтгэл санааны хавсарсан шийтгэл, хүмүүжлийн бусад арга барилаас учирч болох эрсдэлүүдийн талаарх мэдлэг.

**Хандлага** – Тодорхой сэдэв, асуудлын талаар хүүхэд, насанд хүрэгчдийн үзэл бодол, тэрхүү үзэл бодолд нь нөлөөлж буй мэдлэг, итгэл үнэмшил

Жишээ нь: хүүхдүүдэд учирч буй тодорхой аюул заналын талаарх хүмүүсийн хандлага, хүүхдийг хүмүүжүүлэхийн тулд бие махбод, сэтгэл санааны хавсарсан шийтгэлийн арга хэрэглэх талаарх хүмүүсийн хандлага; хүүхдийг хэзээ хөдөлмөрлүүлэх нь зохимжтой эсэх талаарх итгэл үнэмшил; эрт гэрлэлтийг зөвшөөрөх эсвэл татгалзах байдал; эцэг эх нь үл хайхардаг эсвэл ХДХВ/ДОХ-ын халдвартай хүүхдүүдийг ялгаварлан гадуурхах хэвшмэл ойлголт, хандлага.

**Дадал** – Тодорхой сэдэв, асуудлын талаарх мэдлэг, хандлагаа үйлдэл болгон хэрэгжүүлэх арга зам

Жишээ нь: хүүхдээ зодож шийтгэх хүмүүжлийн арга хэрэглэдэг асран хамгаалагчид; хүүхдээ харгалзах хүнгүй, гэрт нь ганцааранг нь үлдээх дадал; эцэг эх нь хүүхдээ үл хайхран харьцах байдал; хүүхэд өвдсөн тохиолдолд туслалцаа хүсэх дадал, тийм бол хаанаас туслалцаа хүсэх байдал; бэлгийн зүй бус харьцаа, хүчирхийлэл гэх мэтийг мэдээлэх байдал.



Ихэнх МХД-ын асуулгын судалгаанд цуглуулсан мэдээллийг тоон утгын хувьд шинжлэх зориулалт бүхий стандартчилагдсан асуулга ашиглан ярилцлагыг хөтлөгч мэдээлэл цуглуулдаг.

## Хүүхэд хамгааллын салбарт МХД-ын асуулгын судалгааг яагаад хэрэглэх ёстой вэ?

Олон улс оронд байх нийтлэг итгэл үнэмшил, дадлаас хамааран хүүхэд гэртээ болон эргэн тойрны орчиндоо эрсдэлтэй тулгарч байдаг. Жишээ нь хүүхдийг хүмүүжүүлэх хамгийн үр дүнтэй арга нь зодож шийтгэх гэж нийтээрээ үзэх; ядуу эсвэл суурь хэрэгцээгээ хангаж чадахгүй өрхийн хүүхдүүдийг асрамжийн газарт байлгах нь хамгийн зөв хувилбар гэж тооцох гэх мэт. Иймэрхүү нөхцөлд хүүхэд хамгааллын хөтөлбөрийг үр өгөөжтэй хэрэгжүүлж гэвэл үйлчилгээнд анхаараад зогсохгүй зорилтот бүлгийн дунд эерэг хандлага, зохистой зан үйлийг дэмжих, мэдлэг нэмэгдүүлэхэд мөн чиглэх ёстой.


Тийм учраас хүүхэд хамгааллын олон хөтөлбөрт олон нийтийн гишүүд, асран хамгаалагчдын ойлголт, хандлага, дадлыг өөрчлөхөд чиглэсэн зорилго, үйл ажиллагаа багтдаг бөгөөд үүгээрээ хүүхдийн сайн сайхан байдал, хамгааллыг сайжруулахад хувь нэмэр оруулна гэж үздэг. Жишээлбэл төвлөрсөн асрамжийн үйлчилгээний эрсдэлийг арилгах зорилготой хөтөлбөр нь асрамж халамжийн өөр хувилбаруудыг бий болгохоос гадна төвлөрсөн асрамжийн үйлчилгээг илүүд үзэж байгаагийн шалтгааныг ойлгох, учирч болох эрсдэлүүдийн талаарх эцэг эхчүүдэд сургалт хийх, олон нийтэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй. Иймэрхүү үйл ажиллагааг сайтар төлөвлөх, үйл ажиллагаа нь үнэхээр үр өгөөжтэй байж чадах эсэхийг мэдэхийн тулд зорилтот бүлгийн мэдлэг, хандлага, дадлыг хэмжих, тодорхойлох хэрэгтэй болдог. МХД-ын асуулгын судалгаа нь ийм мэдээлэл цуглуулах нэг арга хэрэгсэл юм.

МХД-ын асуулгын судалгааны үр дүнг хүүхэд хамгааллын хөтөлбөрт дараах хэлбэрээр хэрэглэж болно:

- Хүүхэд хамгааллын механизмын үр өгөөжийг бууруулах эсвэл хүүхдийг эрсдэлд оруулж болох тодорхой итгэл үнэмшил, дадлын учир шалтгаан, тархалтыг ойлгох
- Хүүхэд хамгааллын тодорхой асуудлаар хүмүүс юу мэдэж байгаа, тэрхүү асуудлын талаар ямар бодолтой байгаа, энэ нь тэдний үйлдэлд хэрхэн нөлөөлж байгаа тухай мэдээлэл цуглуулах замаар хүүхдийн сайн сайхан байдлыг эрсдэлд оруулж болзошгүй эсвэл хамгаалж болох нийтлэг дадал, соёлын итгэл үнэмшил, мэдлэгийн зөрөөг тодорхойлох
- Мэдээлэл, харилцаа, боловсролын үйл ажиллагааны дизайн, төлөвлөлтийг дэмжих
- Нөлөөллийн үйл ажиллагаа явуулахын тулд нотолгоонд суурилсан мэдээллийг цуглуулах, олон нийт, бүлгүүдийг үйл ажиллагаанд татан оролцуулах
- Төслийн хэрэгжилтийн явцад болон төгсгөлд хөтөлбөрийн үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг үнэлэх

Иймэрхүү мэдээлэл нь хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа эрэмбэлэх, нөөцөө тооцоолж, хуваарилах, асуудал, түүний шийдлийг олох, ажлын чиглэлээ бэхжүүлэх, стратегийн шийдвэр гаргахад нь хөтөлбөрийн менежер болон ажилтнуудад тусалдаг.

### Зураг 1. Хүүхэд хамгааллын төслийн үр дүнгийн хүрээ: МХД-ын асуулгын судалгаа юуг тодруулах вэ?






## МХД-ын асуулгын судалгааг сонгох нь: Тохиромжтой арга мөн үү?

### МХД-ын судалгаа болон МХД-ын асуулгын судалгаа хоорондын ялгаа юу вэ?

“Асуулгын судалгаа”, “судалгаа” хэмээх нэр томъёог зарим тохиолдолд нэгийг нь нөгөөгөөр орлуулах байдлаар хэрэглэдэг боловч энэхүү зөвлөмжийг тодорхой болгох зорилгын үүднээс асуулгын судалгаа, судалгаа гэдгийг гэдгийг дараах байдлаар тодорхойлов:

**Асуулгын судалгаа** нь тодорхой цаг хугацааны хүрээнд хүн амын онцлог шинжийн тархалтыг хэмжихэд хэрэглэдэг тоон судалгааны арга юм. Тухайн зорилтот бүлгийн хүмүүсийн хандлага, итгэл үнэмшил, мэдлэг, зан үйлийг ойлгох, хэмжихэд МХД-ын асуулгын судалгааг голчлон хэрэглэдэг. Асуулгын судалгаа нь урьдчилан бэлтгэсэн асуултуудын хариултыг зорилтот бүлгийн хүмүүсээс ярилцлага эсвэл бичгэн хэлбэрээр авна. Зорилтот бүлгийн хүн бүрийг хамрах боломжгүй учраас асуулгын судалгааг ихэвчлэн тухайн тухайн бүлгийг статистикийн хувьд төлөөлж чадах түүврийг сонгох ба ингэснээр дараа нь асуулгын судалгааны үр дүнг нийт зорилтот бүлэгт тархаан хэрэглэх боломжтой болно.



Харин **судалгаа** гэдэг нь тухайн сэдвийн талаар мэдээлэл олж авах, уг сэдвийг иж бүрнээр дүрслэхийн тулд судалгааны хэд хэдэн ялгаатай аргыг хослуулан хэрэглэдэг өргөн хүрээтэй судалгаа, үнэлгээний ажил юм. Иймэрхүү судалгаанд судалж буй асуудал, байгаа нөөц болон мэдээлэл цуглуулах боломж зэргээс хамааран чанарын (фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага), оролцооны эсвэл тоон аргуудыг хэрэглэж болох юм. МХД-ын асуулгын судалгаа нь ганц аргад суурилсан бөгөөд МХД-ын судалгааны нэг бүрэлдэхүүн хэсэг хэмээн ойлгож болно.

МХД-ын судалгааг эхлүүлэхээс өмнө хамгийн тохиромжтой судалгааны дизайныг тодорхойлох хэрэгтэй. Эхний алхам нь мэдээллийн хэрэгцээ, түүнийг чухам юунд хэрэглэх гэж байгаагаар тогтооно. Хэрэв мэдээллийг хөтөлбөрийн үйл ажиллагааны санаа гаргах, төлөвлөх зорилгоор дотооддоо хэрэглэх гэж байгаа бол чанарын мэдээлэл илүү зохимжтой бөгөөд санхүүгийн хувьд ч хэмнэлттэй. Харин мэдээллийг нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах, нөөцийг хуваарилах эсвэл тодорхой сэдвийн талаар өргөн хүрээний баримт нотолгоо цуглуулахад хэрэглэх гэж байгаа бол тоон мэдээлэл илүү тохиромжтой. Өргөн түүврээр мэдээллийг цуглуулж болохоос гадна цуглуулсан мэдээлэл нь объектив хэмээн хүлээн зөвшөөрөгдөх нь илүүтэй учраас ийнхүү тоон мэдээллийг онцолдог.

**Энэхүү гарын авлага нь МХД-ын асуулгын судалгааг хийх зөвлөмжийг агуулна. Харин МХД-ын өргөн хүрээний судалгаа хийх зөвлөмжийг багтаагаагүйг анхаарна уу.**

МХД-ын асуулгын судалгаа нь нэг талаас тоон мэдээллийг харьцангуй хурдан хийгээд хялбар замаар цуглуулж болох ч нөгөө талаас хөрөнгө санхүү, цаг хугацаа, мэдлэг туршлага шаарддаг учраас хязгаарлагдмал нөөцийг хамгийн зохист хэмжээгээр зарцуулахын тулд энэхүү аргын давуу, сул талыг сайтар ойлгох нь чухал.



## Зураг 2. Судалгааны аргууд

### Тоон

Мэдээллийн объектив, хүчин төгөлдөр, үнэн зөв, алдаагүй байдлыг эрхэм болгодог.

- Асуулга: Оролцогчдыг төлөөлөх түүвэр бүлгээс тоон хэлбэрээр илэрхийлж болох мэдээллийг цуглуулах стандартчилагдсан асуултуудыг голчлон хэрэглэдэг.
- Сорил: Стандартчилагдсан ажиглалт эсвэл сорилыг үндэс болгон тоон мэдээлэл цуглуулдаг.
- Хоёрдогч мэдээллийн дүн шинжилгээ: Шинэ таамаглал эсвэл үр дүнг олохын тулд хоёрдогч буюу бэлэн байгаа мэдээллийг шинжилдэг.

### Чанарын

Ажиглалтын үнэ цэн, субъектив тайлбарын баялаг байдлыг онцолдог. Хязгаарлагдмал тооны ярилцлага эсвэл ажиглалтаас цуглуулсан мэдээллийг ашиглан тодорхой ухагдахууныг тайлбарладаг.

- Ажиглалт: Судалж буй бүлгийн гишүүдтэй ярилцалгүйгээр мэдээлэл цуглуулж, бичиж авдаг өргөн хүрээний үйл ажиллагаа юм. Тодорхой бүтэцтэй протокол, арга хэрэгслээр дамжуулан ажиглах бөгөөд стандарт маягт, тэмдэглэл, аудио, видео, фото болон зурмал зураг байдлаар мэдээлэл цуглуулдаг.
- Ярилцлага: Ярилцлагыг хөтлөгч болон ярилцлага өгч буй нэг эсвэл хэд хэдэн хүний хооронд явагддаг үйл ажиллагаа. Ярилцлагын зорилго нь судалж буй ухагдахууны талаар ярилцлага өгөгчийн үзэл бодлыг мэдэхэд оршдог.
- Фокус бүлэг: 8-12 хүнтэй бүлэгт чадварлаг чиглүүлэгчийн удирдлагаар явагдах хагас бүтэцчилэгдсэн ярилцлага, хэлэлцүүлэг. Тодорхой сэдвийн талаар тухайн бүлгийн бодол санааг таньж мэдэх зорилгоор мэдээлэл цуглуулна.
- Кейс судалгаа: Тодорхой хувь хүн эсвэл хам орчны талаарх нарийвчилсан судалгаа.

### Оролцооны

Үнэлгээнд оролцогчид болон үр шим хүртэгчдийг оролцуулахын чухлыг онцолдог.

- Санаагаа уралдуулахуй, үйл явцын зураглал, иргэний хяналт, хөндлөнгийн хяналт, аалзан дасгал, тэмдэглэл гэх мэт.

(Трохим, 2006)

Өөр төрлийн аргуудтай харьцуулахад МХД-ын асуулгын судалгааны гол давуу тал нь судалгааны үр дүнг хүн амын томруулсан бүлэгт **тархаан** хэрэглэж болдог. Түүнчлэн тоон мөн чанар бүхий үр дүн нь тодорхой шалгуур үзүүлэлтүүдийн цар хүрээ, далайц, тархалтыг тодруулах, цаг хугацааны давтамжаар тэдгээр шалгуур үзүүлэлтийг харьцуулах, мөн шалгуур үзүүлэлтүүдийн хоорондын харилцаа холбоонд дүн шинжилгээ хийх боломж бүрдүүлнэ.

Гэхдээ **цуглуулсан мэдээлэл найдвартай байх тохиолдолд л асуулгын судалгааны дээрх давуу тал үүснэ** гэдгийг мартаж болохгүй. Хэрэв асуулгын судалгааг тааруухан төлөвлөж гүйцэтгэн, чанаргүй мэдээлэл цуглуулбал тоон аргыг хэрэглэсний үр дүн үгүй болно гэсэн үг. Тийм учраас МХД-ын асуулгын судалгааг хийхээсээ өмнө цаг хугацаа, хөрөнгө мөнгө, мэдлэг туршлага гэх мэт нөөц хангалттай байгаа эсэхийг нягтлах, мөн асуулгын судалгааг сайтар төлөвлөн, мэдээллийн найдвартай байдал, чанарын баталгааг хангахуйцаар хийх ёстойг ойлгох хэрэгтэй.

Харин аливаа хөтөлбөрийн төгсгөлийн буюу эцсийн үнэлгээг хийхдээ холимог арга хэрэглэхийг Хүүхдийг Ивээх Сан зөвлөдөг. Хэд хэдэн аргыг хослуулан хэрэглэх, түүнээс гарсан үр дүнг хооронд нь харьцуулах, баталгаажуулан нэгтгэх нь судалгааны үр дүнгийн хүчин төгөлдөр байдлыг нэмэгдүүлдэг. Хэрэглэж болох аргуудыг сонгоход туслах зарим шалгуур үзүүлэлтийг зураг 3-т харууллаа.

### Зураг 3. Судалгааны аргуудыг сонгоход анхаарах зүйл

Мэдээллийн төрөл, үнэ цэн	Илтгэлцэл, шинжлэх ухааны шаардлага	Анхаарах зүйл
<ul style="list-style-type: none"> <li>Асуулга: Оролцогчдыг төлөөлөх түүвэр бүлгээс тоон хэлбэрээр илэрхийлж болох мэдээллийг цуглуулах стандартчилагдсан асуултуудыг голчлон хэрэглэдэг.</li> <li>Сорил: Стандартчилагдсан ажиглалт эсвэл сорилыг үндэс болгон тоон мэдээлэл цуглуулдаг.</li> <li>Хоёрдогч мэдээллийн дүн шинжилгээ: Шинэ таамаглал эсвэл үр дүнг олохын тулд хоёрдогч буюу бэлэн байгаа мэдээллийг шинжилдэг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Тоон аргууд нь стандартчилагдсан, сольж орлуулж болохуйц арга хэрэгслийг ашигладаг. Цугларсан мэдээлэлд статистикийн нарийн дүн шинжилгээ хийх боломжтой. Гэхдээ тоон аргуудаар цуглуулсан мэдээлэл нь дандаа объектив, найдвартай байна гэсэн үг биш.</li> <li>Судалгааны аргуудаас гадна мэдээллийн итгэлцэлд нөлөөлдөг олон хүчин зүйл байдаг. Тиймээс ямар аргыг эсвэл ямар аргуудыг хослуулан хэрэглэвэл илүү итгэж болох мэдээлэл цуглуулах вэ гэдгийг тогтооходоо судлах гэж буй зорилтот бүлгээ анхаарах ёстой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зардал</li> <li>Ажилтнуудын чадвар</li> <li>Цаг хугацаа</li> </ul>

(Шарп, Фрэктлинг, 1997)

Холимог арга бүхий судалгааны хувьд чухам ямар асуудлыг таньж мэдэх, ойлгох вэ гэдгээ тодорхойлохын тулд чанарын аргаар голдуу эхэлдэг. Дараа нь судалгаанд сонгосон хүн амын бүлэгт асуулгын судалгаа явуулах ба төгсгөлд нь асуулгын судалгаагаар илэрсэн зарим үр дүнг баталгаажуулах, үр дүнгийн тайлбаруудыг хүчин төгөлдөр болгох үүднээс нарийвчилсан буюу гүнзгийрүүлсэн ярилцлага хийдэг.

#### Асуулгын судалгааны аргын хязгаарлал: МХД-ын асуулгын судалгаагаар юу тодруулж болохгүй вэ?

Сайн асуулгын судалгаа хийхэд цаг хугацаа, үр чадвар, хөрөнгө мөнгө нэлээд хэмжээгээр шаардагддаг бөгөөд хөтөлбөрийн энэхүү үнэт нөөцийг МХД-ын асуулгын судалгаанд зарцуулах эсэхийг сайтар тодорхойлох хэрэгтэй. Үүний тулд МХД-ын асуулгын судалгааны хязгаарлал болон энэхүү хязгаарлалыг арилгахын тулд өөр ямар нэмэлт аргаар мэдээлэл цуглуулж болохыг мэдэж байх нь чухал. Асуулгын судалгааны аргыг хэрэглэхийн хязгаарлал болон хүндрэл бэрхшээлийг дор дүрслэн харуулав:

- Мэдлэг, хандлага, зан үйл нь нарийн төвөгтэй, цогц зүйл тул асуулгын судалгааны асуултууд нь тэдгээрийн цаад мөн чанарыг илрүүлэхдээ тааруу.** МХД-ын асуулгын судалгаанд тоологдохуйц мэдээллийг цуглуулахын тулд стандартчилагдсан, дээр зэргээр бүтэцчилэгдсэн асуултуудыг голдуу хэрэглэдэг. Гэвч хүүхэд хамгааллын талаарх хүмүүсийн мэдлэг, хандлага, дадал нь нарийн төвөгтэй, цогц зүйл. Эдгээрт нөлөөлж, харилцан үйлчлэлцэж байдаг маш олон хүчин зүйлийг асуулгын арга дангаараа илрүүлж чадахгүй. Асуулгын судалгаанд хэрэглэж буй асуултуудын хариултуудын хувилбарууд ихэнхдээ өгөгдсөн байх (дүн шинжилгээ хийхэд амар байх үүднээс) тул тэдгээр хариултын хувилбараас өөр, шинэ эсвэл урьдчилан таамаглаагүй хариултын хувилбарууд тэмдэглэгдэлгүй үлддэг. Жишээ нь эрт гэрлэлт гэх мэт асуудлын дадлын хүрээ, хэмжээг асуулгын судалгаагаар үнэлж болох боловч хүүхдүүд яагаад насанд хүрэхээс өмнө гэрлэдгийн “шалтгаан” болон энэхүү дадлыг өөрчилж болох шийдлүүдийг тодруулахад сайн арга байж тэр бүр чаддаггүй. Ийм мэдээллийг чанарын аргуудаар цуглуулна.
- МХД-ын асуулгын судалгаа нь шалтгаан, үр дагаврын хамаарлыг харуулж чаддаггүй.** Шалтгаан, үр дагавар гэдэг нь тодорхой үзэгдэл, хувьсагч (жишээ

нь хөтөлбөр дэх оролцоо, боловсролын түвшин, итгэл үнэмшил гэх мэт) нь аливаа нэг үр дүн, нөлөөлөл (зан үйл гэх мэт)-ийн учир шалтгаан байж болохыг батлахыг хэлж байгаа юм. МХД-ын асуулгын судалгаа нь хоёр хувьсагчийн хоорондын харилцаа холбоог харуулж чадах ч дээр дурдсан шалтгаан, үр дагаврын хамаарлыг баталж чаддаггүй. Тодруулбал МХД-ын асуулгын судалгаа нь хувь хүн тодорхой зан үйлийг яагаад үзүүлж буйн цаад логик механизмыг тайлбарладаггүй. Тиймээс МХД-ын асуулгын судалгааны үр дүнг өөр мэдээллийн эх сурвалжтай хослуулах замаар шалтгаан, үр дагаврын харилцан хамаарлыг ойлгож болно (Лауниала, 2009).

- **Хүүхэд хамгааллын салбарт хэрэглэж болох баталгаажсан стандарт асуулга ховор.** Эрүүл мэнд, боловсрол гэх мэт хөгжлийн бусад салбартай харьцуулахад хүүхэд хамгаалал нь харьцангуй шинэ учраас энэ салбарын үйл ажиллагаанд судалгааны тоон аргуудын хэрэглээ хязгаарлагдмал байсаар байна. Үүнээс үүдэн системтэйгээр туршиж, сайжруулсан, хүчин төгөлдөр, хүүхэд хамгаалалд тохирсон стандартчилсан асуулга (асуултууд)-ууд ховор<sup>1</sup>. Асуулга боловсруулах нь төсөөлснөөс илүү төвөгтэй, цаг хугацаа шаарддаг зүйл бөгөөд асуултын агуулга, түүнийг илэрхийлсэн үг хэллэгийг судлуулагчид яг ижил байдлаар хүлээн авч, ойлгохоор томьёолж, түрших ёстой. Нэн ялангуяа “эрсдэл” гэх мэт нэр томьёо нь хоёрдмол утгатай тул түүнийг судлуулагч болон мэдээллийг цуглуулж буй хүмүүс өөр өөрөөр ойлгож болно. Асуулгын судалгааны асуултуудыг сайтар боловсруулж, шалгахгүй бол цугларсан мэдээлэл үнэгүйднэ гэсэн үг.
- **Мэдлэг, хандлага, дадалд өөрчлөлт алгуур гардаг, энэхүү өөрчлөлтийг төслийн хэрэгжилтийн хугацаанд асуулгын судалгаагаар илрүүлэх боломжгүй байх талтай.** Бие махбодын болон сэтгэл санааны шийтгэлтэй холбоотой эцэг эх, олон нийтийн хандлага, зан үйл гэх мэтийн өөрчлөлтийг МХД-ын асуулгын судалгаагаар илрүүлбэ гэвэл нэлээд хэдэн жил шаардлагатай болно. Хэмжиж болохуйц өөрчлөлт гарах хугацаа нь зарим тохиолдолд 5-10 жил, үүнээс ч урт байх нь бий. Тиймээс хоёр эсвэл гурван жилийн хугацаатай төсөл хэрэгжүүлж байгаа тохиолдолд МХД-ын судалгаа хийгээд ч өөрчлөлт илрэхгүй байж болно. Харин ахиц дэвшлийг хэмжих чанарын аргууд энэ тохиолдолд илүү тохиромжтой.

## МХД-ын асуулгын судалгааг хэзээ хийх вэ?

Мэдээлэл цуглуулах бусад аргатай адилаар МХД-ын асуулгын судалгааг хийх цаг хугацаа нь мэдээллийн хэрэгцээ, түүнийг юунд хэрэглэхээр төлөвлөснөөс хамаарна. Хэрэв төслийн үндсэн төлөвлөлт, үйл ажиллагаа эхлэхээс өмнө буюу төслийн эхэн үед асуулгын судалгаа хийж буй бол түүний үр дүнг төслийн үйл ажиллагаа, арга, аргачлалыг илүү сайжруулах, нөөцийн хуваарилалтыг зохицуулах, гол шалгуур үзүүлэлтүүдийг хянах суурийг тогтоох гэх мэтэд хэрэглэж болно. Хэдий энэхүү асуулгын судалгаа нь төлөвлөсний дагуу амжилттай явагдлаа ч судалгааны эцсийн тайлан энэхүү судалгааг төлөвлөж эхэлснээс дор хаяж гурван сарын дараа бэлэн болно гэдгийг мартаж болохгүй.

Асуулгын судалгааг хэзээ хийх вэ гэдэг нь тэрхүү судалгааны үр дүнг ямар нэг нөлөөллийн үйл ажиллагааг дэмжихэд хэрэглэх гэж байгаа эсэхээс мөн хамаарна. Хэрэв ялгаатай цаг хугацаанд төслийн шалгуур үзүүлэлтүүдийг

<sup>1</sup> Хүүхэд хамгааллын сэдвүүдийн хүрээнд шалгагдаж, хүчин төгөлдөр болсон стандарт асуултуудын жишээг Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа ([http://www.unicef.org/statistics/index\\_24302.html](http://www.unicef.org/statistics/index_24302.html))-аас харж болно.



харьцуулах зорилгоор төслийн дунд хугацаанд эсвэл төгсгөлд асуулгын судалгаа хийхээр бол өөрчлөлт гарахад хангалттай хугацаа өнгөрсөн эсэхийг тооцохоо мартуузай. Хандлага, дадалд өөрчлөлт удаан гардаг, харин төсөл харьцангуй богино хугацаанд хэрэгждэг.

**Хоёр жилээс бага хугацаанд хэрэгжсэн төслийн үр дүнг үнэлэх гэж буй бол МХД-ын асуулгын судалгаа нь өөрчлөлтийг илрүүлж чадахгүй байж болно. Тийм учраас богино хугацааны төслийн үр дүнг үнэлэхдээ өөр арга хэрэглэхийг зөвлөж байна. МХД-ын судалгаа нь онцгой нөхцөлд бараг тохиромжгүйг мартаж болохгүй.**

## Гол алхмууд

Орон нутагт очиж, хүмүүсээс ярилцлага авах нь МХД-ын асуулгын судалгааны хүрээнд хийх олон ажлын зөвхөн нэг л үйл ажиллагаа бөгөөд олон сарын бэлтгэл ажил шаардана. Учир нь мэдлэг, хандлага нь нийгэм, улс төр, соёлын орчноос ангид, тусгай зүйл бөгөөд МХД-ын асуулгын судалгааг төлөвлөх, түүнд хэрэглэх арга хэрэгслийг боловсруулахад маш их цаг хугацаа, хүчин чармайлт хэрэгтэй, тэгж гэмээн орон нутгийн нөхцөлд тохиромжтой болж чадна.

### Бэлтгэл

**АЛХАМ 1: Асуулгын судалгааны зорилгыг тодорхойлох.** Баримт бичгийн дүн шинжилгээ нь гол судлах асуудлууд, судалгааны асуултууд, түүвэр бүлгийг тодорхойлоход тусална. Үүнийг тодорхойлохдоо хөтөлбөрийн ажилтнууд, Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн Сан, орон нутгийн ТББ-ууд, иргэд, олон нийт гэх мэт олон талын оролцоог хангасан системтэй үйл явц талаас нь хандахыг зөвлөж байна.

**АЛХАМ 2: Асуулгын судалгааны протокол боловсруулах.** Протокол бол асуулгын судалгааны суурь баримт бичиг бөгөөд үүнд асуулгын судалгааны зорилго, түүврийн хүрээ, ажлын төлөвлөгөө, чанарын баталгаа, мэдээлэлд дүн шинжилгээ хийх төлөвлөгөө, ёс зүйн асуудлууд, хүүхэд хамгааллын асуудлууд, төсөв, төлөвлөгөө багтана. Протокол нь асуулгын судалгааг хэрхэн явуулах, цуглуулсан мэдээлэлд хэрхэн дүн шинжилгээ хийхийг тодорхой мөртлөө дэлгэрэнгүй дүрсэлсэн удирдамж бөгөөд үүнийг түншлэгчид болон хяналтын хороонд хүргүүлж болно.

**АЛХАМ 3: Асуулга боловсруулах.** Сайн асуулгыг бичиг баримтын нарийн дүн шинжилгээнээс гадна судалгааны зорилтот хүн ам, тэднээс авсан чанарын мэдээлэлд суурилан боловсруулдаг. Асуулга нь хүчин төгөлдөр мэдээлэл цуглуулах хэрэгсэл болж чадсан эсэхийг баталгаажуулахын тулд заавал туршиж, сайжруулах ёстой. Үүний дүнд мэдээлэл цуглуулагчдад болон судлуулагчдын аль алинд нь асуултууд нь ойлгомжтой болно гэсэн үг. Олон тохиолдолд чанарын арга бүхий урьдчилсан судалгаа хийсний дараа асуулгыг боловсруулдаг.

### Хэрэгжилт

**АЛХАМ 4: Асуулгын судалгааны мэдээлэл цуглуулах.** Асуулгын судалгааны мэдээлэл цуглуулах ажил нь судалгааны багийн гишүүдийг бүрдүүлэх, сургахаас эхэлнэ. Энэ шатны үйл ажиллагаа нь маш сайн удирдлага, зохион байгуулалтыг шаарддаг. Мэдээлэл цуглуулах явцын өдөр тутмын тайлан, хяналт, шалгалт хийх замаар мэдээллийн чанарын баталгааг системтэйгээр хангах ёстой.

**Хэрэгжилтийн дараах үйл ажиллагаа** (дүн шинжилгээ хийх, тайлан бичих, үр дүнг түгээх, хэрэглэх)

**АЛХАМ 5: Цуглуулсан мэдээллийг программд оруулах, цэвэрлэх, дүн шинжилгээ хийх.** Энэ шатанд үр дүнгүүдийг тайлбарлах ажил ч мөн хийгдэнэ. Мөн энэ шат



нь цуглуулсан мэдээлээ үр шим хүртэгчид, түншлэгчдэдээ ойлгуулах, цаашид авах арга хэмжээг тэдэнтэй хамтран тодорхойлох боломж олгоно.

**АЛХАМ 6: Тайлагнах, үр дүнг ашиглах.** МХД-ын асуулгын судалгааны үр дүнг бусдад ойлгомжтойгоор хүргэхийн тулд зорилтот бүлэг болон хэрэглэгчдэд тохирсон хэллэг, хэлбэрт оруулах ёстой. Асуулгын судалгааны үр дүнг үйл ажиллагааны төлөвлөгөө, материал болгон хөрвүүлэхэд хөтөлбөрийн ажилтнууд оролцох нь зүйтэй. Асуулгын судалгааны үр дүнг үндэсний, бүсийн, орон нутгийн хэмжээний уулзалт, хурал хэлбэрээр түгээж болох бөгөөд зорилтот бүлгүүдэд зориулсан товч мэдээлэл, тайлан, өгүүлэл, илтгэл гэх мэт ялгаатай бүтээгдэхүүнийг бэлтгэвэл зохино.

## Нөөцөө тооцох нь

МХД-ын асуулгын судалгаа хийхэд шаардлагатай цаг хугацаа болон бусад нөөц нь асуулгын судалгааны хамрах хүрээ, далайцаас шууд хамаарна. Тодруулбал том сэдвийг хамарсан, өргөн түүвэртэй асуулгын судалгааг хийхэд илүү их нөөц хэрэг болно гэсэн үг.

	Либерти	Сиера Лион
<b>Асуулгын судалгааны зорилго</b>	<p>Хүүхдийг Ивээх Сангийн хөтөлбөр хэрэгждэг орон нутагт эцэг эхийн асрамж халамжгүй хүүхдүүдийг хамгаалах асуудалтай холбоотой мэдлэг, хандлага, дадлын суурь үзүүлэлтийг тогтоох</p> <p>Зорилтот орон нутагт амьдардаг эмзэг бүлгийн хүүхдүүдэд зориулсан нөөц, хүүхдийн эрхийн зөрчлийг үүсгэж буй хүчин зүйл, урьдчилан сэргийлэх болон хариу үйлчилгээний хүртээмж, тэрхүү үйлчилгээг авах хүсэл сонирхол зэргийг тодорхойлох</p>	<p>Хүүхдийг Ивээх Сангийн хөтөлбөр хэрэгждэг орон нутгуудад өсвөр насны охидын жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх төслийн хяналт, үнэлгээний суурь үзүүлэлтэд хэрэглэх мэдээлэл цуглуулах</p> <p>Зан үйлийг өөрчлөх арга хэмжээний стратеги гаргах, хүүхдийг хамгаалах олон нийтийн чадавхыг сайжруулах арга хэмжээг тодорхойлох зорилгоор жендэр, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх хүүхэд болон үүрэг хүлээгчдийн мэдлэг, хандлага, дадлыг илрүүлэх</p>
<b>Хэр хугацаа шаардагдсан бэ?</b>	<p>Нийтдээ таван сар гаруй хугацаа зарцуулсан. Эхний гурван сар нь үндсэндээ бэлтгэл ажилд зарцуулагдсан бөгөөд энэ хүрээнд урьдчилсан судалгаа (фокус бүлэг болон ярилцлага) хийж, асуулгын судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгслийг боловсруулах, турших, эцэслэх зэрэг ажлыг хийсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>→ 1,160 эцэг эх, асран хамгаалагч, 387 хүүхдийг хамруулсан түүврээс мэдээлэл цуглуулах ажилд дөрвөн долоо хоногийг зарцуулсан.</li> <li>→ Мэдээллийг программд оруулах, цэвэрлэх, дүн шинжилгээ хийх, тайлан бичих ажилд найман долоо хоногийг зарцуулсан.</li> </ul>	<p>Асуулгын судалгааг ойролцоогоор хоёр сарын хугацаанд хийсэн:</p> <ul style="list-style-type: none"> <li>→ Асуулгыг боловсруулж, эцэслэхэд хоёр долоо хоног</li> <li>→ 420 насанд хүрэгч, 420 хүүхдийг хамруулсан түүврээс мэдээлэл цуглуулахад хоёр долоо хоног зарцуулсан.</li> <li>→ Мэдээллийг программд оруулах, цэвэрлэх, дүн шинжилгээ хийхэд хоёр долоо хоног болсон.</li> </ul>
<b>Асуулгын судалгааны багт хэн хэн багтсан бэ?</b>	<ul style="list-style-type: none"> <li>→ Асуулгын судалгааны менежер 1 хүн (олон улсын зөвлөх)</li> <li>→ Мэдээлэл цуглуулах багийн ахлагч 3 хүн</li> <li>→ 9 судлаач</li> <li>→ Мэдээллийг программд оруулах 2 хүн</li> </ul> <p>Хүүхдийг Ивээх Сангийн ажилтнууд асуулгын судалгааны багийн бараг тэн хагасыг бүрдүүлсэн.</p> <p>Асуулгын судалгааны баг нь “Зөвлөх хороо” хэмээх тусгай бүлгээр дамжуулан түншлэгчидтэй холбоотой байсан.</p>	<ul style="list-style-type: none"> <li>→ Асуулгын судалгааны менежер 1 хүн (Хүүхдийг Ивээх Сангийн ОУ-ын эвслийн Онцгой нөхцөл дэх хүүхэд хамгааллын ажилтан судалгаанд туслахаар 7 долоо хоногийн хугацаатай томилогдсон)</li> <li>→ Арга зүйн дэмжлэг авах зорилгоор 3 долоо хоногийн хугацаатай авсан дотоодын зөвлөх 1 хүн</li> <li>→ Хүүхэд хамгааллын багаас асуулгын судалгаанд 7 долоо хоногийн хугацаанд туслахаар томилогдсон мэдээлэл цуглуулах багийн ахлагч 2 хүн</li> <li>→ Гаднаас хөлсөлсөн 12 судлаач</li> <li>→ Мэдээллийг программд оруулах, гаднаас хөлсөлсөн 8 ажилтан</li> </ul>



<b>Мэдээллийг хэрхэн хэрэглэсэн бэ?</b>	<ul style="list-style-type: none"> <li>→ Нийслэл болон төсөл хэрэгжиж буй 6 орон нутаг, нийтдээ 7 удаагийн уулзалт-хурлыг холбогдох гол хүмүүсийг оролцуулан зохион байгуулж, судалгааны тайланг танилцуулан, түгээсэн.</li> <li>→ Нөлөөллийн бичиг баримт боловсруулж, Засгийн газар болон НҮБ-ын түншлэгчдийн хамтарсан өндөр хэмжээний уулзалтад танилцуулсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>→ Төсөл хэрэгжиж буй бүх орон нутагт уулзалт-хурал хийсэн.</li> <li>→ Асуулгын судалгааны үр дүнг хөтөлбөр төлөвлөхөд суурь болгон ашигласнаас гадна дараагийн судалгаануудын эх сурвалж болгон хэрэглэсэн.</li> </ul>
	<p>→ 40,000 ам.доллар</p> <p>Төслийн төсөв нь 4 сая ам.долларын төсөвтэй. Үүнээс асуулгын судалгааны төсөв нь 21,600 ам.доллар бөгөөд үүнд тээвэр, томилолтын зардал багтаагүй. Олон улсын зөвлөхийг асуулгын судалгааны ажлыг ахлуулахаар 5 сарын хугацаанд 60 өдрөөр хөлсөлсөн.</p>	<p>→ 25,717 ам.доллар</p> <p>18 сарын хугацаатай төсөл нийтдээ 200,000 ам.долларын өртөгтэй. Дотоодын зөвлөхийг гурван сараар хөлсөлсөн. Хүүхдийг Ивээх Сангийн ОУ-ын эвслийн Онцгой нөхцөл дэх хүүхэд хамгааллын ажилтан 7 долоо хоногийн хугацаатай ажилласан.</p>

**Төсөв** – Асуулгын судалгаанд зарцуулах төсөв нь түүнийг хаана хийж байгаагаас хамааран ялгаатай байх боловч хөтөлбөр, төслийн нийт төсвийн хүрээнд асуулгын судалгааг явуулж болох эсэхийг урьдчилан тооцох боломжтой. МХД-ын асуулгын судалгаа хийхэд багцаагаар хамгийн багадаа нь 15,000-25,000 ам.доллар шаардагдана. Асуулгын судалгааны цар хүрээ, далайцаас хамааран 50,000-75,000 ам.доллар ч байж болно. МХД-ын асуулгын судалгааг төслийн суурь болон төгсгөлийн үнэлгээнд зориулж хоёр удаа хийх гэж байгаа бол төсөл, хөтөлбөрийн нийт төсөвт хоёр удаагийн асуулгын судалгааны зардлыг тусгах хэрэгтэйгээ санаарай. Төсвийн тооцоолол гаргах энгийн загварыг энэхүү зөвлөмжийн **Хавсралт Б**-ээс үзээрэй.

**Хүний нөөц** – Асуулгын судалгаанд хамгийн багадаа дараах хүний нөөц хэрэгтэй болдог:

- Асуулгын судалгааны менежер – Асуулгын судалгааг эхнээс нь аваад төгсгөл хүртэл хариуцан зохицуулах хүн
- Мэдээлэл цуглуулах багийн ахлагчид – Мэдээлэл цуглуулах багийн үйл ажиллагааг хариуцах, цугларч буй мэдээллийн чанарт хяналт тавих
- Мэдээлэл цуглуулагчид – Зорилтот хүн амаас мэдээллийг цуглуулах
- Мэдээллийг шалгах, программд оруулах ажилтнууд – Мэдээлэл цуглуулах явцад болон мэдээлэл цуглуулж дуусмагц мэдээллийг программд оруулах, хяналт, шалгалт хийх
- Хөтөлбөрийн ажилтнууд – Төлөвлөгөө, боловсруулалт, мэдээллийн дүн шинжилгээнд оролцох, асуулгын судалгааны мэдээллийн багийн ахлагч эсвэл мэдээлэл цуглуулагчаар ажиллах
- Захиргаа, санхүү, ложистикийн ажилтнууд – Асуулгын судалгаа явуулахад хэрэгтэй бүхий л зохион байгуулалт, санхүү, ложистикийн асуудлуудыг хариуцах бөгөөд асуулгын судалгааны багийн нэг хэсэг болох

Асуулгын судалгааны багийн гишүүдийн үүргийн талаар Алхам 5-д дэлгэрүүлэн дурдах болно.

**Цаг хугацаа** – МХД-ын асуулгын судалгаа нь уг судалгааны протоколыг боловсруулахаас эхлээд тайлан бичиж дуусах хүртэл нийтдээ 3-6 сар шаардаж болно. Мэдээлэл цуглуулахад цаг хугацаа их шаардагдахгүй боловч асуулгын судалгааны протокол боловсруулах, мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг боловсруулах, шалган турших, сайжруулах, багийн гишүүдийг сургах гэх мэт бэлтгэл ажилд цаг хугацаа нэлээд шаардлагатай. Хэрэв гаднын зөвлөх ажиллуулах гэж байгаа бол тухайн хүнийг шалгаруулан авах цаг хугацааг ч бодолцох ёстойгоо мартуузай.

**Мэдлэг туршлага** – МХД-ын асуулгын судалгааг мэргэжлийн түвшинд, өндөр чанартай хийхийн тулд судалгааны арга зүй эзэмшсэн, энэ чиглэлийн ажиллаж байсан туршлагатай мэргэжлийн хүнээр судалгааг удирдуулах нь нэн чухал. Уг хүн мэдээллийн хүчин төгөлдөр байдал, чанарт учирч болох эрсдэлийг хэрхэн бууруулахыг мэддэг, тоон судалгааны чиглэлээр туршлагатай байх ёстой. Ийм шаардлага хангасан хүн байгууллагад байхгүй бол их сургууль, судалгааны эсвэл зөвлөх байгууллагаас мэргэжлийн хүн эсвэл хувь судлаачийг урьж ажиллуулж болно. Ийм экспертээр хийлгэх ажлын даалгаврын загварыг энэхүү зөвлөмжийн **Хавсралт В**-д тусгав. Түүнчлэн Хүүхдийг Ивээх Сангийн “Үнэлгээний гарын авлага” –д буй гаднын зөвлөх шалгаруулан авах зөвлөмжийг үзэхийг санал болгоё.

Хүүхэд хамгаалалд МХД-ын асуулгын судалгааг хийхээс өмнө **хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан зөвлөхөөс мэргэжлийн зөвлөгөө авах** нь нэн чухал болохыг сануулж байна. Ажлын цар хүрээ, төслийн грантаас хамааран дараах хүмүүстэй холбогдох хэрэгтэй:

- Хүүхдийн Ивээх Сангийн гишүүн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан зөвлөхүүд
- Хүүхэд хамгааллын санаачилгын хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хэсэг ([cpi.me@rb.se](mailto:cpi.me@rb.se))
- Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний бүсийн зөвлөх

## Дүгнэлт, шалгалт

**Заавал хийх зүйл:** МХД-ын асуулгын судалгааг хийхээс өмнө дараах шалгах асуултуудад хариулаарай. Асуулгын судалгаагаа эхлүүлэхээсээ өмнө бүх асуултад “ТИЙМ” гэж хариулсан байх ёстой.

**Таны хэрэгжүүлж буй хүүхэд хамгааллын хөтөлбөрт МХД-ын асуулгын судалгааг хийх нь тохиромжтой юу? Судалгааг эхлүүлэхээс өмнө дараах шалгах асуултуудад хариулаарай.**

- Хөтөлбөр хэрэгжиж буй газарт хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлаарх мэдлэг, хандлага, дадлын мэдээллийн хэрэгцээ, гол бүлгийг тодорхой гаргасан уу? Мэдээллийг хэн, хэрхэн ашиглах талаар мэдэж байгаа юу?
- Мэдээлэлд тавих шинжлэх ухааны шалгуур, итгэлцлийн талаар гол хүмүүстэй ярилцсан уу?
- Хэрэглэж эсвэл дахин дүн шинжилгээ хийж болох хоёрдогч мэдээлэл байгаа эсэхийг нягталсан уу? Асуулгын судалгааны зорилтот хүн амыг хамруулан хийсэн саяхны ижил төстэй судалгаа байхгүй гэдэгт итгэлтэй байна уу?
- Шаардлагатай мэдээллийг цуглуулахад ашиглаж болох төрөл бүрийн аргуудыг судалж үзсэн үү?
- Төрөл бүрийн аргуудыг судалж үзсэн бол чухам яагаад тоон мэдээлэл хэрэгтэй болов гэдгийг тайлбарлаж чадах уу?
- Асуулгын судалгааг хийхэд шаардагдах санхүүжилт хангалттай бий юу?
- Асуулгын судалгааг хийхэд хангалттай хугацаа бий юу?
- МХД-ын асуулгын судалгааг төлөвлөх, гүйцэтгэх мэргэжлийн мэдлэг, туршлага байгууллагад бий юу? Үгүй бол МХД-ын асуулгын судалгааг удирдан явуулах гаднын зөвлөхийг олсон үү?
- 3–6 сарын хугацаанд асуулгын судалгааны менежерээр ажиллах боломжтой асуулгын судалгааны төлөвлөлт, хэрэгжилтийн чиглэлээр мэргэшсэн хүн ажилтнуудын дунд бий юу?
- Асуулгын судалгааг хийхэд дэмжлэг үзүүлэх боломжтой орон нутгийн болон үндэсний хэмжээний түншлэгчид бий юу?
- Үнэлгээнд хэрэглэх төслийн суурь мэдээлэл бүрдүүлэхээр асуулгын судалгаа хийх гэж байгаа бол төгсгөлийн судалгаа хийх төсөв бий юу?

**Эдгээр асуултад бүгдэд нь “ТИЙМ” гэж хариулсан бол дараагийн бүлэгт буй МХД-ын асуулгын судалгааг төлөвлөх хэсгийг эхлүүлж болно.**

# АЛХАМ 1: Асуулгын судалгааны зорилгыг тодорхойлох нь

## Үйл ажиллагаа

- 1.1. Хоёрдогч мэдээлэл (баримт бичиг)-ийг судлах
- 1.2. Асуулгын судалгааны зорилго, зорилтуудыг тодорхойлох
- 1.3. Судлах асуудлуудыг тогтоох
- 1.4. Судалгааны гол асуултуудыг тодорхойлох
- 1.5. Асуулгын судалгааны зорилтот хүн амыг тогтоох
- 1.6. Түүврийн төлөвлөгөө гаргах

## Үр дүн

- ✓ Хоёрдогч мэдээллийн шинжилгээ
- ✓ Асуулгын судалгааны ажлын даалгавар
- ✓ Асуулгын судалгааны менежментийн болон мэргэжлийн удирдлагыг харуулсан бүтэц (жишээ нь асуулгын судалгааны менежментийн баг, зөвлөх хороо гэх мэт)
- ✓ Асуулгын судалгаа хийхэд хэрэгтэй мэргэжлийн зөвлөгөө өгөх гаднын мэргэжилтэн





# АЛХАМ 1: Асуулгын судалгааны зорилгыг тодорхойлох нь

Асуулгын судалгааны хамгийн чухал эхлэлийн цэг бол асуулгын судалгааны гол зорилго, зорилтуудыг тодорхой гаргах, үр дүнг хэрхэн ашиглах талаарх төлөвлөгөөг хийх явдал юм. МХД-ын асуулгын судалгааг яагаад хийх хэрэгтэйг тодорхойлохдоо хэрэгжүүлж буй хөтөлбөрт ямар мэдээлэл шаардлагатай байгаа, мэдээллийг хэрхэн ашиглах талаар урьдчилан гаргасан байх ёстой.

Зөвлөмжийн энэхүү бүлэгт хүүхэд хамгааллын тодорхой шалгуур үзүүлэлтүүд, хэрэгжүүлж буй төслийн логик хүрээг асуулгын судалгаатай уялдуулахад анхаарсан байдлаар асуулгын судалгааны зорилгыг улам тодорхой болгоход чиглэсэн зөвлөгөөг багтаалаа.



## 1.1. Хоёрдогч мэдээллийг судлах

Хоёрдогч мэдээлэл буюу хүүхэд хамгааллын асуудлаар өмнө хийгдсэн судалгаа, баримт бичгүүдтэй нарийн танилцсанаар энэ чиглэлээр мэдэгдэж байгаа зүйл, цаашид мэдэх ёстой зүйл тодорхой болох бөгөөд үүгээрээ байгаа мэдээллийг давтан цуглуулахаас сэргийлнэ.

Тухайн улс орны хүүхэд хамгааллын асуудлыг ойлгохын тулд эхлээд аль болох сүүлийн үеийн хийгээд үндэсний хэмжээний бэлэн байгаа судалгаануудтай танилцах нь зүйтэй. Үүнд дараах судалгааг оруулж болно:

- **Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа** – НҮБ-ын Хүүхдийн Сангийн санаачилга, дэмжлэгээр явагддаг энэхүү үндэсний асуулгын судалгаа нь бие махбод, сэтгэл санааны шийтгэл, хүүхдийн хөдөлмөр, эрт гэрлэлт, эмэгтэй хүүхдийн бэлэг эрхтнийг эрэмдэглэх гэх мэтийг багтаасан хүүхэдтэй хамааралтай өргөн хэмжээний мэдээлэл цуглуулдаг. Мэдээллийн холбоос: [http://www.unicef.org/statistics/index\\_24302.html](http://www.unicef.org/statistics/index_24302.html)
- **ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын судалгаанууд** – Хүүхдийн хөдөлмөрийн төрөл, тархалтын талаарх үндэсний хийгээд бүсийн хэмжээний судалгаануудыг ОУ-ын Хөдөлмөрийн байгууллага гаргадаг. Мэдээллийн холбоос: <http://www.ilo.org/ipecc/ChildlabourstatisticsSIMPOC/Questionnairesurveysandreports/lang--en/index.htm>
- **Хүн ам зүй, эрүүл мэндийн судалгаа** – Хүн ам зүй, эрүүл мэндийн судалгаа нь хоёр эсвэл таван жил тутам бүх улсад явагддаг бөгөөд гэр бүлийн хэлбэр, асрамж хамгааллын асуудлууд, гэр бүлийн хүчирхийлэл, эрт гэрлэлт, өсвөр



насны охидын жирэмслэлт болон хүүхэд хамгаалалтай холбоотой бусад сэдвээр мэдээлэл цуглуулдаг. Мэдээллийн холбоос: <http://www.measuredhs.com/>

- **ХДХВ/ДОХ-ын үзүүлэлтийн судалгаа** – ХДХВ/ДОХ-ын үзүүлэлттэй холбоотой судалгааг маш олон орон тогтмол цуглуулдаг. Гэр бүлийн хэлбэр, хагас болон бүтэн өнчин хүүхдийн тоо, уг өвчний халдвартай хүүхдүүдэд үзүүлэх суурь үйлчилгээний хүртээмж зэрэг хүүхэд хамгаалалтай холбоотой мэдээллүүд энэ судалгааны хүрээнд цуглардаг. Мэдээллийн холбоос: <http://www.measuredhs.com/What-We-Do/Survey-Types/AIS.cfm>

Дараа нь хөтөлбөрийг хэрэгжүүлж буй орон нутагт, хийх гэж буй асуулга судалгааны сэдэвтэй ижил төстэй тоон болон чанарын судалгаа байгаа эсэхийг хайх хэрэгтэй. Хэрэв байхгүй бол эрлээ өргөтгөн, нийгэм-эдийн засаг, соёл, хүн ам зүйн хувьд ижил онцлогтой бүс нутаг болон хүн амыг хамарсан үндэсний болон олон улсын судалгаа хараарай. Холбогдох яамд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд (НҮБ-ын Хүүхдийн Сан, НҮБ-ын Дүрвэгсдийн Асуудал Эрхэлсэн Дээд Комиссарын Газар, НҮБ-ын ХДХВ/ДОХ-ын Нэгдсэн Хөтөлбөрийн Газар, НҮБ-ын Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага, НҮБ-ын ОУ-ын Хөдөлмөрийн Байгууллага) болон бусад ТББ-уудаас байгаа мэдээллийг нь авч болно. Тэднээс авч болох мэдээллүүдийн жишээг дор үзүүлье:

- Үндэсний судалгаанууд (Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа гэх мэт өмнө дурдсан судалгаанууд)
- Хүүхдийг Ивээх Сангийн Мэдээллийн нөөцийн төв – <http://resourcecentre.savethechildren.se>
- Дэлхийн Банкны Өгөгдлийн сан – <http://data.worldbank.org/topic>
- НҮБ-ын Дүрвэгсдийн Асуудал Эрхэлсэн Дээд Комиссарын Газрын статистик – <http://www.unhcr.org/pages/49c3646c4d6.html>
- Бэлгийн хүчирхийллийн судалгаа мэдээллийн санаачилга – <http://www.svri.org/>
- Хямралын үеийн хүүхэд хамгааллын суралцахуйн бүлэг – <http://www.cpcnetwork.org/>
- Хүүхдийн талаарх бодлогын Африкийн форум – <http://www.africanchildforum.org/site/>
- ОУ-ын Хөдөлмөрийн Байгууллага – <http://www.ilo.org/global/lang-en/index.htm>

Бусад хоёрдогч мэдээлэл, судалгааг дараах эх сурвалж, материалаас хайж болно:

- Хүүхэд хамгааллын үндэсний хөтөлбөрүүдийн мэдээлэл
- Түншлэгч байгууллагуудын хэвлэл, баримт бичгүүд
- Сэтгүүл
- Орон нутгийн сонин
- Мастер, докторын түвшний судалгаа
- Орон нутгийн эксперт, хүүхэд хамгааллын хороо, зөвлөл

## 1.2. Асуулгын судалгааны зорилго, зорилтуудыг тодорхойлох

Хоёрдогч мэдээллийг судалсны дараагаар МХД-ын асуулгын судалгаагаар илрүүлэх шаардлагатай буюу дутуу байгаа мэдээллийн талаар тодорхой ойлголттой болно. Тиймээс одоо асуулгын судалгааны үндсэн зорилгыг томъёолох, үр дүнг чухам яаж хэрэглэхийг зураглах ёстой. МХД-ын асуулгын судалгааны зорилгыг дараах зүйлийн аль нэг эсвэл хосолсон байхаар тодорхойлж болно:



- **Илрүүлэх:** хүүхэд хамгааллын тодорхой асуудалтай холбоотой далд байгаа зүйлийн талаар мэдээлэл цуглуулах. Энэ нь тухайн асуудлын талаар хүмүүс ойлголт мэдээлэлгүй эсвэл тухайн сэдвийг бараг судлаагүйн аль алинтай холбоотой байж болно.
- **Тодорхой чиг хандлага эсвэл таамаглалыг шалгах:** Хөтөлбөрийн чиг хандлага, стратегитай холбоотой таамаглалыг шалгахад асуулгын судалгааг хэрэглэж болно. Жишээ нь хүүхдийн хөдөлмөртэй холбоотой хуулийн талаарх мэдлэг, хүүхдэд хор хохирол учруулах хөдөлмөрт хандах хандлага, дадал хоорондын харилцаа холбоог тогтооход асуулгын судалгааг хэрэглэж болно.
- **Суурь үзүүлэлт тогтоох:** Хөтөлбөрийн үзүүлэлтүүдийг тодорхой цаг хугацааны явцад хянаж, өөрчлөлтийг үнэлэхэд хэрэглэх суурь үзүүлэлтүүдийг тогтооход асуулгын судалгааг хэрэглэж болно. Хэрэв суурь үзүүлэлт тогтоох зорилгоор асуулгын судалгаа хийсэн бол харьцуулахын тулд дараагийн судалгаанд яг ижил арга зүй, арга хэрэгслийг ашиглана гэдгийг мартуузай.
- **Үнэлэх:** МХД-ын асуулгын судалгаагаар хүүхэд хамгааллын хөтөлбөрийн суурь үзүүлэлтүүдийг тогтоосон бол харьцуулахын тулд түүнтэй яг ижил арга зүйгээр дахин мэдээлэл цуглуулах бөгөөд зорилго нь тодорхой хугацааны дотор хөтөлбөрөөс хамааран тухайн бүлгийн хүн амын дунд ямар өөрчлөлт гарсныг хэмжих юм.

**Заавал хийх зүйл:** МХД-ын асуулгын судалгааны зорилго, зорилтууд нь хөтөлбөрийн зорилго, шалгуур үзүүлэлттэй нягт уялдсан эсэхийг хянахын тулд хөтөлбөр болон төслийн логик хүрээг эргэн хараарай.

МХД-ын асуулгын судалгаа нь өөр хоорондоо холбоотой хэд хэдэн зорилттой байж болно. Жишээ нь хүүхэд хамгааллын асуудлуудын талаарх мэдлэгийн суурь үзүүлэлт тогтоох, сургалт, мэдээллийн материалд ашиглах оновчтой хэллэг, логикийг мэдэх зорилтоос гадна Засгийн газрын нөөц хуваарилалтыг сайжруулах үүднээс хүүхэд хамгааллын түгээмэл эрсдэлүүдийн талаар баримт цуглуулах зорилт тавьж болно. Хэдийгээр нэг удаагийн асуулга судалгаагаар олон зүйлийг тодруулахыг хичээх нь зүйн хэрэг ч хүүхэд хамгаалал гэх мэт хэт өргөн хүрээг хамарсан, олон талын зорилт тавьбал асуулгын судалгаа хэт сунжрах эсвэл удирдан хэрэгжүүлж болохгүйд хүрнэ. Арга хэрэгслүүдийг боловсруулж, туршилт хийсний дараа ярилцлагыг хөтлөгч болон оролцогч хоёрыг хэт ядраахаас зайлсхийх, зөвхөн гол мэдээллийг авах зорилгоор асуултын тоог багасгаж, сайжруулах ажлыг хийдэг.

Хүүхэд хамгаалал бол өөртөө маш олон чиглэл, сэдвийг агуулдаг өргөн хүрээтэй салбар. Жишээ нь эцэг эхийн асрамж халамжгүй хүүхдүүд, хөдөлгөөнд (шилжин суурьшиж) буй хүүхэд, бие махбод, сэтгэл санааны шийтгэл, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, хүүхдийн ажил, хөдөлмөр, гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүн, эрт гэрлэлт, хорт нөлөөтэй, сөрөг уламжлал, зан үйл гэх мэт. Түүнчлэн үйлчилгээний хүртээмж, нийгмийн хэм хэмжээ болон дадал, хүчирхийллийг мэдээлэх байдал гэх мэт өмнө дурдсан асуудлуудад бүгдэд нь хамаатай сэдвүүд ч бий. Ганц удаагийн МХД-ын асуулгын судалгаагаар энэ бүх асуудлыг судлах боломжгүй нь ойлгомжтой бөгөөд судалгааг үр дүнтэй болгохын тулд нэг дэд сэдэв, чиглэлийг л барих нь зүйтэй.

МХД-ын асуулгын судалгааны төгсгөл үе шатуудад хэт их засвар хийхээс сэргийлэхийн тулд ялгаатай мэдээллүүдийг хэрхэн хэрэглэх зураглал гаргах, асуулгын судалгааны зорилтуудыг онцолсон гол чиглэлүүдийг тогтоох хэрэгтэй. Хүүхэд хамгааллын өргөн асуудлын хүрээнд чухам ямар сэдэв, чиглэлийг голчлон авч үзэх талаар түншлэгчидтэй хэлэлцэн шийдвэр гаргах ёстой бөгөөд мэдээж тухайн сэдэв, чиглэл нь хөтөлбөрийн



зорилго, үзүүлэлтүүдтэй уялдсан байх ёстой. Хөтөлбөрийн ажилтнууд, төрийн байгууллагуудын төлөөлөл, бусад түншлэгчдийг оролцуулсан жижиг хэмжээний уулзалт хэлэлцүүлэг хийх замаар асуулга судалгаагаар хөндөх асуудлуудыг хэлэлцэх, үүнд холбогдох хүмүүсийг оролцуулах эхлэлийг тавих нь маш чухал.

**Заавал хийх зүйл: МХД-ын асуулгын судалгааны зорилгыг нэгээс хоёр өгүүлбэрт багтаан бичээрэй.**

Дор зарим жишээг үзүүлэв:

*“Жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой асран хамгаалагчдын мэдлэг, хандлага, дадлын талаарх суурь мэдээлэл цуглуулах” (суурь үзүүлэлт тогтоох)*

*“Хүүхдийн хөдөлмөртэй холбоотой асуудлаарх хүн амын хандлага, дадлыг илрүүлэх, хүүхдийг бэлгийн хүчирхийллийн эрсдэлд оруулах хувь хүний, нийгмийн, орчны хүчин зүйлийг тодорхойлох” (илрүүлэх)*

*“Эмзэг бүлгийн хүүхдүүдэд зориулсан нөөцийг тодорхойлох, үйлчилгээг хүртээмжтэй болгоход нөлөөлж буй эерэг болон сөрөг хүчин зүйл, хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх болон хариу үйлчилгээнд хамрагдах хүсэл сонирхлыг тогтоох” (илрүүлэх)*

*“Орон нутгийн хүүхэд хамгааллын хорооноос санаачлан хэрэгжүүлсэн компанит ажлын хүрээнд хүүхдийг хамгаалуулах эрхийн талаарх олон нийтийн гишүүдийн ойлголт, хандлагад гарсан өөрчлөлтийг хэмжих” (чиг хандлага/таамаглалыг шалгах/үнэлэх)*

**Заавал хийх зүйл: МХД-ын асуулгын судалгааны зорилгоо хянаж, энэ нь а) бодитой, б) тодорхой нэг сэдэвт чиглэсэн, в) холбоотой буюу нийцсэн эсэхийг баталгаажуулаарай.**

Зорилго, зорилтот бүлэг, хамрах орон нутгаас хамааран асуулгын судалгааны асуулгад асуулт нэмэгдэх эсвэл түүврийг өргөтгөх гэх мэт өөрчлөлт гарах бөгөөд үүнтэй уялдан судалгааны арга хэрэгслийг боловсруулах, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийхэд цаг хугацааны хийгээд бусад нөөц нэмэлтээр хэрэгтэй болно гэдгийг санаарай.

**Зураг 4. Асуулгын судалгааны менежмент – Баг бүрдүүлэх нь**

**Асуулгын судалгаа бол мэргэжлийн хийгээд хөтөлбөрийн ажилтнууд, захиргаа, ложистик, санхүүгийн багийнхны дэмжлэгийг шаарддаг жижиг хэмжээний төсөл юм. Менежементийн баг бүрдүүлэх нь дээрх ялгаатай нөөц, талуудыг нэг дор цуглуулан, асуулгын судалгааны үе шатуудыг түргэсгэх, шийдвэр гаргах, алдааг засах боломж олгоно. Асуулгын судалгааны менежментийн баг ажлыг төлөвлөхөөс эхлэн оролцоно.**

**Гишүүнчлэл**

- Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн менежер (эсвэл асуулгын судалгааны менежерээр томилогдсон хөтөлбөрийн аль нэг ажилтан)
- Захиргааны ажилтнууд
- Санхүүгийн ажилтнууд
- Ложистикийн ажилтнууд
- Хүүхдийг Ивээх Сангийн ахлах менежментийн багийн гишүүн

**Ажлын хүрээ**

- Асуулгын судалгаатай холбоотой шийдвэр гаргах үйл явц
- Уулзалтуудын давтамж, үргэлжлэх хугацаа
- Цуврал уулзалтуудын хөтөлбөр
- Багийн гишүүдийн үүрэг



## 1.3. Судлах асуудлуудыг тогтоох

### Юу мэдэхийг хүсэж байна вэ?

МХД-ын асуулгын судалгаа нь хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлаарх хувь хүмүүсийн мэдлэг, хандлага, итгэл үнэмшлийн тухай өргөн хүрээний мэдээллийг цуглуулахаас гадна эдгээр нь гэр бүл, сургууль болон нийгмийн бусад орчинд гаргадаг дадалтай ямар холбоо хамааралтайг шинжлэхэд тусалдаг. Хөтөлбөрт чухам яг ямар мэдээлэл хэрэгтэй байгааг сайтар тодорхойлох нь нэн чухал бөгөөд ингэснээр тэрхүү мэдээллээ олоход чиглэсэн арга хэрэгсэл боловсруулж чадна.

**Заавал хийх зүйл:** МХД-ын асуулгын судалгаагаар судлах, олж илрүүлэхийг хүсэж байгаа гол сэдвүүдээ жагсаан бичээрэй.

Судлах асуудлуудад дараах зүйл орж болно:

- Хүүхдийн хамгаалуулах хэрэгцээ, эрхийн талаар нийтлэг итгэл үнэмшил
- Хууль, үйлчилгээ, нөөцийн талаарх ойлголт
- Хүчирхийллийг мэдээлэх, сургуульд хамрагдах, хамгааллын механизмыг хэрэглэхэд нөлөөлж буй хувь хүний, нийгмийн, бүтцийн саад бэрхшээл
- Хүүхэд хамгааллын олон нийтийн механизм
- Эрт гэрлэлт, хүүхдийн асрамжлал, бие махбодын болон сэтгэл санааны шийтгэл, төвлөрсөн асрамж халамж гэх мэтийн талаар эерэг хийгээд сөрөг хандлагын тархалт

**Судлах зүйл болон судалгааны асуултыг хэр нарийн тодорхойлно, тэр хэмжээгээр хэрэгтэй байгаа мэдээллээ цуглуулах арга хэрэгсэл нарийн гарна.**

Судлах асуудлуудыг тогтоохын тулд хөтөлбөрийнхөө логик хүрээг эргэн харахыг зөвлөж байна. Зарим тохиолдолд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд нь судлах асуудлууд болон судалгааны үндсэн асуулттай шууд холбоотой байдаг.

### Зураг 5. Судлах зүйлийг тогтоох





Хавсарсан шийтгэл эсвэл хүүхдийн хөдөлмөр гэх мэт тодорхой асуудлаар зорилтот хүн амын зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн зорилгын төлөө олон хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Гэвч хүний зан үйл бол маш нарийн, төвөгтэй зүйл бөгөөд хөтөлбөрийн үйл ажиллагаатай хамааралтай болон хамааралгүй маш олон хүчин зүйл түүнд нөлөөлж байдаг. Сайн хөтөлбөр нь хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхойлохдоо хүний зан үйлийн цогц, нарийн байдлыг харгалзан үзэх бөгөөд үйлчилгээг хүргэхэд анхаарахаас гадна тодорхой үйлчилгээг бий болгохыг шаарддаг.

### Хүүхдийн оролцоо

Асуулгын судалгааны зорилгыг тодорхойлох, судлах зүйлийг тогтоох, судалгааны асуулт гаргахад хүүхдүүдийг оролцуулж болно.

- ➔ Зорилтот хүн амын бүлгээс хүүхдийн зөвлөлдөх бүлгийг үүсгэснээр асуулгын судалгааны төлөвлөлтөд хүүхдүүд оролцох боломжтой болно.
- ➔ Асуулгын судалгааны төлөвлөлтийн үүлзалт хийх, судалгааны гол асуулттай холбоотой энгийн судалгааг хүүхдүүдээр үеийнхэн дотор нь хийлгэж болно.
- ➔ Асуулгын судалгааны сэдэв, чиглэлээр хүүхдүүдийн үзэл бодлыг мэдэх фокус бүлгийн ярилцлагыг хийж болно.

Жишээ нь хүчирхийллийг мэдээлэх асуудалд хандахдаа мэдээлэх, хариу арга хэмжээ авах механизмыг бүрдүүлэх нь чухал ч гэсэн энэ нь дангаараа үр дүнгээ өгөхгүй. Хүчирхийллийг мэдээлэх шийдвэр нь хүчирхийлэл болон хүний хувийн нууц, кейсийн нөхцөл байдал, мэдээлэхтэй холбоотой гарч болох эрсдэлүүд, хүлээн зөвшөөрөл, дэмжлэг, нийгмийн ээдрээтэй динамик байдал зэргээс хамаарсан итгэл үнэмшил, дадалтай холбоотой байдгийг бас анхаарах хэрэгтэй. МХД-ын асуулгын судалгаа нь зорилтот хүн ам болон түүнийг бүрдүүлэгч бүлгүүдийн дунд хүчирхийллийг мэдээлэхэд саад болж буй гол хүчин зүйлийг тогтооход тусалж болно. Энэ мэдээллийг хөтөлбөрөө төлөвлөх, тодорхой арга хэмжээ авахад ашиглана.


## 1.4. Судалгааны гол асуултуудыг тодорхойлох

Хариулт олохыг хүсэж буй асуултуудаа жагсаан бичээд тэдгээр хариултыг олоход МХД-ын асуулгын судалгаа тохиромжтой арга байж чадах эсэхийг бодоорой. Асуулгын судалгааны зорилгоос хамааран жагсаасан асуулт тань илрүүлэх эсвэл үнэлэх хэлбэртэй байна. Ойлгоход хялбар болгох зорилгоор энэхүү зөвлөмжид судлах асуудлуудын дотор байгаа бүх асуултыг судалгааны асуулт (research question) гэж үзлээ. Судлах асуудал буюу судалгааны асуултыг тодорхойлох явцдаа хөтөлбөрийн бүтцэд ямар нэг сул, хоосон “зай” байгааг олж харж магад. Энэ нь тухайн сул, хоосон “зайг дүүргэх” сайхан боломж юм.

**Судалгааны асуулт нь тодорхой хийгээд нэг зүйлд төвлөрсөн байна.** Хэрэв судалгааны асуулт хэт өргөн эсвэл хийсвэр бол түүнд хариулт авчрах асуулгын судалгааны арга хэрэгсэл боловсруулах ажил төвөгтэй болно. Үүнтэй адилаар, ялгаатай хэд хэдэн асуултыг нэг дор асуулт болгон багцлахаас зайлсхийх хэрэгтэй. Ялгаатай асуултуудыг тус тусад нь салгаж, тэдгээр асуултад хариулт авчрах арга хэрэгсэл боловсруулж байгаа эсэхээ анхаарч байвал зохино.

**Заавал хийх зүйл:** Судлах асуудлуудын хүрээнд хариулт олохыг хүсэж буй асуултуудаа бичээрэй.

## Зураг 6. Судалгааны асуулт боловсруулах нь



Судалгааны зарим асуултыг асуулгын судалгаагаар хариулах боломжгүй эсвэл судалгааны өөр аргаар хариулах нь илүү тохиромжтой байж болохыг анзаарч магад. Энэ тохиолдолд асуулгын судалгааны протоколоо эргэн харж, тэрхүү зайг дүүргэж болох нэмэлт мэдээлэл цуглуулах талаар бодож үзээрэй.

## Зураг 7. Хүүхдийг Ивээх Сангийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны онцлох хэсгүүдээр гаргасан судалгааны асуултын жишээ

Хүүхдийг Ивээх Сангийн онцлох үйл ажиллагаа	Судалгааны асуултуудын жишээ		
	Мэдлэг	Хандлага	Дадал
<b>Эцэг эхийн асрамж халамжгүй хүүхэд</b>	Үрчлэлтийн хуулийн талаар асран хамгаалагчдын мэдлэг ямар байна вэ? Төвлөрсөн асрамж халамжийн талаар асран хамгаалагчид юу мэдэж байна вэ (хүүхэд төвлөрсөн асрамжийн үйлчилгээнд шилжлээ ч эцэг эх нь эргэн уулзаж болох талаар гэх мэт)?	Төвлөрсөн асрамжийн газрын асрамж халамж, боловсролын чанарыг асран хамгаалагчид хэрхэн ойлгож байна вэ? ОУ-ын үрчлэлтэд хүүхдээ өгөхийн давуу талыг асран хамгаалагчид хэрхэн ойлгож байна вэ?	Сүүлийн 12 сарын хугацаанд судалгаанд хамрагдсан гэр бүлүүдээс төвлөрсөн асрамжийн газарт хүүхдээ өгсөн гэр бүлийн тоо хэд байна вэ? Хүүхдээ төвлөрсөн асрамжийн газарт өгөх тэдний шийдвэрт ямар хүчин зүйл нөлөөлсөн бэ?
<b>Хөдөлгөөнд (шилжин суурьшиж) буй хүүхэд</b>	Шилжин суурьшихад хүүхдэд тохиолдож болох эрсдэлүүдийн талаар хүүхдүүд болон насанд хүрэгчид юу мэдэж байна вэ? Хэрхэн аюулгүйгээр шилжин суурьшиж болох, шилжин суурьших үед хүүхдийг хэрхэн хамгаалж болох талаар хүүхэд, насанд хүрэгчдийн ойлголтын түвшин ямар байна вэ?	Түр байгаа болон шилжиж очсон газарт боломжийн ажил олдох эсэх талаар хүүхэд, асран хамгаалагч ямар бодолтой байна вэ? Одоо байгаа газартай харьцуулахад шилжиж очсон газарт боломжийн хийгээд цалин сайтай ажил олдох эсэх талаар хүүхэд ямар бодолтой байна вэ?	Сүүлийн 12 сарын хугацаанд шилжиж ирсэн хүүхдийн тоо? Ямар хүүхэд нүүн шилжих хандлагатай байна вэ? Нүүн шилжих шийдвэрт ямар хүчин зүйл нөлөөлж байна вэ? Хүүхдүүд ганцаараа эсвэл эцэг эхтэйгээ нүүн шилжиж байна уу? Хүүхдүүд аюулгүй нүүн шилжсэн үү?
<b>Бие махбод, сэтгэл санааны шийтгэл</b>	Хүүхдийг Ивээх Сангийн хөтөлбөр хэрэгждэг орон нутгуудад бие махбод, сэтгэл санааны шийтгэлийн хүүхдийн хөгжилд үзүүлэх нөлөөний талаар асран хамгаалагчдын мэдлэг ямар байна вэ?	Хүүхдийг хүмүүжүүлэх зохистой арга хэлбэрийн талаар асран хамгаалагчид ямар бодолтой байна вэ? Хүүхдийн хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэдэг бусад хүмүүсийн талаар асран хамгаалагчид ямар бодолтой байна вэ?	Хүүхдийг Ивээх Сангийн хөтөлбөр хэрэгждэг орон нутгуудад бие махбод, сэтгэл санааны шийтгэлийн хэрэглээ ямар байна вэ? Бие махбод, сэтгэл санааны шийтгэлийн хэрэглээнд ямар хүчин зүйл (нийгэм-хүн ам зүйн онцлог, мэдлэг, итгэл үнэмшил, хүүхэдтэйгээ тогтоосон харилцаа холбоо) холбоотой байна вэ?
<b>Хүүхэд ба ажил</b>	Аюултай ажил хийснээр хүүхдэд ямар хор нөлөө учирч болох талаар асран хамгаалагчид юу мэдэж байна вэ? Ажлын байранд хүүхдийн хамгаалуулах эрхийн талаар хүүхэд, асран хамгаалагчийн мэдлэгийн түвшин ямар байна вэ?	Охидыг ажиллуулахын оронд боловсрол олгох талаар асран хамгаалагчдын бодол ямар байна вэ?	Хүүхдийг Ивээх Сангийн хөтөлбөр хэрэгждэг орон нутгуудад хүүхдүүд ямар ажил эрхэлж байна вэ? Хүүхэд аюултай ажил хийхэд нөлөөлж байгаа ямар хүчин зүйл байна вэ?

## 1.5. Асуулгын судалгааны зорилтот хүн амыг ТОГТООХ нь

Асуулгын судалгаагаар чухам юу илрүүлэх, мэдэхийг хүсэж байгаагаас хамааран ялгаатай хүн амын бүлгийг сонгоно. Судалгааны асуултуудыг ойлгомжтой тодорхойлчихсон бол дараагийн алхам нь тэдгээр асуултуудад хариулахын тулд чухам хэнээс мэдээлэл цуглуулах вэ гэдгийг нарийн тодорхойлно. Хүн амын ерөнхий бүлгийн мэдлэг, хандлага, дадлын талаар сонирхож байна уу эсвэл хөтөлбөрийн үйл ажиллагаагаа хандуулдаг тодорхой бүлгийн хүн амынхыг мэдмээр байна уу гэдгээ бодолцож үзээрэй. Жишээ нь 12-оос доош насны хүүхэдтэй асран хамгаалагчдад зориулсан сайн эцэг эх байх буюу хүүхдийн хүмүүжлийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бол бие махбод, сэтгэл санааны шийтгэлийн талаар МХД-ын асуулгын судалгааны гол зорилтот хүн ам нь 12-оос доош насны ядаж нэг хүүхэдтэй өрх байна гэсэн үг.

Түүнчлэн хүүхдээс гадна насанд хүрэгчдээс мэдээлэл авах хэрэгтэй эсэхээ бодох нь тун чухал. Суугаад, урьдчилан боловсруулсан асуултуудад хариулах нас, хөгжлийн онцлогтоо хүрсэн хүүхдүүд л асуулгын судалгаанд оролцоход тохиромжтой. **МХД-ын асуулгын судалгаанд 12-оос дээш насны хүүхдийг оролцуулах нь зохистой хэмээн зөвлөмжилдөг.** Үүнээс доош насны хүүхдийг МХД-ын асуулгын судалгаанд оролцуулах нь зохимжгүй бөгөөд ийм насны хүүхдүүдийг зайлшгүй оролцуулах шаардлагатай бол чанарын юм уу оролцооны аргуудыг ашиглах нь зүйтэй.



Асуулгын судалгааны зорилтот хүн амыг дараах хэмжүүрт үндэслэн тогтооно:

- **Хүн ам зүйн онцлог шинж** – нас, хүйс, шашин шүтлэг, хот, хөдөө, орлогын түвшин, нийгмийн статус, боловсрол, ажил эрхлэлт, үндэстний болон хэлний цөөнх, хөгжлийн бэрхшээл, хүүхдээр толгойлуулсан өрх гэх мэт
- **Газар зүйн байршил/хүртээмж** – үйлчилгээнээс зайтай, алслагдмал байх
- **Ажлын байр, нийгмийн бүлэглэл** – Эрхэлдэг ажлын төрөл, салбар (албан, албан бус салбар, хөдөө аж ахуй, жижиглэн худалдаа, шийдвэр гаргагч, эрүүл мэндийн ажилтан, шашны удирдагч, их сургуулийн оюутан гэх мэтээр нарийн задарч болно)
- **Бусад онцлог шинж** – шилжин суурьшсан эсэх, өнчин эсэх, байгалийн гамшиг эсвэл ямар нэг зөрчилд (зэвсэгт зөрчил, мөргөлдөөн гэх мэт) өртсөн эсэх, асран хамгаалагч, багш, хүүхэд, гэр бүлийн бусад гишүүн гэх мэт хүүхэд хамгаалалтай холбоотой бусад бүлгүүд
- **Хүүхэд хамгааллын үйл ажиллагаан дахь оролцоо эсвэл хамрагдалт**

Тухайн улс орны нөхцөл байдлаас хамааран үйлчилгээний талаарх ойлголт, хүртээмжийн түвшин нь нийгэм, соёл, эдийн засгийн онцлог шинжээр мөн ялгарна.



### Асуулгын судалгааны хүн амыг тогтоох нь: Кейс судалгаа (Либериа)

**Зорилго 1:** Либерийн Хүүхдийг Ивээх Сангийн хөтөлбөр хэрэгждэг орон нутгуудад хүүхэд хамгааллын, нэн ялангуяа эцэг эхийн асрамж халамжгүй хүүхдүүдийн асуудлаар олон нийт (хүүхдүүд болон үүрэг хүлээгчид)-ийн мэдлэг, хандлага, дадлын суурь үзүүлэлт бүрдүүлэх

**Зорилго 2:** Зорилтот газруудад буй эмзэг бүлгийн хүүхдүүдэд зориулсан нөөцийг тогтоох, хүүхдийн хамгаалуулах эрхийн зөрчлийг үүсгэхэд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйлчилгээний хүртээмж болон түүнд хамрагдах хүүхдийн хүсэл сонирхлыг мэдэх

Судлах асуудлууд буюу судалгааны асуултууд	Зорилтот хүн ам
<p><b>Хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдалд учрах нийтлэг эрсдэл</b> Хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдал, хөгжлийг эрсдэлд оруулж болохуйц нөхцөл байдлын талаар хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид ямар бодолтой байна вэ?</p>	<p><b>Төв болон баруун Либериа, Монровиагийн 12 дүүргийн өрхүүдийн хүүхдүүд болон тэдний асран хамгаалагчид</b></p>
<p><b>Эцэг эхийн асрамж халамжгүй хүүхдүүдэд учирч болох эрсдэл</b> Эцэг эхийн асрамж халамж хангалтгүй байхыг хүүхэд, эцэг эхчүүд эрсдэл гэж үзэж байна уу, тэдгээр эрсдэлийг хэрхэн ойлгож байна вэ? Эцэг эхийн асрамж халамжгүй хүүхдүүдэд зориулсан хувилбарт үйлчилгээний талаар мэдлэг, хандлага ямар байна вэ?</p>	<p>Донор байгууллагын хүсэлтээр төсөл хэрэгжиж буй орон нутгийн хүн амыг хамруулсан.</p>
<p><b>Хүүхдийг хамгаалах нөөцийн хүртээмж, мэдлэг, хэрэглээ</b> Хүүхдийн асрамж халамж, аюулгүй байдалтай холбоотой Либерийн хуулийн болон нөөцийн талаарх ойлголт, мэдлэгийн түвшин ямар байна вэ? Хүүхэдтэй зүй бус харилцахтай холбоотой асуудлаарх хүүхэд болон асран хамгаалагчдын хандлага, дадал ямар байна вэ?</p>	<p>Өрх гэдэг нь өөр хоорондоо хамааралтай эсвэл хамааралгүй боловч нэг дор амьдарч, нэг тогооноос хоол идэж буй нэг буюу хэсэг бүлэг хүнийг хэлнэ гэж тодорхойлсон.</p>
<p><b>Хүүхдийг хамгаалах олон нийтийн хандлага</b> Хүүхдийг хамгаалах талаар итгэл үнэмшил, дадал байна вэ? Хүүхдийг хамгаалахад зориулсан, байх ёстой дэмжлэгийн талаар хүүхэд, асран хамгаалагч ямар бодолтой байна вэ?</p>	<p>Асран хамгаалагч гэдэг нь хүүхэдтэй ямар холбоо хамааралтай байхаас үл хамааран хүүхдийг асран халамжилж буй 18-аас дээш насны хүн.</p>
<p><b>Эцэг эхийн асрамж халамжгүй хүүхдүүд</b> Хүүхэд, эцэг эхтэйгээ амьдрахгүй байгаагийн гол шалтгаанууд юу байна вэ? Эцэг эхийн асрамж халамжгүй хүүхдүүдийг халамжлах хувилбарт үйлчилгээ (асралт гэр бүл)-ний талаарх хандлага, дадал ямар байна вэ? Төрсөн болон асарч байгаа хүүхдүүдэд ялгаатай хандлага гаргах байдал асралт гэр бүлүүдэд байна уу?</p>	<p>Төвлөрсөн халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй эсвэл орон гэргүй хүмүүс энэ асуулгын судалгааны зорилтот хүн амын бүлэгт багтсан боловч тодорхой шалтгаанаар өрхийн түүвэрт хамрагдаагүй.</p>
<p><b>Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хүртээмж</b> Хүүхэд зориулсан эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хүртээмжийн түвшин ямар байна вэ? Өвчтэй хүүхэд эрүүл мэндийн үйлчилгээ авахад эсвэл сургуулийн насны хүүхэд боловсролын үйлчилгээний гадна орхигдоход нөлөөлж буй ямар саад бэрхшээл байна вэ?</p>	<p>Өнчин хүүхэд, аюулгүй гэр орны талаарх хандлага, ойлголтын талаарх мэдээллийг фокус бүлгийн хэлэлцүүлгээр цуглуулсан.</p>



**Заавал хийх зүйл:**

- 1) **Асуулгын судалгаанд хамрагдах хүн амын тодорхой бүлгийг тогтоох, тэрхүү бүлгийн онцлог шинжийг тодорхойлоорой.** Уг бүлгийн хүн амыг хэрэгжүүлж буй хөтөлбөрийн зорилтот бүлгээр тодорхойлчихсон байх нь элбэг (жишээ нь өнчин эсвэл эмзэг бүлгийн хүүхэдтэй өрх гэх мэт). Түүнчлэн судлах асуудлуудаас хамааран ямар бүлгийн хүн амыг асуулгын судалгаанд оролцуулахаа тодорхойлж болно.
- 2) **Хүн амын бүлгийн онцлог шинжүүд, нэн ялангуяа асуулгын судалгаагаар олж мэдэхийг сонирхсон үр дүнд нөлөөтэй байж болох шинжүүдийг тодорхойлон бичээрэй.**

Амьдарч буй газар, шашны итгэл үнэмшил, хэл, яс үндэс, боловсролын түвшин, нийгэм-эдийн засгийн статус гэх мэт хүн амын онцлог шинжүүд нь хүүхэд хамгаалалтай холбоотой тэдний ойлголт, хандлага, зан үйл нөлөөлөх магадлалтай байдаг. Асуулгын судалгаанд харгалзан үзэх хүн амын бүлгийн онцлогийн жишээг дор үзүүлэв:

- Зорилтот хүн амын доторх эрэгтэй, эмэгтэйн тоо
- Зорилтот хүн амын насны ангилалд суурилсан онцлогууд (жишээ нь хүүхдүүд, өсвөр насныхан, насанд хүрэгчид, ахмад насныхан гэх мэт)
- Асран хамгаалагч
- Гэр бүлийн гишүүн
- Өнчин эсвэл эмзэг хэмээн тогтоогдсон хүүхдүүд
- Асралт гэр бүл
- Төвлөрсөн асрамжийн газарт буй хүүхдүүд
- ХДХВ/ДОХ-той гишүүнтэй өрхийн хүүхдүүд
- Сургуулийн насны сургуульд сурдаггүй хүүхдүүд
- Эхчүүд (өсвөр насны ээжүүд мөн орно)

Түүврийн хэмжээ, мэдээлэл цуглуулахад шаардагдах цаг хугацаа, бусад нөөц, мэдээлэл цуглуулах арга хэрэгслийн тоо, мэдээлэл цуглуулагчдын тоо, мэдээлэлд дүн шинжилгээ хийх хүрээ нь судлахыг хүсэж буй хүн ам, тэдгээрийн тодорхой онцлог бүхий бүлгүүдээс шууд хамаарна. Жишээ нь төсөл хэрэгжиж буй газруудын асран хамгаалагчид болон 12-17 насны хүүхдүүдийг хамруулъя гэж бодож байгаа бол хүүхэд, насанд хүрэгчдийн бүлэг тус бүрийн түүврийг гаргана. Мөн хүүхэд, насанд хүрэгчдэд зориулсан ялгаатай асуулт боловсруулахаас гадна хүүхдээс мэдээлэл цуглуулах хүмүүсийг сайтар бэлтгэж, сургах хэрэгтэй болно гэсэн үг.

Асуулгын судалгаанд өөр өөр бүлгийн хүмүүсийг оролцуулахаар болсон бол бүлэг тус бүрд зориулсан бага зэргийн ялгаатай асуултуудыг боловсруулах хэрэгтэй болно. Жишээ нь асуултыг ойлгох, хариулах чадварт суурилан хүүхэд болон өсвөр насныханд тавих асуулт өөр өөр байна. Үүнтэй адилаар эмэгтэй, эрэгтэй хүнд тавих асуултууд ч өөр байж болох юм. Түүнчлэн сургуульд сурах боломжийг хааж буй шалтгаан, ажил эрхлэлт, тэдэнд тохиолддог эрсдэлүүд гэх мэт асуултыг сургуульд сурч буй хүүхдээс асуух шаардлагагүй, харин сургуульд сурдаггүй хүүхдээс асуух ёстой учраас асуултууд нь асуулгын судалгаанд хамрагдаж буй зорилтот бүлэг болгоноор ялгаатай байна.

## 1.6. Түүврийн төлөвлөгөө гаргах

**Асуулгын судалгааны түүвэр гэдэг нь асуулгын судалгаанд оролцуулахаар, эх олонлогийг төлөөлөхүйц хэмжээгээр сонгосон бүлэг юм.**

Асуулгын судалгаанд ихэвчлэн эх олонлог буюу тухайн зорилтот бүлгийн хүн амыг бүхэлд нь төлөөлж чадах тодорхой хэсгийг түүвэрлэн сонгож, ярилцдаг. Зорилтот хүн амыг бүрдүүлж буй бүх хүнтэй ярилцлага хийх нөөц байхгүй (10 жил тутам явагддаг хүн амын нэгдсэн судалгааг эс тооцвол) учраас асуулгын судалгааны түүвэрт чухам хэнийг хамруулах вэ, хэдэн хүнийг хамруулах вэ, үр дүнг тархаан хэрэглэхийн тулд чухам ямар аргаар тэднийг сонгох вэ гэдгийг тооцсон түүврийн төлөвлөгөөг гаргадаг.

**Үр дүнг тархаан хэрэглэх** гэдэг нь тухайн асуулгын судалгааны үр дүнг зөвхөн сонгосон түүврийн хэмжээнд биш харин тухайн түүврийн төлөөлж буй эх олонлог буюу хүн амын тодорхой бүлэгт үр дүнг тархаан хэрэглэж болохыг хэлнэ. Үр дүнг тархаан хэрэглэх боломжийг бүрдүүлэхийн тулд түүврийн хэмжээ болон мэдээлэл нь судалгааны арга зүйн тодорхой шалгуурыг хангасан байх ёстой.

Асуулгын судалгааны зорилтот бүлэг буюу түүврийг сонгох арга (санамсаргүй, зориудын, хялбар гэх мэт) нь судалгаанд гарч болох алдаа, түүнийг багасгах, арилгах боломжийг тооцох, эх олонлогт асуулгын судалгааны үр дүнг итгэлтэйгээр тархаан хэрэглэх нөхцөлийг хангахад нөлөөлнө.

Түүврийн дараах хэлбэрүүд байна:

**Санамсаргүй түүвэр:** Сонгогдох боломж тэгш байх зарчмаар эх олонлогоос тухай хүнийг санамсаргүйгээр сонгох арга. Ийнхүү санамсаргүй байдлаар түүвэрлэн сонгох нь гарч болох алдааг бууруулж, эргээд судалгааны үр дүнг эх олонлогт тархаан хэрэглэх боломж өгдөг. МХД-ын ихэнх асуулгын судалгаанд **кластер (бүлэглэсэн)-ийн түүврийг** хэрэглэдэг бөгөөд энэ нь хувь хүмүүсээс биш харин тодорхой хүн амын бүлгүүдээс санамсаргүй түүврийн аргаар оролцогчдыг сонгож, бүлэг тус бүрээс сонгогдсон хүмүүстэй ярилцах замаар хүссэн түүвэртээ хүрэх арга юм.

**Зориудын түүвэр:** Тодорхой шалгуур, үндэслэлд суурилан оролцогчдыг сонгох түүврийн хэлбэрийг хэлнэ. Жишээ нь хүүхдийн төвлөрсөн асрамжийн газарт ажиллаж буй мэргэжилтнүүдийн түүвэр гэх мэт.

**Хялбар түүвэр:** Амар хялбар байх үндэслэлээр оролцогчдыг сонгох арга. Түүврийн энэ арга нь цаг хугацаа, хөрөнгө бага зарах боломж өгдөг боловч судалгааны алдааг бууруулж чаддаггүй, дээрээс нь үр дүнг эх олонлогт тархаан хэрэглэж болох итгэлцлийг үүсгэдэггүй.

Түүврийн хүрээг сонгохоосоо өмнө судалгааны үр дүнг ямар эх олонлогт тархаан хэрэглэх бодолтой байгаа, хүлээж буй үр дүнг гаргах зорилтот бүлгийн хэмжээг тогтоох статистикийн (шинжлэх ухааны) **шаардлагын** түвшин буюу зэргийг тодорхой болгох хэрэгтэй. Сонгосон түүвэрт хүрэхийн тулд зарцуулж буй цаг хугацаа, бусад нөөцийн хэмжээ нь статистикийн шаардлагын түвшин буюу зэрэгтэй шууд хамааралтай буюу пропорциональ байна. Статистик төлөөлөл бүхий түүвэр (санамсаргүйгээр сонгосон) нь эх олонлог дахь хүн амын хэчнээн хувь

нь тодорхой асуудлын талаар мэдлэг, хандлага, дадлын ямар түвшин, зэрэгтэй байгааг илэрхийлж чадна. Харин хялбар түүвэр нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй боловч судалгааны үр дүнг тархаан хэрэглэх, судалгааны алдааг багасгах зорилгыг хангаж чадахгүй. Шаардагдах хүчин чармайлт эсвэл нарийвчлалтай, тодорхой байх шалгуурын алиныг нь сонгохоо жинлэх хэрэг гарч байгааг эндээс харж болно.

Асуулгын судалгааны үр дүнг хэрхэн хэрэглэхэд нөлөөлдөг учраас түүврийн хүрээ тун чухал. Тийм учраас түүврийн хүрээг зохистой хийгээд шинжлэх ухааны судалгааны шалгуур хангасан байхаар гаргахад хангалттай цаг хугацаа, нөөц зарцуулах нь буруу биш. Судалгааны үр дүнг эх олонлогт тархаан хэрэглэх боломжийг хязгаарладаг учраас **боломжтой бол хялбар түүврийн аргыг аль болох хэрэглэхгүй байхыг зөвлөж байна.** Түүврийн хүрээгээ сайтар гаргаагүй тохиолдолд судалгааны зарим үр дүнг хэрэгжүүлж буй хөтөлбөртөө хэрэглэж болох ч Засгийн газар гэх мэт хөндлөнгийн байгууллага, хүмүүсийн өмнө судалгааны үр дүнгээ хамгаалж чадахгүйд хүрч болно. Харин **санамсаргүй түүврийн арга нь шинжлэх ухааны судалгааны шаардлага хангасан, хамгийн итгэлтэй аргачлалд тооцогддог.** Гэвч санамсаргүй түүвэрлэлт хийх үзүүлэлтээ зөв сонгохгүй бол алдаа гарч, тэр хэрээр судалгааны үр дүнд итгэх итгэл багасна.

Түүврийн хэмжээ ихсэх тусам үнэн бодитой үр дүн гарах боловч бага хэмжээний түүвэртэй харьцуулахад мэдээж цаг хугацаа их шаардлагатай. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх төлөвлөгөөнд хүн амын ялгаатай хэсгүүдээр харьцуулалт хийхээр туссан бол түүврийн хүрээгээ эргэн харж, нийт түүвэр, түүн доторх ялгаатай бүлгүүдэд харьцуулалт хийхэд хангалттай хэмжээний түүвэр орсон эсэхийг нягтлах хэрэгтэй. Жишээ нь охид, хөвгүүд гэсэн хүйсийн бүлгээр мэдээллийг харьцуулахыг хүсэж байгаа бол охид, хөвгүүдийн бүлгийн түүвэр нь харьцуулж болох хэмжээний их байх ёстой гэсэн үг. Түүврийн хэмжээг тодорхойлох тусгай хэрэгсэл ашиглаж байгаа бол зорилтот хүн амын доторх бүлэг тус бүрээр түүврийг тодорхойлох, ингэснээр хангалттай хэмжээний түүвэр бүрдүүлж чадна.

**Түүврийн хүрээг тогтоох, нэн ялангуяа санамсаргүй аргаар түүврийг сонгох гэж байгаа бол мэргэжлийн статистикчийн туслалцаа зайлшгүй авахыг зөвлөж байна.**



Судалгаанд гарах алдаанаас зайлсхийх эсвэл багасгах үүднээс санамсаргүй түүврийн аргыг хэрхэн хэрэглэх, **нарийвчлал, итгэлцлийн** шаардлагад нийцсэн түүврийг тооцож гаргахад статистикч тусална. Түүврийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл зөвлөмжийн төгсгөлд буй нэмж судлах материалын жагсаалтыг үзнэ үү.

## **Асуулгын судалгаанд зориулсан зөвлөгөө – Зөвлөх хороо байгуулах нь**

**Тодорхой давтамжтай уулзаж, асуулгын судалгааны явцыг хянах, мэргэжлийн зөвлөгөө өгөх зорилго хувьд мэргэжилтнүүдээс бүрдсэн Зөвлөх хороог байгуулах нь асуулгын судалгаанд түншлэгчдийн оролцоог хангах үр дүнтэй хийгээд шалгарсан арга юм.**

Асуулгын судалгааны дизайн боловсруулах, хэрэгжүүлэх явцад түншлэгчдийг ийнхүү албан ёсоор оролцуулах нь асуулгын судалгааг гүйцэтгэх явцад болон асуулгын судалгааны үр дүнг түгээх, нөлөөлөхөд хэд хэдэн давуу талыг авчирна. Төрийн байгууллагууд, академик институтууд, орон нутгийн хийгээд олон улсын ТББ-ууд, олон нийтийн бүлгүүд зэрэг түншлэгчдийг оролцуулах нь тэдгээр бүлгийн дэмжлэгийг авах, Хүүхдийг Ивээх Санд тэр бүр байдаггүй нөөц болох мэргэшлийн чадвар, мэдээлэл, нөлөөлөл гэх мэт ашигтай нөөцийг тэднээс гаргуулах боломж олгоно.

**1. Зөвлөх хорооны ажлын даалгавар боловсруулах.** Асуулгын судалгааны үе шат бүрд хороо хэрхэн оролцох, гишүүнчлэлийн шалгуур үзүүлэлт, хорооны хуралд оролцох, мэргэжлийн дэмжлэг үзүүлэхтэй холбоотой хүлээлтүүдийг ажлын даалгаварт тусгана. Зөвлөх хорооны ажлын даалгаварт тэдний “зөвлөх” үүргийг маш тодорхой тусгаарай. Асуулгын судалгаатай холбоотой аливаа чухал шийдвэр гаргах эрхийг Зөвлөх хороонд олгохоос татгалзах нь зүйтэй.

**2. Зөвлөх хорооны гишүүдийг сонгох, урихдаа няхуур хандах.** Асуулгын судалгааны зөвлөх хороо байгуулах нь давхар хяналт, зөвлөгөө өгөх мэтээр ажлыг удаашруулах тал бий ч хорооны гишүүдийг сонгохдоо бодолтой хандвал дараа нь үр дүнтэй байж болно. Хорооны гишүүн бүр мэргэжлийн мэдлэг туршлага, нөөц гэх мэт ямар нэг зүйлээр асуулгын судалгаанд хувь нэмэр үзүүлнэ. Гэвч асуулгын судалгааны үр дүнг нэн ялангуяа нөлөөллийн үйл ажиллагаанд хэрэглэх гэж байгаа бол тэдний улс төрийн байр суурийг харгалзалгүйгээр өнгөрч болохгүй.

**3. Зөвлөх хороог, асуулгын судалгааны төлөвлөлтийн явцаас буюу аль болох эрт оролцуулах.** Зөвлөх хорооны гишүүдийн мэдлэг туршлага, холч хараа, дэмжлэг нь асуулгын судалгаанд хэрэгтэй нөөцийг тогтоох, асуулгын судалгааны сайн протокол боловсруулах, мэдээлэл цуглуулахаас өмнө ёс зүйн зөвшөөрөл авах зэрэгт тус болно. Мөн тэднийг асуулгын судалгааг төлөвлөх үйл явцад оролцуулснаар түүнд эзэн хүний ёсоор хандах байдлыг бүрдүүлж, улмаар асуулгын судалгааны сүүлийн шатуудад тэдний дэмжлэг авах боломж бүрдэнэ.





# АЛХАМ 2: Асуулгын судалгааны протокол боловсруулах нь

## Үйл ажиллагаа

- 2.1. Асуулгын судалгааны протоколын гол бүрэлдэхүүн хэсгүүдийг боловсруулах
- 2.2. Ёс зүйн зөвшөөрөл авах, хүүхэд хамгааллын бодлого гаргах
- 2.3. Ажлын төлөвлөгөө гаргах
- 2.4. Төсөв боловсруулах

## Үр дүн

- ✓ Мэргэжлийн зөвлөгөө авахаар Зөвлөх хороонд хүргүүлсэн протокол
- ✓ Хүүхдийг Ивээх Сан болон холбогдох бусад байгууллагаас ёс зүйн зөвшөөрөл авахаар хүргүүлсэн протоколын сүүлийн хувилбар
- ✓ Ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө гаргах, төсөв боловсруулахтай холбоотой ажилтнуудыг дэмжих ложистик болон удирдлагын туслалцаа





# АЛХАМ 2: Асуулгын судалгааны протокол боловсруулах нь



## 2.1. Асуулгын судалгааны протоколын гол бүрэлдэхүүн хэсгүүдийг боловсруулах

Аливаа судалгааны гол баримт бичиг нь протокол бөгөөд энэ нь асуулгын судалгааны зорилго, арга, алхмуудаас гадна мэдээлэл цуглуулах зөвлөмжийг багтаасан үндсэн баримтын үүрэг гүйцэтгэдэг. Хэрэв ёс зүйн хороо болон бусад холбогдох байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагатай бол энэхүү протокол нь тэрхүү зөвшөөрлийн суурь болно. Түүнчлэн асуулгын судалгааны протокол нь судалгааны үе шат тус бүрийг харуулсан мастер төлөвлөгөө болохоос гадна хийх ажил, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан гаргахад тусалдаг.

Асуулгын судалгааны протоколд хамгийн наад зах нь дараах элементүүдийг оруулсан байх ёстой:

1. Асуулгын судалгааны нэр
2. Асуудал ба суурь мэдээлэл (асуулгын судалгаа явагдаж буй хам орчин, ерөнхий зорилго, асуулгын судалгаагаар “хоосон зайг” нөхөх чухам ямар мэдээлэл дутмаг байгаа талаар энд бичнэ)
3. Асуулгын судалгааны зорилго, судалгааны гол асуултууд
4. Асуулгын судалгааны зорилтот хүн ам, түүврийн төлөвлөгөө
5. Асуулгын судалгааг явуулах газар зүйн бүс, байршил
6. Мэдээлэл цуглуулах, менежментийн аргууд (мэдээлэл цуглуулах үе шатуудын дэлгэрэнгүй дүрслэл, мэдээлэл цуглуулах, нэгтгэх, программд оруулах, хадгалах ложистикийн асуудлууд)
7. Мэдээллийн цэвэрлэгээ, дүн шинжилгээ хийх төлөвлөгөө (мэдээлэлд хэн дүн шинжилгээ хийх, статистикийн дүн шинжилгээний ямар программ ашиглах, мэдээлэлд ямар гол дүн шинжилгээг хийх гэх мэтийг багтаана)
8. Нууцыг хадгалах, мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрөл гэх мэт ёс зүйн асуудлууд (зөвшөөрөл авах маягт гэх мэтийг хавсралтаар оруулсан байх)
9. Оролцогч (судлуулагч)-дод гарч болох эрсдэл болон тэдний хүртэж болох үр шим
10. Төсөв
11. Ажлын төлөвлөгөө
12. Асуулгын судалгааны үр дүнг хэрэглэх, түгээх төлөвлөгөө
13. Мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл болон зөвшөөрөл авах хуудас гэх мэтийг багтаасан шаардлагатай хавсралтууд

## 2.2. Ёс зүйн зөвшөөрөл авах, хүүхэд хамгааллын бодлого гаргах

МХД-ын асуулгын судалгаа болон өөр бусад ямар нэг судалгааг хийхэд ёс зүйн хорооноос зөвшөөрөл авах нь чухал. Хийж буй судалгаанд хүнийг хамруулсан л бол заавал ёс зүйн хороогоор орох ёстой. Хүүхдүүдээс болон нэн эмзэг өрхүүдээс мэдээлэл цуглуулдаг тул ёс зүйн зөвшөөрөл авах нь нэн ялангуяа хүүхэд хамгааллын салбарт тун чухал. Түүнчлэн хүчирхийлэл, мөлжлөг гэх мэт эмзэг, төвөгтэй асуудлын талаар мэдээлэл цуглуулдаг учраас хүүхдийн хамгааллын салбарт ёс зүйн хувьд анхаарах зүйл бий. Хүүхдийг зорилтот бүлгээр сонгосон асуулгын судалгаа хийх гэж байгаа бол мэдээлэл цуглуулахаас өмнө асуулгын судалгааны протоколыг ёс зүйн хороогоор хэлэлцүүлэх нь нэн чухал бөгөөд ингэснээр асуулгын судалгааны явцад хүүхдэд ямар нэг хор хохирол учрахгүй байх, хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангасан байх шаардлага хангагдана.

**Ёс зүйн хороогоор асуулгын судалгааны протоколыг хянуулж, зөвшөөрөл авснаар судалгааны явцад оролцогчдыг хангалттай хэмжээнд хамгаалах, уг судалгааг зайлшгүй хийх шаардлагыг батлах, судалгаанд хамрагдаж буй хүн амын дээд эрх ашгийг хангах нөхцөл бүрддэг.**

Хүүхдийг Ивээх Сангийн хувьд “Байгууллагын Ёс Зүйн Хороо” эсвэл ёс зүйн хяналтын албан ёсны үйл явц гэж байдаггүй. Харин төрийн болон эрдэм шинжилгээний хамтрагч байгууллагуудад ийм хороо, судалгааны протоколыг ёс зүйн хувьд хянах үйл явц байдаг тул Хүүхдийг Ивээх Сангийн хувьд тэдэнд хандаж болно. Улс бүр өөрийн гэсэн үндэсний ёс зүйн хяналтын хороотой, МХД-ын асуулгын судалгаа гэх мэтээр аливаа нэг судалгаа хийхээр бол тэр хорооноос заавал ёс зүйн зөвшөөрөл авах шаардлага байж болно. Үндэсний ёс зүйн хороо нь ихэнхдээ Эрүүл мэндийн яамны харьяанд байдаг. Тиймээс асуулгын судалгаа явуулахад тухайн улс орон ёс зүйн зөвшөөрлийн хувьд ямар шаардлага тавьдгийг судалж үзэх хэрэгтэй. Асуулгын судалгааны протоколыг ёс зүйн хороогоор хянуулж, зөвшөөрөл авахад тодорхой төлбөр шаардагдаж болох тул түүнийг төсөвт тусгахаа мартуузай.

**Заавал хийх зүйл: Судалгааны хяналт, зөвшөөрөлтэй холбоотой тухайн улс орны шаардлагыг судалж үзээрэй. Үндэсний бодлого, шаардлагыг дагаж буй эсэхээ нягтлах шаардлагатай.**

Хүнээс мэдээлэл цуглуулах аливаа судалгаа нь олон улсын ёс зүйн стандартад нийцсэн эсэхийг баталгаажуулах үүднээс асуулгын судалгааны протоколыг судалгаа явагдах улс орны ёс зүйн хяналтын хороонд хүргүүлэх үүргийг судалгааг хийж буй байгууллага болон хувь судлаачид (асуулгын судалгааг ахалж буй хүмүүс) хүлээнэ. Тухайн улс орны шаардлагаас үл хамааран судалгааны төлөвлөлт (дизайн) болон хэрэгжилт, мэдээллийн хэрэглээнд ёс зүйн болон хүүхэд хамгааллын асуудлыг хэрхэн харгалзан үзсэнийг хянуулах зорилгоор протоколын нэг хувийг Хүүхдийг Ивээх Сангийн төв оффисийн асуудал хариуцсан хүнд заавал илгээхийг зөвлөө.



## Зураг 9. Судалгааны ёс зүйн хяналт

**1964 оны Хельсинкийн тунхаглалд “Судалгаанд оролцож буй аливаа хүнийг бүх ашиг сонирхлын өмнө тавина.” хэмээн заасан байдаг.**  
(Дэлхийн Анагаах Ухааны Холбоо, Хельсинкийн тунхаглал, 1964)

Судалгааны оролцогчдын эрх, сайн сайхан байдлыг хамгаалахад чиглэсэн байдлаар аливаа судалгааны дизайн гарсан байхыг ёс зүйн хороо хариуцана.

**Ёс зүйн хороо эсвэл байгууллагын ёс зүйн зөвлөл нь судалгааны протоколын дараах үзэл баримтлалуудыг хянаж үзнэ:**

- Судалгааны нийцэл, судалгааны дизайн, түүний үр дүнгийн шинжлэх ухааны чанар, судалгааны тодорхой үндэслэл, тухайн судалгаагаар аливаа зүйлийг сайжруулах, боловсронгуй болгох боломж
- Судлуулагчид (оролцогчид)-аас мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрөл
- Судлуулагч болон эмзэг хүмүүс (насанд хүрээгүй, өвчтэй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт)-ийн хамгаалал
- Хувийн мэдээллийн нууцлал
- Судалгаанд оролцогчдод үүсэх эрсдэл болон тэдний хүртэх үр шимийн үнэлгээ
- Ашиг сонирхлын зөрчил

Судалгааны үр дүнг хэвлэхийн тулд тухайн судалгаа нь заавал ёс зүйн хорооны зөвшөөрөлтэй байх ёстой.

**Судалгааны протоколыг ёс зүйн хороогоор хянуулж, зөвшөөрөл авах нь тодорхой цаг хугацаа шаардах үйл ажиллагаа тул ажлын төлөвлөлтөндөө үүнийг тусгах хэрэгтэй.**

**Дийлэнх улс орны Засгийн газар, их сургуулиуд ёс зүйн хороотой байдаг.**

МХД-ын асуулгын судалгаанд хүүхдийг оролцогчоор сонгосон бол ёс зүйн болон хамгааллын дараах зүйлийг харгалзан үзсэн байх ёстой:

- Асуулгын судалгаанд оролцох хүүхдүүдийн насны тохиромжтой доод хязгаар
- Ярилцлагын явцад хүүхэд хүчирхийллийн талаар мэдээлэл өгвөл холбогдох хүмүүст мэдээлэх, хариу арга хэмжээ авах гэх мэт удирдамж (Хүүхдийг оролцуулсан хүүхэд хамгааллын аливаа судалгаанд хамгааллын энэ асуудал хамгийн чухалд тооцогдох бөгөөд үүнийг урьдчилан сайтар төлөвлөсөн байна)
- Мэдээлэл өгсний үндсэн дээр хүүхэд, түүний асран хамгаалагчаас зөвшөөрөл авах үйл явцын удирдамж (хүүхдийн үндсэн асран хамгаалагч байхгүй тохиолдолд хэрхэн зөвшөөрөл авахыг мөн үүнд тусгана)
- Хүүхдийн мэдээллэлийг нууцлалыг хангах удирдамж
- Асуулгын судалгаанд оролцсон хүүхэд, түүний эцэг эхийн хүлээж буй дэмжлэгийг зохицуулах удирдамж
- Асуулгын судалгаанд оролцож буй хүүхдийн хүртэх үр шим, учирч болох эрсдэлийн үнэлгээ
- МХД-ын асуулгын судалгаан дахь оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хүүхдэд олгох урамшуулал
- Судалгаанд оролцсон хүүхдэд (ялангуяа ажил эрхэлдэг хүүхдэд) цагаа судалгаанд зарцуулсных нь төлөө өгөх төлбөр





Хүүхдийг Ивээх Сангийн ОУ-ын Эвслээс судалгаанд барих ёстой ёс зүйн хийгээд хамгааллын босго стандартыг тогтоосон байдаг (**Хүүхдийг Ивээх Сангийн Үнэлгээний гарын авлагаас** харна уу). Хүүхэд хамгааллын хөтөлбөрт МХД-ын асуулгын судалгаа хийхээр бол тэдгээр стандартыг анхааралтайгаар мөрдөх хэрэгтэй. Түүнчлэн асуулгын судалгааны зорилго, арга зүйд ёс зүйн асуудлыг тусгахаас гадна асуулгын судалгааны протоколд **мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрөл, мэдээллийн нууцлалыг хамгаалах**, судалгаанд оролцохын үр шим болон эрсдэлийг тусгах хэрэгтэй. Мэдээлэл өгсний үндсэн авах зөвшөөрлийн маягтыг боловсруулж, асуулгын судалгааны протоколд хавсаргана.

**Мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрөл:** Асуулгын судалгааны зорилго, оролцоход тавих шалгуур, эрсдэл, үр шимийг бүрэн дүүрэн мэдсэний үндсэн дээр судалгаанд оролцохоор зөвшөөрөхийг хэлнэ.

Асуулгын судалгааг чухам яагаад хийх болсон, ямар мэдээллийг тэднээс асуух, тэдний өгсөн мэдээллийг хэрхэн хэрэглэх талаар оролцогчид ойлгож мэдсэн байх ёстой. Түүнчлэн асуулгын судалгаанд оролцохоос татгалзах эсвэл судалгааны явцад хэдийд ч гарах эрхтэйгээ оролцогчид мэдсэн байх хэрэгтэй. Ерөнхийдөө ярилцлагыг хөтлөгч дээр дурдсан зүйлийг оролцогчид уншиж өгөх бөгөөд тухайн оролцогчид ижил агуулгатай маягт өгч, судалгаанд оролцохоор зөвшөөрч байгаа бол гарын үсгээ зурахыг хүсдэг. Хэрэв оролцогч бичиг үсэгт тайлагдаагүй бол хурууны хээгээ дарж ч болно. Мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрлийн маягтыг бичгээр гаргах ба хэрэв гарын үсэг зурах маягт нь соёлын хувьд тохиромжгүй бол аман зөвшөөрөл авч болно. Мэдээлэл өгсний үндсэн дээр зөвшөөрөл өгөх маягтын загварыг **Хавсралт Г**-ээс хараарай. Хүүхдийг судалгаанд оролцуулж байгаа бол хүүхэд, түүний хууль ёсны асран хамгаалагчаас зөвшөөрөл авна. **Хэрэв хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч байхгүйгээс зөвшөөрөл авч чадахгүй бол тухайн хүүхдийг судалгаанд оролцуулж болохгүй.**

**Нууцыг хадгалах:** Оролцогчдын өгсөн мэдээллийг нууцлах нь нэн чухал юм. Хүүхэд хамгаалал дахь МХД-ын асуулгын судалгаа нь ихэвчлэн хүүхэд эсвэл түүний гэр бүлийг эрсдэлд оруулж болзошгүй хувийн болон эмзэг асуултуудыг асуудаг. Судалгаанд оролцох зөвшөөрөл авахаас өмнө оролцогчдод тэдний өгсөн мэдээллийг нууцлана гэдгийг мэдээлэх ёстой.

**Нууц хадгалах** гэдэг нь хүний хувийн нууцыг хамгаалах үйл явц юм. Өгсөн мэдээллийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр бусдад задлахгүй гэх итгэлцлийн үндсэн дээр хувь хүний өгсөн мэдээлэлд хандахыг нууц хадгалах гэнэ. Хүний хувийн мэдээллийг хадгалах хэрэгцээ нь нийтийн сайн сайхны төлөө хувийн нууцыг задлах хэрэгцээний эсрэг байнга тавигдаж байдаг.

Оролцогчдын өгсөн мэдээллийн нууцыг хадгалахын тулд авах ёстой хэд хэдэн арга хэмжээ байдаг:

- Ярилцлагыг хөндлөнгийн хүнгүй газарт хийх
- Боломжтой бол маягтууд, асуултууд, мэдээллийн санд хүний нэр биш код ашиглах

- Мэдээлэл, нэн ялангуяа хувийн мэдээлэлтэй холбоотой материалуудыг хөтөлбөрийн юм уу судалгааны менежерийн зөвшөөрөлтэй ордог, цоожтой газар хадгалах. Компьютер дэх мэдээллийг нууц үг хийж хадгалах, ингэснээр хэн нэгэн мэдээлэлд нэвтрэх боломжгүй болно.

## Нууцлал ба хүүхэд хамгааллын бодлого

Асуулгын судалгаанд хүүхдийг хамруулах тохиолдолд нууцыг хадгалах зарчим болон Хүүхдийг Ивээх Сангийн хүүхэд хамгааллын бодлогын хооронд зөрчил үүсэж болно. Энэ асуудлыг МХД-ын асуулга судалгаа эхлэхээс өмнө шийдвэрлэх хэрэгтэй.

**Хүүхдийг Ивээх Сангийн хүүхэд хамгааллын бодлогод тусгаснаар тус сангийн бүх ажилтан, төлөөлөгч, хамтран ажилладаг байгуулагуудын албан хаагчид хүүхдийн хүчирхийлэл, бэлгийн мөжлөгтэй холбоотой батлагдсан болон сэжигтэй бүхий л тохиолдлыг тухайн улс орны журамтай холбоотойгоор 24 цагийн дотор мэдээлэх үүрэгтэй байдаг.**

МХД-ын асуулгын судалгааг хийх үедээ оролцогчийн өгсөн бүхий л мэдээллийг нууцална гэж амлан, зөвшөөрөл авах нөхцөлд нууцыг хадгалах зарчим болон хүүхэд хамгааллын бодлогын хоорондын зөрчил гардаг. Ярилцлагын явцад хүүхэд хүчирхийллийн талаар мэдээлэл өгсөн бол эсвэл мэдээлэл цуглуулагч хүүхдийн өгч байгаа мэдээллээс тухайн хүүхэд хүчирхийлэлд өртсөн хэмээн сэжиглэж байгаа бол тухайн мэдээлэл цуглуулагч хүүхэд хамгааллын бодлогын дагуу тэр кейсийг мэдээлэх ёстой. Асуулгын судалгааны явцад хүчирхийлэл, мөжлөгийн талаар хүүхдээс өөрөөс нь шууд асуух үед энэхүү зөрчил улам тодоор илэрч болно.

Хүүхдийн хүчирхийлэл, мөжлөгийн талаарх мэдээллийг хүлээн авсан Хүүхдийг Ивээх Сангийн холбогдох ажилтны хамгийн түрүүнд хийх зүйл бол хүүхдийн аюулгүй байдлыг нэн даруй хангаж, анхан шатны үйлчилгээг үзүүлэх явдал юм. Гэвч хүчирхийллийн талаарх мэдээллийг мэдсэн бол түүнийг мэдээлэх ёстой мөртлөө хүүхдийн өгсөн бүх мэдээллийг нууцална гэж амлах нь ёс зүйгүй хэрэг.

Энэхүү зөрчлийг шийдвэрлэх арга бий. Либерт, МХД-ын асуулгын судалгааны багийнхан өгсөн бүх мэдээллийг нууцална, гэхдээ хүүхэд аюултай байдалд байвал нууцлахгүй гэдгийг оролцогчдод мэдээлсэн байна. Яг ижил мэдээллийг хүүхдүүдийн асран хамгаалагчдаас зөвшөөрөл авахдаа өгчээ.

Хүүхэд хамгааллын бодлогыг харгалзан үзсэн зөвшөөрлийн хуудсанд ашиглаж болох текстийн санааг дор үзүүлэв.

*"Хэрэв энэ судалгаанд оролцохоор зөвшөөрвөл чамд асуултууд тавьж, өгсөн хариултуудыг чинь тэмдэглэж авна. Асуух асуултууд нь чиний төрж, өсөж буй гэр бүл, эргэн тойрны орчны тухай. Мөн хүүхдээ асран халамжлахад гэр бүлүүдэд хэрхэн туслах чиний санаа бодлыг асууна. Зарим асуултад хариулахад ичмээр эсвэл хэцүү байвал хариулахгүй байж болно гэдгийг бүү мартаарай. Бас хэлсэн бүх зүйлийг чинь нууцлах болно. Чиний өгсөн мэдээллийг зөвхөн ахлагчдаа үзүүлнэ. Чиний нэрийг чинь тавихгүй учраас чиний өгсөн мэдээлэл гэж мэдэгдэхгүй. Харин чиний өгсөн хариултаас чамайг аюултай нөхцөл байдалд орж магадгүй эсвэл орчихсон байгааг мэдвэл чамд тусалж чадах хүмүүст би мэдээлэх ёстой."*

Хүүхэд хамгаалалд МХД-ын асуулгын судалгааг хийх үед ёс зүйн болон хүүхэд хамгааллын асуудалд нэлээд няхуур хандах хэрэгтэй байдаг. Тийм учраас асуулгын судалгаа хийхээр төлөвлөж байгаа бол ёс зүйн болон хүүхэд хамгааллын бодлогыг хэрхэн зохицуулахаа сайтар бодох хэрэгтэй. Ёс зүйн болон хүүхэд хамгааллын бодлогын талаар зөвлөгөө, дэмжлэг авъя гэвэл байгууллагынхаа хүүхдийн хамгааллын бодлого хариуцсан ажилтан, Хүүхдийг Ивээх Сангийн ОУ-ын эвслийн бүсийн болон олон улсын зөвлөхтэй холбогдоорой.

## Хүүхэд, залуусаас мэдээлэл цуглуулахад анхаарах асуудлууд

Хүүхэд, залуучууд өөрсдийнхөө хамгааллын талаар үнэтэй мэдээллийг өгч чадахаас гадна тэд ихэнхдээ асуулгын судалгааны хүн амын бүлэгт багтдаг. Хэрэв асуулгын судалгааны оролцогчоор хүүхэд сонгогдсон бол судалгааны ёс зүй, асуулгын боловсруулалт, ярилцлага авах аргачлалтай холбоотой анхаарах асуудлууд гарна.

## Ёс зүй

Хүүхдэд нөлөөлөх аливаа шийдвэрийн талаар түүнтэй зөвшилцөх, тэрхүү шийдвэрийн талаар мэдээлэл авах хүүхдийн эрхийг бид хамгаалах ёстой. Судалгаа, үнэлгээ, хөтөлбөр дэх хүүхдийн оролцоо нь түүний санал бодлыг харгалзан үзэх хангалттай шалтгаан юм. **Хүүхдээс мэдээлэл цуглуулах ёс зүйн стандартыг мөрдөх нь нягт нямбай байдал, анхаарал болгоомжийг шаардах бөгөөд тэгж чадсан тохиолдолд хүүхдийг хамгаалах, дээд ашиг сонирхлыг нь хангах боломж бүрдэнэ.**

**Заавал хийх зүйл:** Хүүхдийг судалгаанд хамруулахад тухайн улс оронд ёс зүйн ямар шаардлагууд байдаг, насанд хүрэх босго насыг олж мэдээрэй.

Судалгаанд даган мөрдөх ёс зүйн шаардлагын талаарх санал зөвлөмжийг жишээг дор үзүүлэв:

- ➔ Судалгаа хийх зайлшгүй шалтгаан, үндэслэл, хүүхдэд үзүүлэх үр шимийг сайтар тодорхойлох
- ➔ Хүүхдээс хүчин төгөлдөр мэдээлэл цуглуулж чадахуйц арга зүй сонгох
- ➔ Судалгааны явцыг хянахын тулд хөндлөнгийн бүлэг буюу зөвлөх хороог байгуулах
- ➔ Хүүхэд, залуучуудад гарч болох үр дагавар (эрсдэл болон үр шим)-ыг урьдчилан тооцоолох
- ➔ Хүүхэд хамгааллын бодлогыг ойлгомжтой, тодорхой гаргах (Хамгаалалтай холбоотой асуудал гарвал нууцыг хадгалах зарчмыг мөрдөхгүй байхаар тусгах хэрэгтэй. Хүүхдээс зөвшөөрөл авахаас өмнө тухайн хүүхэд аюултай нөхцөлд байгаа тохиолдолд түүнийг хамгаалах үүднээс холбогдох газарт мэдээлэх үүрэгтэй гэдгийг түүнд ойлгуулна.)
- ➔ Хүүхдийг асран халамжлах үүрэг бүхий насанд хүрсэн хүнээс болон хүүхдээс өөрөөс нь мөн зөвшөөрөл авах (Хүүхэд зөвшөөрөл өгөхдөө ярилцлаганд орохоос татгалзах, ярилцлагын дундаас орхих эрхтэй гэдгээ мэдсэн байх ёстой. Хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нь хүүхэдтэй хамт амьдрахгүй байгаагаас тэднээс зөвшөөрөл авах боломжгүй эсвэл эцэг эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл авах нь хүүхдэд эрсдэл үүсгэх гэх мэт онцгой нөхцөл байдал гарч болно. Ийм тохиолдол гарвал эдгээр хүүхдийг судалгаанд заавал оролцуулах хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг дахин үнэлнэ. Хэрэв шаардлагатай бол судалгааны протоколд тусган, зөвшөөрөл авна.)
- ➔ Арга зүй, судалгааны талаар мэдээлэл өгөх материалууд, ярилцлагын явцыг хүүхдийн насанд тохируулах, хүүхдийг эрсдэлд оруулахгүй байх, асуулгын судалгааны явцад хүүхдийг хамгаалах удирдамжийг боловсронгуй болгох
- ➔ Мэдээллийг хэрхэн хадгалах, хэрэглэх, түгээх талаар хүүхэд, түүний эцэг эхэд мэдээлж ойлгуулах
- ➔ Мэдээлэл цуглуулагчийн нэр, түүнтэй холбоо тогтоох мэдээллийг бүх оролцогч мэдсэн байх

Хүүхэд, залуучуудыг хамруулсан судалгаанд ёс зүйн асуудлыг хэрхэн анхаарах талаар Хүн амын зөвлөл цогц хийгээд тодорхой зөвлөмж гаргасныг дараах холбоосоор үзээрэй: *“Олон улсын түвшинд хүүхэд, өсвөр үеийнхнээс мэдээлэл цуглуулахад баримтлах ёс зүйн арга хандлагууд: Зөвлөмж ба нөөц”*




## Асуултын боловсруулалт

Хүүхдээс асуух асуултууд буюу асуулгыг боловсруулахдаа түүний танин мэдэхүйн болон харилцааны хөгжлийг харгалзах хэрэгтэй. Хүүхдэд зориулсан асуултуудын агуулга нь насанд хүрэгчдэд тавьж болох асуултуудтай төстэй байж болно, гэхдээ хүүхдийн аливаа зүйлийг ойлгох, эргэн санах, мэдээлэлтэй харилцах чадвар нь бүрэн хөгжөөгүй байдаг тул асуултуудыг дэлгэрүүлэн тайлбарласан байх нь чухал. Доктор Эдит Д. Лийувийн бичсэн “Асуулгын судалгааны үеэр хүүхэд, өсвөр насныхнаас авах мэдээллийн чанарыг сайжруулах нь: Танин мэдэхүйн болон харилцааны хөгжил, түүнийг асуулт боловсруулах, туршихад анхаарах нь” хэмээх тайланд асуулгын судалгааны асуултыг ойлгох, түүнд хариулах хүүхдийн чадварт түүний хөгжлийн үзүүлэх нөлөөллийг тайлбарласнаас гадна хүүхдээс асуух асуултуудыг боловсруулах, туршихад анхаарах зүйлийн талаарх практик зөвлөмжүүдийг өгсөн байдаг. Тэрхүү тайлан (Эдит Д. Лийув, 2001)-гаас зарим зөвлөмжийг дор танилцуулъя:

- ➔ Асуултыг сөрөг утгаар томъёолохоос зайлсхийх
- ➔ Асуултын хариултын хувилбарууд, Лайкертын шкал эсвэл эрэмбэлэх асуултын түвшнийг аль болох бага байлгах
- ➔ Асуултууд хоёрдмол утгагүй байх
- ➔ Хүүхдүүд аливаа үг, өгүүлбэрийг шууд утгаар нь хүлээж авдаг учраас “Ихэнх хүүхэд ...” гэх мэтээр асуултыг өөр үгээр эсвэл хийсвэр үгээр орлуулан хэрэглэхгүй байх
- ➔ Хүүхдийн ой санамж бүрэн хөгжөөгүй байдаг учраас хүүхдээс аливаа юмыг эргэн санахыг шаардсан өнгөрсөн үе, цагийн юмыг асуухаас зайлсхийх
- ➔ Энгийн мөртлөө тодорхой заавар өгөх
- ➔ Хүүхдүүд “зөв” хариулт хайх хандлагатай байдаг учраас асуултад хариулахад нь зөвлөхдөө анхааралтай хандах
- ➔ Хариултын карт (аз жаргал гэх хэмжүүрээр хүүхдээс хариулт авахдаа инээмсэглэсэн эсвэл гунигтай царай бүхий карт үзүүлэн, сонгуулах) гэх мэт бодитой өдөөгч ашиглах (Хүүхдүүд ихэвчлэн хариултуудын хувилбаруудыг мартаж хандлагатай байдаг)
- ➔ Тоон илэрхийллээр хариулах асуултыг хүүхдээс асуухаас зайлсхийх

## Ярилцлага авах аргачлал

- ➔ Мэдээлэл цуглуулагч буюу ярилцлагыг хөтлөгч нь хүүхэдтэй ажилласан туршлагатай байх, түүнчлэн ярилцлага хийх арга зүй болон хүүхэд хамгааллын бодлогын чиглэлээр бэлтгэгдсэн байна.
- ➔ Ярилцлагыг аль болох богино, сонирхолтой хэлбэртэй байхаар хөтлөх, ингэснээр хүүхдүүд уйдаж залхах, сэдлээ алдах асуудал гарахгүй (Асуултаа тавихдаа тоглоомын аргыг ашиглах гэх мэт).
- ➔ Эргэн тойрны орчинд анхаарлаа хандуулж, ярилцлага хийх явцад тухайн хүүхдийн дүү, эцэг эх эсвэл багш нь хажууд байна уу, байвал энэ нь асуултын хариултуудад хэрхэн нөлөөлж болох вэ гэдгийг бодож, анхааралтай хандана.
- ➔ Ярилцлагын үед ярилцлагыг хөтлөгч (мэдээлэл цуглуулагч) болон хүүхэд хоёр харааны хувьд ижил түвшинд байна.
- ➔ Ярилцлагыг явуулахдаа хүүхдэд аль болох тухтай, амар байхад анхаарах, ярилцлага бол шалгалт биш гэдгийг ойлгуулахад анхаарна.





## 2.3. Ажлын төлөвлөгөө гаргах

Ажлын төлөвлөгөө гэдэг нь асуулгын судалгаа, түүний үе шат бүрийн үйл ажиллагаа, түүнийг гүйцэтгэх цаг хугацаа, хариуцах хүмүүсийн хамт гаргасан жагсаалт юм. Асуулгын судалгаанд ашиглаж болох ажлын төлөвлөгөөний энгийн загварын жишээг **Хавсралт Д**-ээс хараарай. Ажлын төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагаануудыг хийх цаг хугацааг өдрөөр тооцвол түүнд үндэслэн төсөв гаргах, асуулгын судалгаанд ажиллах хүмүүсийг сонгон авах ажлын даалгавар боловсруулахад хэрэг болно.

Асуулгын судалгааны протоколыг ёс зүйн хороонд танилцуулж, зөвшөөрөл авах гэж байгаа бол уг ёс зүйн хорооны хуралдах өдөр, шийдвэр гаргах дундаж хугацааг тооцсоны үндсэн дээр ажлын төлөвлөгөө гаргах хэрэгтэй. Зарим орны хувьд ёс зүйн зөвшөөрөл бараг зургаан сарын хугацаанд гардаг бөгөөд зөвшөөрөл авахаас нааш судалгааг эхлүүлэх боломжгүй юм.

Ажлын төлөвлөгөө гаргахдаа асуулгын судалгааны үйл ажиллагаатай холбоотой ажилд наад зах нь гурван сар, үүний цөөн хэдэн долоо хоногийг мэдээлэл цуглуулахад зориулах хэрэгтэй. Асуулт боловсруулах, судалгаанд хамрагдах газар зүйн бүсийг тодорхойлох, зөвлөх болон ажилтнуудыг сонгон шалгаруулах, тэднийг сургах гэх мэт асуулгын судалгааны мэдээлэл цуглуулахаас өмнөх бэлтгэл ажилд маш их цаг хэрэгтэй болно. Түүврийн хэмжээ, газар зүйн байршил, мэдээлэл цуглуулах багийн гишүүдийн тооноос хамааран мэдээлэл цуглуулахад 2–4 долоо хоног хэрэгтэй. Гэхдээ мэдээлэл цуглуулахад нэг сараас илүүгүй хугацаа зарцуулахаар ажлын төлөвлөгөөнд тусгах нь зөв. Учир нь мэдээлэл цуглуулах хүмүүс үүнээс урт хугацаагаар ажиллавал ядарч залхах, улмаар мэдээллийн чанарт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

Магистр, докторын түвшинд суралцаж буй оюутнуудыг мэдээлэл цуглуулагч, мэдээллийг программд оруулах ажилтнаар асуулгын судалгаанд авахад тохиромжтой байж болно. Тэдгээр оюутны хувьд богино хугацаагаар ажиллах, туршлагатай болохын тулд иймэрхүү ажлыг их сонирхдогтоос гадна тэднийг сургахад амар байдаг. Гэхдээ өмнө нь асуулгын судалгаанд, нэн ялангуяа хүүхэд хамруулсан судалгаанд ажиллаж байсан туршлагатай хүнийг мэдээлэл цуглуулагчаар сонгох нь чухал.

**Мэдээлэл цуглуулж дуусмагц тэдгээрийг программд оруулан, цэвэрлэхийг зөвлөж байна.** Энэ нь цаг хэмнэхээс гадна мэдээллийг дахин хянаж, баталгаажуулах, асуулт эсвэл мэдээлэл цуглуулагчаас үүдсэн чанарын асуудлыг “ямааны мах халуун дээр нь” засварлах боломж өгдөг. Ийнхүү мэдээлэл оруулж, цэвэрлэж дуусмагц дүн шинжилгээ хийх, тайлан бичих ажлыг эхлүүлнэ.

## 2.4. Төсөв боловсруулах

Асуулгын судалгаа хийхэд байгууллага доторх хүмүүсээс гадна гаднаас авах хувь зөвлөх, гэрээт ажилтнуудын хөдөлмөрийн хөлсийг тооцсон бүхий л өртгийг тооцож, төсөв боловсруулна. **Хавсралт Б**-д төсөв боловсруулах загварыг үзүүлсэн болно.

Төсөв боловсруулахад зайлшгүй тооцох ёстой гол зүйлийг дор жагсаан үзүүлье:

- Ажилтнуудын (байгууллага доторх) цалин хөлс
- Зөвлөх, гэрээт ажилтны өдрийн төлбөр (үүнд судалгааны дизайн гаргах, статистикийн дүн шинжилгээний хүрээ гаргах, сургалт хийх, мэдээлэл оруулах, дүн шинжилгээ хийх, тайлан бичих, тайланг хянан тохиолдуулах, асуултуудыг орон нутгийн хэлээр орчуулах гэх мэт багтана)
- Хангамжийн зардал
- Тоног төхөөрөмж (компьютер, принтер, мэдээлэл уншигч болон бусад)
- Харилцаа холбооны зардал (утас, интернет, факс)
- Аяллын зардал (тээвэр, томилолт, байр)
- Уулзалт-хурлын зардал (судалгааг төлөвлөх, ажилтнуудыг сургах, үр дүнг түгээх уулзалт-хурал)
- Асуулт, маягт бусад мэдээллийг хэвлэх зардал
- Ёс зүйн хорооны зөвшөөрөл авахад шаардагдах зардал (төлөх ёстой бол)
- Зохион байгуулалт болон бусад урсгал зардал

Дотооддоо байгаа хүний нөөцөөс гадна асуулгын судалгааны ялгаатай үе шатуудад гаднаас авч болох нөөц (мэдлэг туршлага, чадамж)-ийг харгалзаж үзээрэй.

МХД-ын асуулгын нэг судалгаанд ойролцоогоор 15,000 – 25,000 ам.доллар шаардагдана. Асуулгын судалгааны хүрээ, далайцаас хамааран 50,000 – 75,000 ам.доллар ч хэрэг болж болно. МХД-ын асуулгын судалгааг суурь үзүүлэлт тогтоох, мөн төгсгөлийн үнэлгээ хийх зорилгоор давтан хийхээр бол төслийн эсвэл хөтөлбөрийн төсөвтөө хоёр удаагийн зардлыг тусгахаа мартуузай.






## АЛХАМ 3: Судалгааны асуулга боловсруулах нь

### Үйл ажиллагаа

- 3.1. Асуулга боловсруулах
- 3.2. Асуулгыг бүтцэд оруулах (хэлбэржүүлэх)
- 3.3. Асуулгыг орчуулах
- 3.4. Мэдээллийн менежмент, дүн шинжилгээний төлөвлөгөө гаргах
- 3.5. Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг турших, эцэслэх

### Үр дүн

- ✓ Өмнөх судалгаануудад хэрэглэгдэж байсан асуултуудад анализ хийж, орон нутгийн онцлогт тохируулан өөрчилсөн асуулга
- ✓ Хэт эмзэг, субъектив шинжтэй сэдвүүдийг тодорхойлох, асуултуудын байж болох хариултын хувилбарууд, үг хэллэг, бичиглэлийн түвшнийг мэдэх зорилгоор хийсэн урьдчилсан судалгаа (фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага гэх мэт)
- ✓ Судалгааны асуултуудтай харьцуулан гаргасан асуултуудын жагсаалт (асуулга)
- ✓ Тухайн орон нутгийн хэлээр орчуулсан асуулга, түүний хүчин төгөлдөр байдлын чанар, түүнд нөлөөлж байгаа зүйлийг тодруулж, засварлахад зориулан анхны хэл рүү нь буцаан орчуулсан асуулга
- ✓ Асуулгын судалгааны баг болон зорилтот бүлгийн жижиг түүвэрт туршсан асуулга
- ✓ Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх төлөвлөгөө болон кодлол хийх удирдамж
- ✓ Кодлол, мэдээлэл оруулалтыг тооцож дахин бүтэцчилсэн асуулга





## АЛХАМ 3: Судалгааны асуулга боловсруулах нь



Асуулга (асуултууд) боловсруулах нь асуулгын судалгааны маш чухал шат тул үүнд цаг хугацаа, анхаарал нэлээд хэрэгтэй. **Хэрэв асуултууд алдаатай эсвэл асуултуудыг орон нутгийн онцлогт тохируулан өөрчлөхдөө анхааралтай хандаагүй, алдааг багасгах үүднээс хүчин төгөлдөр байдлыг нь шалгаагүй бол цуглуулсан мэдээлэл нь оролцогчдын үзэл хандлага, дадлыг харуулахаасаа илүү судалгааны арга хэрэгсэл (буюу асуултууд)-ын алдаа, сул талыг илэрхийлнэ.** Асуултуудыг томъёолсон үг хэллэг, бүтэц нь тухайн улс орны буюу орон нутгийн соёл, орчинд тохирсон байх нь нэн чухал бөгөөд асуултуудыг урьдчилсан судалгааны үндсэн дээр гаргаж, туршилтаар хүчин төгөлдөр байдлыг нь шалгасан байх хэрэгтэй. Түүнчлэн мэдээлэл цуглуулагчид болон оролцогчдод асуултуудыг ойлгоход хялбар, логик дэс дараалалтай болгохын тулд асуултуудыг тодорхой бүтэц, хэлбэрт оруулах хэрэгтэй. **Хавсралт Е-д МХД-ын асуулгын судалгааны асуултуудын жишээг оруулсныг хараарай.** Тэдгээр асуултуудын жишээг Либерийн Хүүхдийг Ивээх Сангийн хийсэн асуулгын судалгааны асуултуудаас авсан бөгөөд асуулт хэрхэн боловсруулах талаарх жишээг тэндээс харж болно. **Жишээ болгон үзүүлсэн асуултуудыг орон нутгийн онцлогт тохируулалгүй, мөн туршилгүйгээр шууд хэрэглэж болохгүйг анхаараарай.**

### 3.1. Асуулга боловсруулах

Орон нутгийн онцлогт тохируулан өөрчлөхгүй шаардлагагүй буюу бүх орны нөхцөлд тохирсон стандарт асуулга гэж байхгүй. Гэхдээ тухайн орны онцлогтой ижил улс оронд хийгдсэн асуулгын судалгааг судалгааны эхэн үед эх сурвалж болгон хэрэглэх боломжтой. **“Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа”-ны хүүхэд хамгааллын чиглэлийн асуултуудыг ялгаатай орны онцлог, соёлын нөхцөл байдалд таарахаар боловсруулж, хүчин төгөлдөр болгосон байдаг.** Энэхүү “Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа” нь хүүхдийн гэрлэлт, төрсний бүртгэл, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, бэлэг эрхтнийг зэрэмдэглэх практик, хөгжлийн бэрхшээл, хүүхдийн хүмүүжил, гэр бүлийн хүчирхийлэлд хандах хандлага зэргийг багтаадаг. Хүүхэд хамгааллын энэхүү сэдвүүдтэй холбоотой асуудлаар МХД-ын асуулгын судалгаа хийх гэж байгаа бол тухайн улс оронд хийсэн хамгийн сүүлийн “Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа”-г хянаж үзэхийг зөвлөж байна.

Асуулгын судалгааны асуултын маш олон төрөл бий. Тэдгээрийг одоо танилцуулъя.



**Зураг 10. Асуулгын судалгааны асуултын төрөл**

<p><b>Хаалттай төгсгөлтэй асуулт</b> МХД-ын асуулгын судалгааны асуулга нь ихэнхдээ хаалттай асуултуудаас бүрддэг. Хаалттай асуулт гэдэг нь өгөгдсөн хариултын хувилбаруудаас тухайн оролцогч өөрт тохирох нэг буюу хэд хэдэн хариулт сонгох замаар хариулдаг асуулт юм. Хаалттай асуулт нь энгийн мөртлөө статистикийн олон дүн шинжилгээ хийх боломж өгдөг ч хариултын хувилбаруудыг сайтар тодорхойлсон байхыг шаарддаг. Хаалттай асуулт нь шинэ мэдээлэл, түүний мөн чанарыг илрүүлж чаддаггүй.</p>						
<p><b>Тоон утгаар хариулагдах асуулт</b> Тасралтгүй тоон хэмжүүрээр (жишээ нь нас, жин, гэр бүлийн гишүүдийн тоо гэх мэт) эсвэл эсвэл тодорхой тооны интервалаар (жишээ нь насны бүлэг гэх мэт) мэдээлэл авах боломжтой хариулт бүхий асуултууд. Тоон утгаар хариулагдах асуулт нь дундаж (дундаж утга, моод, медиан)-ийг тооцох, бүлэглэх гэх мэт дүн шинжилгээ хийх боломж олгодог.</p>	<p>Хэдэн настай вэ?  _ _ _  настай</p> <p>Өнгөрсөн долоо хоногт хэдэн удаа махтай хоол идсэн бэ?  _ _ _  удаа</p>					
<p><b>Хоёр хувилбараас нэгийг сонгох суулт</b> Өгсөн хоёр хариултын хувилбараас нэгийг сонгох асуултыг хэлдэг. “Тийм эсвэл үгүй”, “Үнэн эсвэл худал”, “Санал нийлж байна эсвэл санал нийлэхгүй байна” гэсэн хоёр хариултаас нэгийг сонгох асуултыг асуулгын судалгаанд түгээмэл хэрэглэдэг. Ийм асуултад статистикийн шинжилгээ хийхэд хялбар бөгөөд оролцогчийн үндсэн мэдээлэл (нас, хүйс гэх мэт)-д суурилан бусад асуултын үр дүнтэй харьцуулан шинжилж болдог оролцогчид. Гэвч аливаа зүйлийг зөвшөөрөх нь эелдэг байдлын илэрхийлэл гэж ойлгодог улс оронд “Тийм эсвэл үгүй” гэсэн хариулттай асуулт нь тэр бүр бодит хандлагыг харуулахгүй байх талтай.</p>	<p>Хүүхдийг асран хамгаалах, түүний аюулгүй байдлыг нь хангах хуулийн талаар мэдэх үү?</p> <p>(1) Тийм, мэднэ (2) Үгүй, мэдэхгүй</p>					
<p><b>Нэрлэсэн асуулт</b> Өөр хоорондоо ялгаа бүхий хариултын олон хувилбартай асуулт. Асуултуудын хувилбаруудыг дугаарласан байх бөгөөд энэхүү дугаарлалт нь мэдээллийг дүн шинжилгээ хийх программд оруулахад л хэрэгтэй болохоос хариултын хувьд нөлөөгүй байдаг. Оролцогчид асуултыг уншиж өгөх, өгөхгүйгээс хамааран боломжит хариултуудын урдах дугаарыг ашиглах нь зохистой. Хэрэв асуултыг чанга уншиж өгөх тохиолдолд асуултын дугаарыг ашиглаагүйгээс оролцогчид “хамгийн сайн хариулт”-ыг л сонгох сэдэл төрүүлэх эсвэл боломжит хариултын хувилбарууд нь хангалтгүй учраас хариулалгүй орхих гэх мэт алдаа гарч болно. Хэрэв асуултыг “нээлттэй” мэт байдлаар тавьж байгаа бол хүчин төгөлдөр байдлыг нь хангахын тулд боломжит хариултын хувилбарыг гаргахад анхаарах хэрэгтэй (Хажуу талын жишээнд үзүүлсэн 5 дахь хариултын хувилбарыг хараарай).</p>	<p>Хүүхэд хүчирхийлэлд өртөж буйг мэдвэл Та юу хийх вэ?</p> <p>(1) Мэдээлнэ (2) Хүчирхийлж буй хүнд эсэргүүцэл үзүүлнэ (3) Хүүхдийг тайвшруулна (4) Чимээгүй өнгөрнө/Юу ч хийхгүй (5) Бусад (бичнэ үү) .....</p>					
<p><b>Эрэмбэлсэн асуулт</b> Эрэмбэлж хариулах асуулт нь асуултын нэг хариултын хувилбар нь нөгөө хувилбаруудтайгаа холбоотой байх ёстой. Эрэмбийн хэмжээ хамгийн ихдээ 4-5 байвал зохино. Үүнээс хэтэрвэл оролцогчид тоогоо алдах эрсдэл гарахаас гадна тухайн асуултад дүн шинжилгээ хийхэд төвөгтэй болдог. Хамгийн их эсвэл хамгийн бага ач холбогдолтой хариултыг гаргах нь хамгийн сонирхолтой дүн шинжилгээний хэлбэр юм.</p>	<p>Таны эргэн тойрны орчинд хамгийн их гардаг хүүхдийн сайн сайхан байдалд аюул учруулж буй гурван асуудлыг нэрлэнэ үү (1 бол хамгийн их гардаг асуудал).</p> <p>___ Хүүхдийн хөдөлмөр ___ Бэлгийн хүчирхийлэл ___ Тэжээлийн доройтол, өлсгөлөн ___ Мансуурал/архидалт ___ Бэлгийн харьцаанд эрт орох ___ гэх мэт</p>					
<p><b>Лайкертын шкал</b> Боломжит хариултуудын хувилбаруудыг интервалчилсан асуулт бөгөөд ийм төрлийн асуулт нь үзэл бодол, хандлагыг тодруулахад чухал. Оролцогчид асуултын боломжит хувилбаруудыг ойлгож байгаа эсэх, тэдгээр нь тэдний нөхцөлд тохирсон эсэхийг баталгаажуулахын тулд Лайкертын шкал бүхий асуултыг урьдчилан шалгах нь нэн чухал. Тэгш тоотой шкал нь эерэг эсвэл сөрөг хариултын хувилбарыг илэрхийлдэг бол сондгой тоотой шкал нь ихэвчлэн “төвийг сахисан” хувилбарыг илэрхийлнэ. Асуулт эсвэл тухайн орчны нөхцөл байдлаас хамааран “төвийг сахисан” хариултын хувилбарууд нь сонирхолтой үр дүн харуулах эсвэл оролцогчдыг төөрөгдүүлэхээс гадна эсвэл бүр хариултаа сонгож чадахгүй байгаа оролцогчдын ямар нэгэн бодолгүйгээр сонгодог хувилбар ч болдог. Либерт хийсэн асуулгын судалгаанаас харахад хүүхдүүд ихэвчлэн хөндсөн асуудлуудын талаар хар эсвэл цагаан гэсэн хоёр туйлт хандлагатай байсан бөгөөд хариултын хувилбаруудыг 3-аас дээш ангилсан тохиолдолд ойлгохгүй, төөрөлдөх нь их байжээ.</p>	<p>Дараах бодомжтой хэр зэрэг санал нийлж байгаагаа хэлнэ үү: Эцэг эхтэйгээ хамт амьдрахгүй байгаа хүүхдүүд ...</p>	<p>Санал огт нийлэхгүй байна</p>	<p>Санал нийлэхгүй байна</p>	<p>Санал нийлж байна</p>	<p>Санал бүрэн нийлж байна</p>	<p>Мэдэхгүй</p>
<p><b>Нээлттэй төгсгөлтэй асуулт</b> Нээлттэй төгсгөлтэй асуулт нь гэдэг нь хариултын хувилбаруудгүй асуулт юм. Оролцогчид асуултын хуудсанд байгаа зайнд өөрсдийн хариултаа бичих ёстой бөгөөд дараа нь дүн шинжилгээ хийх үед бичсэн хариулуудыг кодлодог.</p>						
<p>Жишээ нь: Танай орон нутагт хүүхдэд тохиолдож болзошгүй хамгийн том эрсдэл юу гэж бодож байна вэ?</p>						
<p>Оролцогч өөрийнхөө үгээр, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж байгаа учраас нээлттэй төгсгөлтэй асуулт нь тухайн оролцогчийн үзэл байдал, байр суурь, хариултын мөн чанарыг гүнзгий мэдэх боломж өгдөг. Хаалттай төгсгөлтэй асуулттай адилаар хариулуудыг хэрхэн кодлож тэмдэглэх, тайлбарлахыг мэдээлэл цуглуулагч шийднэ.</p>						

## Асуулгын судалгааны асуулга (асуулт) боловсруулах зөвлөгөө

- ➔ Асуулгын судалгааны зорилгоо санах: Тавьж буй асуулт бүр нь асуулгын судалгааны зорилготой нийцсэн, судалж буй асуудлуудтай холбоотой байх ёстой.
  - ➔ Эргэлзэж байвал орхих: Асуулт нь дүн шинжилгээ хийж буй гол асуудлуудтай холбоотой биш бол тухайн асуултыг заавал хэрэглэх албагүй.
  - ➔ Өнгөрсөн үйл явдал эсвэл ерөнхий мэдлэгийн талаар асуух бол тодорхой цаг хугацааны хүрээ, нөхцөл өгөх: Жишээ нь “өнгөрсөн нэг жилд” эсвэл “хамгийн сүүлийн сонгуулиас хойш” гэх мэт тодорхой цаг хугацааны хүрээ өгнө.
  - ➔ Асуултууд, тэдгээрийн хариултуудын хувилбаруудыг зохимжтой хэлээр томъёолохын тулд фокус бүлгийн ярилцлага болон ганцаарчилсан ярилцлага хийх гэх мэтээр чанарын аргыг хэрэглэх (урьдчилсан судалгаа)
  - ➔ “Зөв” хариулт зөвлөмжилсөн хөтлөх асуулт асуухаас зайлсхийх. Жишээ нь “Хүүхэд зодох нь буруу гэж ихэнх хүн боддог. Та үүнтэй санал нийлэх үү?” гэх асуулт.
  - ➔ Асуултад хариулахын тулд тухайн хариулагч хангалттай мэдээлэлтэй байгаа эсэхэд анхаарах
  - ➔ Асуултыг аль болох энгийн байлгах: Давхардсан сөрөг, ойлгоход төвөгтэй үг хэллэг ашигласан, урт өгүүлбэрээс зайлсхийх.
  - ➔ Төвлөрөх: Хариулагчийг төөрөгдүүлэхгүйн тулд нэг удаад нэг л сэдвийг хөндсөн асуулт тавих. Жишээ нь:
- ✗ Хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг мэдвэл хаана мэдээлэх ёстойг мэдэх үү, мөн Та үүнийг мэдээлэх үү?
- ✓ Асуултыг салгаж, хоёрдмол байдлаас зайлсхийх  
(1) Хүүхдийн эсрэг хүчирхийллийг хаана мэдээлэхээ мэдэх үү? (тийм эсвэл үгүй гэсэн хариултын хувилбар)  
(2) Хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг мэдвэл Та юу хийх вэ? (хариултын олон хувилбарууд)
- ➔ Нэг асуултад хариултын хэт олон хувилбар гаргахаас зайлсхийх: Зургаагаас илүү хариултын хувилбар байвал хариулагчид олон зүйлд төөрөлдөхөөс гадна мэдээлэл цуглуулагчийн хувьд зөв кодлоход асуудал гарч болно. Хэрэв хариултын олон хувилбар байгаа бол тэдгээрийг бүлэглэх аргыг хэрэглээрэй.
  - ➔ Олон хариулт авах: Хариултын олон хувилбартай асуултад нэгээс дээш хариулт авах боломж байгаа эсэхийг тооцох. Хэрэв нэг асуултад олон хариулт авахаар шийдвэл хэдэн хариулт авах, тэдгээрийг хэрхэн бүртгэх, кодлох, шинжлэх зэргийг урьдчилан бодсон байх ёстой.
  - ➔ Шкал болон индексийг тогтоох: Нэн ялангуяа мэдлэг, хандлагыг хэмжих тохиолдолд тодорхой асуултуудыг ашиглан дүн шинжилгээг том зургаар нь хийх шкалыг тогтоох боломжтой. Жишээ нь хүүхдийн эрхийн ялгаатай талуудын талаарх мэдлэгийг үнэлсэн таван асуултын хариултад дүн шинжилгээ хийхдээ дангаар нь эсвэл нийлүүлэн нэг цогц мэдлэгийн шкал болон индекс тогтоох байдлаар ашиглаж болно.

Асуулгын судалгааны судлах асуудлуудыг өөр салбарын судалгаанд хөндсөн байх талтай учраас тийм судалгаануудыг олж, эх сурвалж болгон ашиглах хэрэгтэй. Эрүүл мэнд, хоол тэжээлтэй холбоотой сэдвүүдээр стандарт арга зүй, асуулгууд гарчихсан байдаг. Тиймээс хоол тэжээл, дэглэм, хооллох дадал, эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зэргийн мэдлэг, дадлын талаарх мэдээлэл хайж байгаа бол хүн ам зүйн болон эрүүл мэндийн судалгаа, ХДХВ/ДОХ-ын судалгаа зэрэг үндэсний хэмжээний судалгаанаас гадна орон нутгийн түвшинд явагддаг “СМАРТ” (хоол тэжээлийн стандарт судалгаа) судалгаа зэргийг үзээрэй. Эдгээр эх сурвалжаас нийгэм-хүн ам зүйн холбогдолтой стандарт асуултуудыг өөрийн судалгааны нөхцөлдөө тохируулан өөрчилж ашиглаж болно.

### **Заавал хийх зүйл: Асуулгын судалгааны зорилгоо марталгүйгээр судалгааны асуулт тус бүрд хариулт олж болох асуултуудын жагсаалт гаргаарай.**

Судалгааны зорилготой шууд холбоотой, боловсруулж эсвэл хэрэгжүүлж буй хөтөлбөрт зайлшгүй хэрэг болох мэдээллийг л цуглуулна. “Хөтлөх” (тухайн нэг хариулт руу хөтөлсөн асуулт) эсвэл **эргэлзээ** төрүүлэх асуултаас зайлсхийж, шаардлагатай мэдээллийг хамгийн объектив байдлаар илрүүлэх асуултыг томъёолоход анхаарна.

**Хүчин төгөлдөр байдал гэдэг нь мэдээлэл цуглуулах стратеги, арга хэрэгсэл нь хэмжих ёстой зүйлээ хэмжиж байгаа эсэхийг харуулах зэрэг буюу түвшнийг хэлнэ.**



### Асуултыг энгийн, ойлгомжтой, нэг удаад л нэг л мэдээлэл асуусан

**байхаар боловсруулна.** Энгийн нэг асуултад хүн бүрийн хувьд ялгаатай тайлбар өгч болно. Жишээ нь “Таны хүүхдүүд ажилладаг уу?” гэсэн асуултыг зарим оролцогч гэрийн ажилд туслах гэсэн талаас нь ойлгох бол зарим нь сурах, тоглохыг ажилд оруулахгүй байх, аль эсвэл ажил гэдгийг цалинтай ажлаар төсөөлж болно. Ийм асуултад “тийм эсвэл үгүй” гэсэн хариулт авах нь хүчин төгөлдөр бус мэдээлэл авлаа гэсэн үг. Тийм учраас асуултыг салган тодорхой болгож, хийсвэр нэр томъёог хэрэглэхгүй байх ёстой.

“Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа” нь 5–14 настай хүүхэдтэй өрхүүдээс хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бүлэг асуулт тавьдаг бөгөөд зарим жишээг дор үзүүлье:

1. Өнгөрсөн долоо хоногт (хүүхдийн нэр) энэ өрхийн гишүүн бус хэн нэгэнд ажил хийж өгсөн үү?
2. Өнгөрсөн долоо хоногт (хүүхдийн нэр) гэртээ худгаас ус авч, түлээ хагалсан уу?
3. Өнгөрсөн долоо хоногт (хүүхдийн нэр) өрхийн ферм, бизнест туслах эсвэл гудамжинд юм зарах гэх мэтээр цалинтай эсвэл цалингүй ажил хийсэн үү?
4. Өнгөрсөн долоо хоногт (хүүхдийн нэр) дэлгүүрээс хүнс цуглуулах, гэр цэвэрлэх, хувцас угаах, хоол хийх, хүүхэд харах, өвчтэй хүн асрах гэх мэтээр гэрийн ажилд тусалсан уу?

Хэрэв хариулагч (ярилцлага өгөгч, судлуулагч) дээрх асуултуудад тийм гэж хариулбал өнгөрсөн долоо хоногт тухайн ажилд хэдэн цаг зарцуулсан талаар салбарлуулан (үргэлжлүүлэн) асуудаг.

(Долоо хоногийн тэр өдрөөс) хойш ойролцоогоор хэдэн цагийг (ажлын төрөл) ажилд зарцуулсан бэ?

Иймэрхүү арга техник нь хоёрдмол байдлыг арилгах эсвэл оролцогч нэг зүйлийг олон янзаар ойлгож хариулах байдлыг бууруулахаас гадна хүүхдийн хөдөлмөрийн төрлүүд, тэдгээрт зарцуулж байгаа цагийг сурах, тоглох, сургуульд явах бусад үйл ажиллагаатай холбоотойгоор дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлж байна.

**Алдаа гэдэг нь аливаа хэмжилтийн аргыг хэтрүүлэн эсвэл сул үнэлэх байдлаас үүдэлтэй гардаг алдаа.**



## Хүүхдийн оролцоо

Хүүхэдтэй ярилцахад төвөгтэй эсвэл эмзэг сэдвүүдийг хэрхэн хөндөх талаар ойлголт мэдээлэл авахын тулд хүүхдүүдтэй фокус бүлгээр ярилцах нь хамгийн оновчтой арга юм. Түүнчлэн эрсдэл эсвэл ажил хөдөлмөр гэх мэт асуудлуудыг хүүхдүүд хэрхэн тодорхойлж байна, тэдгээртэй холбоотой асуултуудыг тэд өөрсдийнхөө үгээр хэрхэн гаргаж байна гэдгийг мэдэхийн тулд фокус бүлгийн ярилцлага хийж болно. Хүүхдүүдийн өгсөн мэдээллийг нөхцөл байдалд тохирсон асуултууд боловсруулахад хэрэглэнэ.

- ➔ Тодорхой насны бүлгийн 4–8 хүүхдийг цуглуулан 1–1.5 цагийн хугацаатай ярилцана. Асуулгын судалгааны зорилго, яагаад тэдэнтэй ярилцаж байгаагаа тайлбарлана. Судалгааны асуултыг нэг нэгээр ээлжлэн тавьж, түүнд хариулт олж болох асуултуудыг гаргахыг хүүхдүүдээс хүснэ. Дараа нь тэр асуултуудаа бие биедээ тавьж туршина. Фокус бүлгийн чиглүүлэгч энэхүү үйл ажиллагааг тоглоом хэлбэрээр явуулж, хүүхдүүдийн гаргасан бүх асуултыг тэмдэглэж авна.

**Мэдлэг, хандлага, дадалтай холбоотой асуултын хариултад сэтгэл зүй болон нийгмийн нарийн динамик нөлөөлж байдаг.** Сайн асуулгын судалгаа нь асуултыг олон янзаар тавих замаар үнэн зөв байдлыг давхар шалгаж, хүчин төгөлдөр болгодог.

Асуулгын судалгааны асуултуудыг боловсруулахад зохистой үг хэллэгийг сонгох нь нэн чухал. **Асууж буй зүйлийг ойлгож байж л хариулна. Судалгааны зорилтот хүн амын бүлгийн гишүүдийг оролцуулан фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагыг хийх замаар явагддаг урьдчилсан судалгаа нь асуултыг томъёолох зохистой үг хэллэгийг тодорхойлоход туслахаас гадна хэт эмзэг эсвэл тодорхой алдаанд хүргэж болох сэдвүүдийг илрүүлж өгдөг.** Зохистой үг хэллэгийг сонгон хэрэглэснээр хэт эмзэг сэдвүүдийн талаар удиртгал мэдээлэл өгөхөд хэрэг болох ба үр дүнд нь оролцогчид ярилцлагын явцад цочирдохгүй, тав тухтай байх нөхцөл үүснэ. Хувь хүний зан үйл, санал бодлыг асуух үедээ эмзэг асуултуудыг удиртгал хэллэг ашиглан тухайн хувьд шууд хандсан бүс хэлбэрээр асууна. Жишээ нь:

“Хүүхэд тань зүггүйвэл та түүнийг зоддог уу?” гэж шууд асуухын оронд объектив байдлаар удиртгал хэллэг ашиглан дараах байдлаар асууж болно:





“Олон хүн хүүхдүүдээ хүмүүжүүлэхийн тулд зодож шийтгэх аргыг хэрэглэдэг. Хэрэв хүүхэд тань таны үгэнд орохгүй байвал та түүнийг зодож шийтгэх үү?”

Эсвэл асуултаа нээлттэй асуулт болгож болно, эсвэл хариултын хувилбарууд өгч болно (ярилцлагыг хөтлөгч уг асуултыг чанга унших шаардлага гарч магадгүй бөгөөд оролцогчийн хариултыг дугуйлан тэмдэглэнэ):

“Хүүхэд тань үгэнд орохгүй байгаа бол түүнийг яаж хүмүүжүүлэх вэ?”

**Хүүхдүүд танин мэдэхүйн болон нийгмийн хөгжлийн хувьд харилцан адилгүй үе шатанд байдаг бөгөөд энэ нь асуулгын судалгааны асуултуудыг хэрхэн ойлгож, хариулахад нөлөөлдөг. Дээр дурдсан анхаарах зүйлээс гадна хүүхдээс асуух асуултыг боловсруулахдаа түүний ойлголтын түвшин, харилцааны чадвар, сонирхол, анхаарлын түвшин, хам орчинд мэдрэг байдлыг нь харгалзахад онцгойлон анхаарах ёстой.**

### **Хариултын хувилбаруудыг боловсруулах**

Хариултын хувилбарууд нь тоон дүн шинжилгээний суурь болох тул үүнийг маш анхааралтай боловсруулах хэрэгтэй. Хариултын хувилбарууд нь өөр хоорондоо хамааралгүй байх (жишээ нь агуулгын давхардалгүй эсвэл нэг цаг хугацаанд аль аль нь үнэн байх боломжгүй гэх мэт)-аас гадна байж болох цөөн тооны хувилбаруудад сонгох магадлал бүхий бүх хариултын хувилбар багтсан байх ёстой. Асуултуудаа туршдагийн адилаар асуултуудын хувилбаруудыг ч гэсэн шалгаж, тэдгээр нь оролцогчдод ойлгомжтой эсэхийг баталгаажуулах хэрэгтэй. Жишээ нь Либерт асуулгын судалгааны асуултуудыг туршин үзэхэд хүүхдүүдийн хувьд **Лайкертын шкал** (санал нийлж байна, санал бүрэн нийлж байна, санал бүрэн нийлэхгүй байна гэх мэт)-ын 2-3 хариултын хувилбарыг хооронд нь ялгаж чадахгүй байгаа нь тогтоогдсон. Тийм учраас асуултад хариултын олон хувилбар байх тусам нэг талаас хүүхдүүдийг төөрөгдүүлэх, нөгөө талаас дүн шинжилгээ хийхэд хүндрэл учирч болно.

**Нэг асуултад нэг эсвэл түүнээс олон хариулт сонгож болох эсэхийг хэрхэн дүн шинжилгээ хийхээ бодож байж шийднэ.** Энгийнээр хэлбэл хаалттай төгсгөлтэй нэг асуултад зөвхөн нэг л хариулт авах бол түүнд хийх дүн шинжилгээ нь хамгийн хялбар бөгөөд тодорхой байдаг ч бүх асуултыг ийм байдлаар тавих нь зохимжгүй.

Асуулгын судалгааны асуулт тус бүрд “мэдэхгүй”, “бусад”, “хариулмааргүй байна” гэсэн хариултын хувилбарыг оруулахыг зөвлөж байна. Эдгээр хувилбар байхгүй бол тухайн оролцогч хангалттай мэдээлэлгүй байхад эсвэл өгсөн хувилбарууд нь оролцогчийн нөхцөл байдал, санал бодолтой нийцэхгүй байхад нь хариулахыг хүчилж байгаа хэрэг бөгөөд улмаар судалгаанд алдаа үүснэ. Түүнчлэн “мэдэхгүй”, “хариулмааргүй байна” гэсэн хариултуудын тоог гаргах эсвэл “бусад” хувилбарыг мэдэх нь дараа нь дүн шинжилгээ хийх, үр дүнг тайлбарлахад чухал ач холбогдолтой байж ч болно. Хүүхэд болон насанд хүрэгчдээс хүүхэд хамгааллын талаар эмзэг асуулт тавих үед “хариулмааргүй байна” гэсэн хувилбар байх нь тун чухал. Зарим оролцогчийн хувьд хувийн асуудлаа ярих нь таагүй санагдаж болох тул зарим асуултад хариулахгүй байх боломж олгох нь зүйтэй. Хэрэв олон тооны оролцогч тодорхой асуултад хариулахаас татгалзаж байвал судалгааны үр дүнг зөв тайлбарлахын тулд үүнд дүн шинжилгээ хийхээс гадна дараа дараагийн судалгаанд зориулан хариулахаас татгалзаж байгаагийн шалтгааныг эрэлхийлэх, хариултын түвшнийг хэрхэн нэмэгдүүлж болох талаар ажиллах нь зүйтэй.

## 3.2. Асуулгыг бүтцэд оруулах (хэлбэржүүлэх)

**Асуулга нь мэдээлэл цуглуулж буй хүмүүст зааж ойлгуулахад хялбар байх ёстой.**

Асуулгын бүтцийг гаргаж, засан сайжруулахад цаг нэлээд шаардагдах бөгөөд өгсөн заавар ойлгомжтой, асуултуудын дараалал болон алгасалт тодорхой байх ёстой.

**Алгасалт** гэдэг нь тухайн асуулт оролцогчид хамаатай эсэхийг тодорхой асуултаар шүүж тодруулан, асуултын дэс дарааллыг тогтоох үйлдэл юм. Жишээ нь гэрлэсэн эмэгтэйд л хамаарах бүлэг асуулт байгаа бол эхлээд “Та гэрлэсэн үү?” гэж асуух бөгөөд хэрэв тийм гэж хариулсан бол мэдээлэл цуглуулагч “Гэрлээд хэд жил болж байна вэ?” гэх мэт дараагийн асуултуудыг үргэлжлүүлэн асууна. Хэрэв “Та гэрлэсэн үү?” гэсэн асуултад үгүй гэж хариулсан бол гэрлэлттэй холбоотой бүлэг асуултыг алгасан, дараагийн бүлэг асуултыг асууна.

Асуулга нь заавал удиртгал хэсэгтэй байх бөгөөд үүнд мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрөл заавал багтана.

**Хавсралт Е-д** загвар асуулга (асуултууд) үзүүлснийг хараарай. Асуулгад дараах зүйл заавал орсон байх ёстой:

- ✓ Асуулгын хуудас бүрийн дугаар эсвэл код
- ✓ Ярилцлагыг хөтлөгч буюу мэдээлэл цуглуулагчийн нэр
- ✓ Ярилцлагын огноо, цаг, байршил
- ✓ Мэдээллийг хянах, цэвэрлэх, программд оруулах ажилтанд зориулсан зай, мэдээллийг оруулсан огноо
- ✓ Ярилцлагыг хөтлөгч буюу мэдээлэл цуглуулагчид зориулсан ойлгомжтой, тодорхой зааварчилгаа, удирдамж (үүнд мэндлэх, мэдээлэл өгсний үндсэн дээр зөвшөөрөл авах, асуулт асууж, хариулт авах, алгасах гэх мэт орно)
- ✓ Хуудасны тоо

Дурдах шаардлагагүй зүйл мэт санагдаж магадгүй ч сайн үдээс ашиглахгүй бол асуулгын хуудаснууд салж унах, гээгдэх, холилдох эрсдэл бий. Хэрэв үдээс эвдэрч, хуудаснууд салбал тэдгээрт тэмдэглэгээ хийж, холилдохоос сэргийлнэ.

Асуулга дахь асуултуудыг бүлэг сэдвүүдээр нь ангилбал нэн зохимжтой. Асуулгын судалгааны судлах асуудлуудаар ангилал үүсгэж болохоос гадна асуулгын судалгааны оролцогчдын ялгаатай бүлэгт бүрд зориулсан хэсгүүдийг ч үүсгэж болно.

Асуултуудын дэс дарааллыг тогтоохдоо баримтлах зарчмын хувьд хариулахад хялбар, хэт хувийн шинжтэй биш асуулт (нийгэм-хүн ам зүйн асуултууд) –аас ярилцлага эхэлнэ. Ингэснээр оролцогчид ярилцлагад дасах, улмаар хүнд эсвэл хэт нарийн, эмзэг асуулт асуухаас өмнө оролцогчийг ярилцлага хөтлөгчид мэдээлэл өгөх хэвийн нөхцөлийг бий болгох боломж үүсдэг. Асуултуудын дэс дарааллыг тогтоохдоо дараах зарчмыг ашиглана:



Хүүхдүүдийг асуулгын судалгаанд оролцуулсан, нэн ялангуяа асуултууд нь хэт хувийн шинжтэй асуудлыг хөндсөн бол асуултуудаа эерэг сэдэв эсвэл асуултаар дуусгахыг зөвлөө. Ингэснээр судалгаанд оролцсон хүүхдүүд эерэг бодолтой үлддэг. Жишээ нь ярилцлагын төгсгөлд хүүхдээс түүний ирээдүйн талаарх бодол, итгэл эсвэл амьдардаг орчныхоо төлөө хийж болох сайн зүйлийнх нь талаар асууж болно.

### Асуулгын хуудсан дээр асуултуудыг кодлох

Асуулгын судалгааны хариултуудыг тоон утгаар нь шинжлэхийн тулд мэдээллийг программд оруулахаас өмнө тоон бус утгын мэдээллийг давтагдашгүй тоогоор кодолно. Асуулгын хуудсанд буй асуулт тус бүрийг кодлох бөгөөд энэ нь мэдээллийг программд оруулах, дүн шинжилгээ хийхэд бэлтгэж байна гэсэн үг.

Хувьсагч тус бүрийн хариултын хувилбаруудыг тоон утгаар илэрхийлсэн кодын бүртгэлийн дэвтэр гаргавал зохино. **Хэсэг цаг хугацааны дараа мэдээллээ эргэн харах, мэдээлэлтэй хэрхэн ажилласнаа эргэн санахад энэхүү кодын бүртгэлийн дэвтэр нь чухал баримт бичиг болно.** Түүнчлэн өөрчлөлтийг хэмжих зорилгоор асуулгын судалгааг тодорхой хугацааны дараа дахин явуулахаар бол энэхүү дэвтрийг ашиглан өөр хүмүүс мэдээлэлтэй ажиллах боломжтой болдог. Ерөнхийдөө хариултын хувилбар тус бүрийг асуулгын хуудсан дээр тоогоор кодлох нь мэдээллийг программд оруулах ажлыг хялбар болгодог. Жишээ нь хариултын хоёр хувилбартай асуулт (тийм эсвэл үгүй гэх мэт) байлаа гэхэд хариултын хувилбаруудыг дараах байдлаар кодолно:

**Энэ жил хүүхэд тань өвдсөн үү?**

**“Тийм” = 01**

**“Үгүй” = 00**

Дээрх асуултын хариуг программд оруулахад систем дээр “тийм” эсвэл “үгүй” гэсэн үгэн хариулт биш харин тухайн хариултыг илэрхийлсэн тоон код харагдана гэсэн үг. Тийм учраас код тус бүрийн цаана буй мэдээллийг ойлгох, харах, дүн шинжилгээ хийхэд кодын бүртгэлийн дэвтэр амин чухал.

Хариултын олон хувилбартай асуултын хувьд хувилбар тус бүрийг 01-ээс эхлэн кодолно. Мөн асуулт бүрд “мэдэхгүй” эсвэл “хариулмааргүй байна” гэсэн хувилбарыг оруулах ёстой. Үүнийг дараах байдлаар кодолно:

**“Мэдэхгүй” = 88**

(88 гэсэн тоог “мэдэхгүй” гэсэн хариултыг кодлоход түгээмэл ашигладаг бөгөөд хоёр оронтой тоо учраас алдаатай орох эсвэл бусад хариултын кодтой давхцах эрсдэл багатай.)

**“Хариулмааргүй байна” = 99**

(99 гэсэн тоог “хариулмааргүй байна” гэсэн хариултыг кодлоход түгээмэл ашигладаг. 99 нь өөр бусад хариултын кодтой огт давхцахгүй бөгөөд хариултгүй хувилбар гэдгийг шууд харах боломж өгдөг. Түүнээс гадна хариулаагүй асуулт болон анзаараагүйгээс хариулалгүй үлдээсэн асуулт хоорондын ялгааг гаргаж, дүн шинжилгээ хийхэд чухал.)

Алгасах, хариултын олон хувилбартай, нээлттэй зэрэг асуулт нь кодлолын нарийн төвөгтэй үйл ажиллагааг шаардана. **Мэдээллийн сан үүсгэх, түүний кодын систем бүрдүүлэх ажлыг статистикийн дүн шинжилгээг хариуцан хийх хүн удирдах нь зүйтэй.** Мэдээллийг программд оруулах ажилтныг асуултыг кодлох чиглэлээр бэлтгэхээс гадна мэдээллийг оруулах үед нь кодын бүртгэлийн дэвтрийн нэг хувийг өгнө (Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, 2008).

## Асуулга боловсруулах гол алхмуудын дүгнэлт

- Асуулгын судалгааны зорилго, тавих асуултууд, зөвшөөрөл авахын тулд өгөх ёстой мэдээллийг агуулсан удиртгал буюу танилцуулга мэдээллийг асуулгын хуудасны эхэнд оруулах (ингэснээр мэдээлэл цуглуулагч тэдгээрийг оролцогчдод уншиж өгөх боломжтой болно)
- Мэдээлэл цуглуулах явцын туршид дагаж мөрдөх удирдамжийг мэдээлэл цуглуулагчид гаргаж өгөх, ямар хариултуудыг чанга унших, ямрыг чанга уншихгүй байхыг анхааруулах
- Нарийн төвөгтэй алгасалтыг хэрэглэхээс зайлсхийх, нэг асуултад хоёроос дээш алгасалт байлгахгүйг хичээх
- Асуулгын хуудсыг бөглөхөд ойлгомжтой, тодорхой болгон бүтцэд оруулах, зарим хариултын хувилбарыг дүрсээр (сум гэх мэт) үзүүлэх
- Асуултын дэс дараалалд анхаарах, оролцогчийг гайхшруулах, шоконд оруулахгүй байхыг хичээх (эмзэг асуултуудыг асуулгын судалгааны мэдээлэл цуглуулах явцын төгсгөл хавьцаа буюу оролцогч ярилцлагад дассан үед асууна)
- Хариултын эерэг болон сөрөг хувилбаруудын дэс дарааллыг хангах
- Оролцогч тухайн асуултад хариулах хангалттай мэдээлэлтэй эсвэл туршлагатай эсэхийг тодорхойлох шүүлтүүр асуултыг хэрэглэх

Логик дэс дараалал тогтоох, дүн шинжилгээг хялбарчлах үүднээс асуултуудыг тодорхой сэдвүүд эсвэл хэсгээр бүлэглэх

Асуултын шинэ бүлэг эсвэл сэдэв эхэлж байгааг мэдэгдэх текстийг асуулгын хуудсанд оруулах

### ХЭСЭГ 7. ХҮҮХДИЙН АСРАМЖ, ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО

Хүүхдийг асран хамгаалах, аюулгүй байдлыг хангах тогтолцооны талаар Танаас одоо асууна.

55. Хүүхдийг асран хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн Либерийн хууль тогтоомжийн талаар мэдэх үү?

- |                                 |  |
|---------------------------------|--|
| 1. Тийм                         | >56-р асуултад хариулах                        |
| 2. Үгүй                         | >56-р асуултыг алгасаж, 57-р асуултад хариулах |
| 97. Мэдэхгүй/Итгэлтэй биш байна | >56-р асуултыг алгасаж, 57-р асуултад хариулах |

Сэдэв эсвэл хэсгийг танилцуулахаас өмнө оролцогчийн мэдлэгийг харах, шаардлагатай газар нь алгасах зааврыг оруулах

56. (Тийм бол) Ямар хууль байдаг вэ?

*Хариултын хувилбаруудыг чанга уншиж өгч болохгүй. Өгсөн хариултуудын өмнөх дугаарыг дугуйл.*

- a. Гэр бүлийн холбооны хууль
- b. Үрчлэлтийн хууль (хэлэлцэж байгаа)
- c. Хүүхдийн тухай хууль
- d. Хүн худалдаалахыг хориглох тухай хууль
- e. Бэлгийн хүчирхийллийн эсрэг хууль
- f. Хүний эрхийн хууль тогтоомжууд (Хүүхдийн Эрхийн тухай Конвенц гэх мэт)
- g. Тодорхой хууль нэрлэж чадахгүй байна
- h. Бусад (бичнэ үү)

Асуултыг хэрхэн асуух, тэмдэглэж авах талаар заавар өгөх

“мэдэхгүй” гэх хариултын хувилбар, түүний код оруулах



### 3.3. Асуулгыг орчуулах

Асуулга (буюу асуултууд)-ыг орчуулах нь зохион байгуулалттай холбоотой ажил мэт ч арга хэрэгслийн хүчин төгөлдөр байдлыг шалгах чухал алхам юм. Асуулгыг мэргэжлийн хүн орчуулах бөгөөд асуулгын судалгааны зорилтот хүн амын боловсролын ялгаатай түвшнийг харгалзан, орон нутгийн хүмүүст ойлгогдохуйцаар бичнэ. Ийнхүү асуулгыг бичгээр тэмдэглэх нь мэдээлэл цуглуулах явцад асуултыг мэдээлэл цуглуулагч өөрийн санаагаар тайлбарлах, асуух зэрэг алдаа гарахаас сэргийлдэг. Түүнчлэн энэ нь асуултыг тавих аргыг стандартчилах замаар үр дүнг хүчин төгөлдөр болгоход хувь нэмэр оруулдаг.

Асуулгыг давхар орчуулах (үндсэн хэл рүү нь буцаан орчуулах)-ыг зөвлөж байна. Давхар орчуулга гэдэг нь асуулгыг нэг хүн тухайн орон нутгийн эсвэл улсын хэлээр орчуулах бөгөөд өөр нэг хүн тэрхүү орчуулгыг буцаан үндсэн хэл рүү нь орчуулах үйл ажиллагаа юм. Хоёр дахь орчуулгыг асуулгын эхтэй харьцуулах замаар орчуулгатай холбоотой алдаа гарсан эсэхийг шалгана. Ингэснээр орчуулгын чанар болоод асуултуудын нийцэл баталгаажина.

### 3.4. Мэдээллийн менежмент, дүн шинжилгээ хийх төлөвлөгөө гаргах

Асуулгын судалгааны асуулт боловсруулах үе шатанд мэдээллийн менежмент, дүн шинжилгээний төлөвлөгөө гаргаснаар цуглуулах бүх мэдээлэл нь асуулгын судалгааны зорилготой нийцэж байгаа эсэх, ямар нэг чухал асуултыг асуулгад оруулалгүйгээр үлдээсэн эсэхийг хянахад тусалдаг. Мэдээллийг цуглуулсны дараа тэдгээрт дүн шинжилгээ хийх алхам, арга хэлбэрийг энэхүү төлөвлөгөөнд тусгах бөгөөд дараах асуудлуудыг багтаасан байх ёстой:

- ➔ **Мэдээллийг программд оруулах, цэвэрлэх:** Асуулгын судалгааны яг аль цаг үед нь мэдээллийг программд оруулах, ямар программ ашиглах, мэдээллийг уг программд хэн оруулахыг тодорхойлох; мэдээллийг цэвэрлэх зорилгоор шалгах эсвэл давхар оруулах (ижил мэдээллийг өөр системд өөр ажилтан оруулах замаар хүний хүчин зүйлээс үүдсэн алдааг шалгах) гэх мэт аргаар чанарын баталгаажуулалтыг хангах талаар тусгах
- ➔ **Мэдээллийн менежмент хийх:** Мэдээллийн баазыг хариуцах хүн, мэдээллийг хэрхэн хадгалах, хэн үзэж болохыг тодорхойлох
- ➔ **Мэдээлэлд дүн шинжилгээ хийх төлөвлөгөө гаргах:** Судалгааны асуултуудад хариулт өгөх тодорхой үр дүн, үзүүлэлтүүдийг хэрхэн шинжлэхийг харуулсан дүн шинжилгээний хүрээг гаргах. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх төлөвлөгөө нь дараах асуултуудад хариулсан байх ёстой:
  - o Ямар, ямар үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх вэ?
  - o Ямар мэдээлэлд ямар статистикийн ямар дүн шинжилгээг хийх вэ?
  - o Ямар хувьсагчийг дүрсэлсэн, ямар хувьсагчийг харьцуулалтаар шинжлэх вэ?
  - o Таамаглалыг хэрхэн шалгах вэ?
  - o Ямар, ямар түүврийн дэд бүлэгт дүн шинжилгээ хийх вэ?

Мэдээллийн дүн шинжилгээг эцсийн тайланд ямар байхыг харуулсан хоосон хүснэгтүүдийг гаргах нь хэрэгтэй байж магад. Тэдгээр хүснэгтээ асуулга болон асуулгын судалгааны зорилготой харьцуулан шалгаж, хоорондоо нийцсэн эсэхийг баталгаажуулна.

- ➔ **Мэдээллийг тайлбарлах:** Түншлэгчдийн уулзалт-хуралд хэрэглэх эсвэл бусад эх сурвалжийн мэдээлэлтэй харьцуулах зэргээр асуулгын судалгааны үр дүнг тайлбарлах алхмуудыг тодорхойлох
- ➔ **Мэдээллийг танилцуулах:** Мэдээллийг хэрхэн нэгтгэж, багц болгох, ялгаатай бүлгийн сонирхогчдод хэрхэн хүргэхийг тодорхойлох. Боломжтой бол мэдээлэл, харилцаанд зориулан гаргах ялгаатай материалуудын жагсаалтыг тодорхой болгох.

## 3.5. Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг турших, эцэслэх

Асуулгын судалгааны арга хэрэгсэл (асуулга)–ээ боловсруулж дууссаны дараа зорилтот хүн амын бүлгээс бага хэмжээний түүвэр сонгон, асуултууд хэрэг зэрэг ойлгомжтой байгаа эсэхийг мэдэх, мэдээлэл цуглуулах явцад тулгарч болох асуудлуудыг тодорхойлох зорилгоор туршилт хийх нь нэн чухал.

**Цуглуулах гэж буй мэдээлэл нь цуглуулахыг хүссэн мэдээлэл мөн эсэхийг тодорхойлох, асуулгын хуудсыг хэвлэж, мэдээлэл цуглуулах ажлыг эхлүүлэхээс өмнө асуулгын хугацаа нь тохиромжтой эсэх, алдаагүй эсэхийг баталгаажуулах боломж өгдөг учраас туршилт нь тун чухал юм.** Туршилтыг дараах зорилгоор хийнэ:

- ✓ Асуултуудын тодорхой, нийцтэй байдлыг баталгаажуулах
- ✓ Мэдээлэл цуглуулагч эсвэл хариулагчийн ойлгохгүй байгаа асуултуудыг тогтоох
- ✓ Шаардлагагүй буюу илүүдсэн асуултуудыг олох
- ✓ Асуултыг оновчтой үг хэллэгээр илэрхийлэх, орчуулгыг сайжруулах
- ✓ Асуултуудын дэс дараалал алдагдсан болон хариулагчдад эмзэг тусаж буй асуултуудыг олох
- ✓ Асуултуудаас гарч болох алдааг тодорхойлох
- ✓ Асуулгын хуудсыг бөглөхөд шаардагдах хугацааг шалгах
- ✓ Мэдээлэл цуглуулах зохион байгуулалтыг турших, мэдээлэл цуглуулагчдад өгөх зааврыг сайжруулах хэрэгцээ байгаа эсэх, тэдэнд нэмэлт сургалт, зааварчилгаа хэрэгтэй эсэх, асуулгын формат (бүтэц)–ыг сайжруулах эсэхийг тус тус турших

Асуултууд нь логик дэс дараалалтай эсэх, заавар тодорхой эсэх, хүссэн мэдээллүүдийг цуглуулахуйц хэмжээнд асуултуудыг энгийн томъёолсон эсэхийг шалгахын тулд асуулгын судалгааны зорилтот хүн амын бүлгээс бага хэмжээний түүвэр сонгон туршилт хийхээс өмнө асуулгын судалгааны багийн гишүүд болон ажилтнуудын дунд туршилт хийж болно.

### Хүүхдийн оролцоо

Асуулгын судалгааны арга хэрэгслийн туршилтыг хүүхдүүд үеийнхэн дундаа явуулж, тусалж чадна.

- ➔ Туршилт судалгааны зорилго, туршилтаар тодорхойлох ёстой асуудлууд, тэдгээрийг тэмдэглэн баримтжуулах, нууцыг хадгалах талаар туршилт судалгааг хийх хүүхдүүдэд танилцуулах сургалт зохион байгуулах
- ➔ Туршилт хийсэн туршлага, санал зөвлөмжийг сонсох уулзалтыг туршилт хийсэн хүүхдүүдийг оролцуулан хийх

**Асуулгын судалгааны арга хэрэгслээ ийнхүү туршин сайжруулсны дараа судалгааны зорилтот бүлгийн хүн амаас бага хэмжээний түүвэр (10–30 хүн)-ийг сонгон авч, дахин туршилт хийнэ. Энэхүү бага хэмжээний түүвэрт багтсан хүмүүсийг асуулгын судалгааны үндсэн түүвэрт оруулж болохгүй.** Асуулгын судалгааны мэдээллийг цуглуулж буй мэтээр хандаж, яг ижил нөхцөл байдал, заавар удирдамжийн дагуу туршилтыг хийнэ. Энэхүү туршилтын үйл явц нь нэг талаас асуулгын судалгааны арга хэрэгслийг туршилтаар сайжруулан засварлах зорилготой ч нөгөө талаас мэдээлэл цуглуулагчдыг сургаж, ажилдаа дадахад нь тусалж байгаа хэрэг юм. Хэрэв нэгээс олон гишүүн асуулгын судалгааны арга хэрэгслийг туршиж байгаа бол гишүүн бүр хамгийн багадаа 2–3 удаагийн туршилт ярилцлага хийж, дараа нь арга хэрэгсэлтэй холбоотой ямар нэг асуудал гарч байгаа эсэх болон бусад зүйлийг хэлэлцэнэ.

**Асуулгын судалгааны асуултуудыг бүрэн сайжирлаа гэх хүртэл туршилт хийж, засварлана.** Асуулгын судалгаанд хэрэглэж буй арга хэрэгсэл нэг бүрийг туршиж, ойлгомжтой хэлээр томъёологдсон эсэхийг нэгбүрчлэн нягтална. Ийнхүү засан сайжруулахад асуултуудын агуулгаас гадна бүтцэд ч өөрчлөлт орж болзошгүй тул бэлтгэлтэй байх хэрэгтэй.

Туршилтын судалгааны явцад цугларсан мэдээллийг жинхэнэ судалгааны дүн шинжилгээнд хэрэглэж болохгүй. Туршилт судалгаанд хамрагдаж буй хүүхэд, насанд хүрэгчдэд, тэдний өгсөн хариултууд нь жинхэнэ судалгааны мэдээлэлд орохгүй, харин тэрхүү судалгаанд хэрэглэх арга хэрэгслийг шалгаж баталгаажуулахад ашиглагдана гэдгийг хэлж ойлгуулах ёстой.





## Асуулгын судалгааны арга хэрэгслийг туршихад зориулсан зөвлөгөө

- Асуултуудад буй мэдэгдэхүйц алдаануудыг олж, засахын тулд түүнийг асуулгын судалгааны зорилтот хүн амын бүлгээс бага хэмжээний түүвэрт туршихаас өмнө судалгааны багийн гишүүдийн дунд турших
- Туршилт судалгаанд хамрагдаж байгааг оролцогчдод мэдээлэх, асуулгад буй тодорхойгүй, ойлгомжгүй, таагүй эсвэл асуулгыг бөглөхөд хэт их хугацаа шаардагдаж байгаа эсэх талаар санал бодлоо хэлэхийг оролцогчдоос хүсэх
- “Мэдэхгүй” гэсэн хариулт олноор өгсөн байвал тухайн асуулт эсвэл хариултын хувилбарууд нь ойлгомжгүй, эргэлзээтэй эсвэл тохиромжгүй үг хэллэг ашигласан байж болзошгүйг илтгэх тул түүнд анхаарах
- Хариултын олон хувилбартай асуултад хэт олон “бусад” гэсэн хариулт ирсэн бол бусад гэдэг хувилбарт бичсэн нийтлэг хариултыг асуултын хувилбарт оруулах, гэхдээ хэт олон хариултын хувилбараас аль болох татгалзах
- Асуулгыг бүрэн бөглөхөд шаардагдах хугацааг тогтоох. Ерөнхийдөө 35 минутаас дээш хугацаа шаарддаг асуулга нь мэдээлэл цуглуулагчийг ч тэр, оролцогчийг тэр аль алиныг ядрааж залхаадаг, улмаар энэ нь мэдээллийн чанарт сөргөөр нөлөөлнө. Ялангуяа хүүхдүүд хамрагдаж байгаа тохиолдолд ийм байдал үүснэ. Тиймээс асуулга хэт урт бол асуултын тоог багасгах хэрэгтэй.
- Алгасах асуултууд болон нарийн зааварчилгаатай холбоотой зүйлийг ойлгосон эсэхийг мэдээлэл цуглуулагчдаас лавлах

(Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, 2008)





# АЛХАМ 4: МХД-ын асуулгын судалгааны мэдээлэл цуглуулах нь

## Үйл ажиллагаа

- 4.1. Мэдээлэл цуглуулах хугацаа, өдрийг сонгох
- 4.2. Асуулгын судалгааны баг бүрдүүлэх
- 4.3. Асуулгын судалгааны багийн гишүүдийг сургах
- 4.4. Мэдээлэл цуглуулах
- 4.5. Мэдээллийн чанарыг баталгаажуулах

## Үр дүн

- ✓ Асуулгын судалгааны багийн гишүүдийн ажлын даалгавар
- ✓ Мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах, системтэй байлгахад туслах хэрэгсэл (хэрэглэгдэх зүйлийн жагсаалт, түүвэрлэлтийн явц, өдрийн ажлын дүгнэлт бичих загвар, мэдээллийн чанарын хяналт гэх мэт)
- ✓ Мэдээллийг оруулах хэлбэр (электрон), мэдээллийг цэвэрлэх протокол
- ✓ Мэдээлэл цуглуулах явцад учирч буй асуудлыг бүртгэх, шийдвэрлэх зорилготой өдөр тутмын болон долоо хоногийн ажлын дүгнэлт уулзалт





# АЛХАМ 4: МХД-ын асуулгын судалгааны мэдээлэл цуглуулах нь

## 4.1. Мэдээлэл цуглуулах хугацаа, өдрийг СОНГОХ

**Заавал хийх зүйл:** Мэдээлэл цуглуулах хугацаа, өдрүүдийг төлөвлөж, зураглал гаргаарай.

Төлөвлөгөөнд дараах зүйлийг багтаана:

- ➔ Мэдээлэл цуглуулахад шаардлагатай нийт өдөр (үүнийг тооцоход дараах зүйлийг анхаарна)
  - o Ярилцлага хөтлөгч буюу мэдээлэл цуглуулагчийн тоо
  - o Өөр өөр орон нутагт нэгэн зэрэг мэдээлэл цуглуулах багийн тоо
  - o Орон нутаг тус бүрээс цуглуулах мэдээллийн (ярилцлагын) тоо (түүврийн төлөвлөгөөг харах)
  - o Мэдээлэл цуглуулахад шаардлагатай унаа тээвэр
  - o Асуулгын судалгаанд оролцогчийн цаг зав, ажил, хичээлийн боломжоос гадна мэдээлэл цуглуулагчийн эрүүл мэнд, аюулгүй, сайн сайхан байдлыг тооцсоны үндсэн дээр нэг мэдээлэл цуглуулагч нэг өдөрт дунджаар хэдэн хүнтэй ярилцах ёстойг тогтоосон тоо (Өдрийн туршид хүнтэй ярилцах нь хэцүү ажил бөгөөд нэг өдөрт 4-5 хүнтэй ярилцахад хангалттай.)
- ➔ Мэдээлэл цуглуулах өдрүүдтэй давхцаж буй амралтын өдрүүд
- ➔ Ложистикийн хувьд бэрхшээл үүсгэж болзошгүй цаг агаарын болон замын нөхцөл байдал
- ➔ Улирлын болон өдрийн аль цагт оролцогчид судалгаанд хамрагдах боломжтой эсэх
- ➔ Мэдээлэл цуглуулах ажилтай давхцаж, хүндрэл эсвэл боломж авчирч магадгүй бусад үйл ажиллагаа
- ➔ Мэдээлэл цуглуулах багийн бүх гишүүдийн сургалт
- ➔ Мэдээллийг программд оруулах, дүн шинжилгээ хийхэд зарцуулах хугацаа



## 4.2. Асуулгын судалгааны баг бүрдүүлэх

МХД-ын асуулгын судалгааг амжилттай явуулахад судалгааны баг тун чухал үүрэгтэй. **Судалгааны багийнхан хангалттай хэмжээнд сэдэлжиж, асуулгын судалгааны зорилгыг сайтар ойлгосон, мэдээлэл цуглуулах ажлын туршлагатай бол мэдээллийн чанарыг хангахад анхаарах, мэдээлэл цуглуулах явцад гарах асуудлыг тогтоох, түүнийг шийдвэрлэх чадвартай байна гэсэн үг.** Асуулгын судалгааны удирдагч эсвэл мэдээлэл цуглуулагчдын чадамжийг сайтар нягтлалгүйгээр судалгаанд ажиллуулбал мэдээллийг нэгэнт цуглуулж дууссаны дараа ямар нэг эрсдэл эсвэл асуудал гарч магадгүй бөгөөд тэр үед цуглуулсан мэдээллийн чанарыг сайжруулах талаар ямар нэг арга хэмжээ авахад хэтэрхий оройтсон байх болно.

Мэдээлэл цуглуулахаар төлөвлөсөн хугацаанд өөрийн тань байгууллагын ажилтнууд боломжтой байвал, мөн тэдний ур чадвар хангалттай хүрэлцэнэ гэж бодож байвал асуулгын судалгааны багийн ихэнх гишүүнийг байгууллага дотроосоо бүрдүүлж болно. Гэвч зорилтот хүн амын бүлэгтэй одоо хийгээд ирээдүйд тогтоох харилцаа холбоо, мөн ашиг сонирхлын зөрчил үүсэж магадгүй байдлыг сайтар бодолцох хэрэгтэй. Асуулгын судалгааны багийн гишүүдийг байгууллага дотроосоо эсвэл гаднаас бүрдүүлсэн эсэхээс үл хамааран ижил шалгуур, шаардлага тавих ёстой. Асуулгын судалгааг удирдуулахаар гаднын зөвлөх урьсан бол тэр хүн багийн гишүүдийг сонгох ажлыг хариуцах боловч багийн гишүүдийг сонгох шалгуур, үйл явцыг зөвлөхтэй өмнө нь ярьж тохирсон байх нь зүйн хэрэг.

Асуулгын судалгааны баг дараах үүрэг бүхий хүмүүсээс бүрдэнэ:

**Судалгааны менежерийг** тухайн хөтөлбөрийн ажилтнууд дундаас томилох хэрэгтэй бөгөөд Хүүхдийг Ивээх Сангийн хувьд тэр хүн нь судалгааг хариуцах үүрэгтэй хүн юм. Энэхүү менежер нь судалгаатай холбоотой бүхий л ажлыг удирдан зохицуулах үүрэг хүлээнэ. Судалгаанд гаднын зөвлөх ажиллуулж байгаа бол судалгааны менежер нь уг зөвлөхтэй шууд харилцаж, түүнийг бусад ажилтан (менежмент, хөтөлбөр, хүний нөөц, санхүү, ложистик гэх мэт)-тай холбох үүрэг гүйцэтгэнэ.

**Мэдээлэл цуглуулах багийн ахлагч** нь асуулгын судалгааны протоколын дагуу сонгогдсон газраас судалгааны мэдээллийг цуглуулах үүрэгтэй багийг удирдана. Орон нутгийн удирдлагуудтай уулзах, асуулгын судалгаа хийх зөвшөөрөл авах, түүврийн төлөвлөгөөний дагуу мэдээлэл цуглуулах, мэдээлэл цуглуулагчдад шаардлагатай мэргэжлийн тусламж дэмжлэг үзүүлэх үүргийг багийн ахлагч хүлээхээс гадна мэдээлэл цуглуулах, өдрийн ажлын явцыг дүгнэсэн тайлан бэлтгэх, цуглуулсан мэдээллийн бүрэн байдал, чанарыг хянах ажлыг гүйцэтгэнэ. Мэдээлэл цуглуулах багийн ахлагчийн ажлын даалгаврыг **Хавсралт Ё**-д оруулсныг үзээрэй.

**Мэдээлэл цуглуулагч (Ярилцлагыг хөтлөгч)** нь ярилцлага хийх замаар хувь хүнээс мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэнэ. Асуулгын судалгааны ярилцлагын явцыг оролцогчдод амар хялбар байлгах, асуулгын судалгааны нарийн зааврыг чанд мөрдөх, хариулт зайлшгүй авах ёстой сэдвүүдээр ярилцлага өрнүүлэхийн тулд мэдээлэл цуглуулагч нь харилцааны өндөр чадамжтай байх ёстой. Хэрэв асуулгын судалгаанд хүүхэд оролцуулахаар шийдвэрлэсэн бол хүүхэдтэй, нэн ялангуяа хүүхэд хамгаалал болон хүүхэдтэй холбоотой бусад асуудлаар хүүхэдтэй ярилцаж байсан туршлагатай эсэхийг харгалзан мэдээлэл цуглуулагчдыг сонгох нь нэн чухал. Олон мэдээлэл цуглуулагчийн хувьд эрүүл мэнд, хоол тэжээлийн талаарх өрхийн стандарт асуулгын судалгааны мэдээлэл цуглуулахад оролцсон байж болох ч хүүхэд хамгаалалтай холбоотой эмзэг, нарийн асуудлаар ярилцсан туршлагатай мэдээлэл цуглуулагч цөөн байж болзошгүй. Хүүхэдтэй ярилцах нь мэргэшил шаардахаас гадна ярилцлагын явцыг хүүхэд хялбар байлгах, харилцан итгэлцэл, ойлголцол төрүүлэх чадвар туршлагатай мэдээлэл цуглуулагчдад ч дутагдаж болох юм. Мэдээлэл цуглуулагчдыг сонгох явцад хүүхэдтэй хэр зэрэг сайн ярилцаж чадах эсвэл эсрэгээр нь хүүхдийг сандрааж, айлгаж магадгүй мэдээлэл цуглуулагч аль нь вэ гэдгийг ялгаж



салгах бөгөөд хүүхэдтэй ярилцаж байсан туршлагагүй хүнээр мэдээлэл цуглуулагч хийлгэж болохгүйг анхаараарай. Мэдээлэл цуглуулагчдын ажлын даалгаврыг **Хавсралт Ж**-д үзүүлснийг харна уу.

**Мэдээллийг программд оруулах ажилтан** нь мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа эхэлмэгц мэдээллийг сонгосон программын мэдээллийн системд бүртгэн оруулах ажил гүйцэтгэнэ.

Асуулгын судалгааны багийн гишүүдийг шалгаруулах стандарт үйл ажиллагаанаас гадна танай байгууллагын хийх гэж буй судалгаатай төстэй судалгааг өмнө нь хийсэн түнш байгууллагатай холбогдвол тухайн үүрэгт ажилд хамгийн сайн тохирох хүмүүсийг танай холбож өгч магадгүй. Зарим тохиолдолд эрүүл мэнд, социологи, боловсрол судлал, хэлний чиглэлээр магистр, докторын шатны сургалтад хамрагдаж буй оюутнуудаас мэдээлэл цуглуулагч эсвэл мэдээллийг программд оруулах ажилтныг сонгох нь оновчтой байж магад. Гэвч туршлагатай ажилтны хэрэгцээ байгаа эсэх, сургалтад зарцуулах цаг хангалттай бий эсэхийг тус тус тооцсоны үндсэн дээр оюутнуудыг ажиллуулах эсэхийг шийднэ.

**Мэдээлэл цуглуулагчдыг сонгоход тэдний хүйс нь анхаарах ёстой нэг зүйл юм.** Асуулгын судалгааны асуултуудын агуулгыг эргэн харж, эрэгтэй мэдээлэл цуглуулагч охид, эмэгтэйчүүдээс мэдээлэл авах (үүнтэй адилаар эмэгтэй мэдээлэл цуглуулагч эрэгтэйчүүдээс мэдээлэл цуглуулах) нь соёлын хувьд зохимжтой эсэхийг бодолцоно. Асуулгын судалгааны оролцогчдод таатай байх эсэх, тэдний хариултад мэдээлэл цуглуулагчийн хүйс нөлөөлж болох эсэхийг тооцсоны үндсэн дээр мэдээлэл цуглуулагчдыг сонгоно.

**Урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдлыг нөхөх гэхээс илүүтэйгээр аль болох олон мэдээлэл цуглуулагчийг сонгож, сургах хэрэгтэй** гэж зөвлөө. Либерид, мэдээлэл цуглуулагчдад зориулан хийсэн сургалт нь тэднийг сонгон шалгаруулах үйл явцын нэг хэсэг болсон. Энэ тактик нь үр дүнгээ өгсөн бөгөөд үүний дүнд мэдээлэл цуглуулах ажлын шаардлага хангахгүй хоёр ч хүнийг олж, багаас гаргажээ. Энэ нь сургалтын зардлыг үргүй ашигласан мэт боловч мэдээлэл цуглуулах чанартай багийг бүрдүүлэхэд чухал хөрөнгө оруулалт болсон гэдгийг санах хэрэгтэй.

### 4.3. Асуулгын судалгааны багийн гишүүдийг сургах

Асуулгын судалгааны багийн гишүүд нь ярилцлага хийх үр чадвартай байхаас гадна асуулгыг хэрхэн хэрэглэх талаар мэддэг, судалгааны зорилго, зорилтууд болон судалгаа явагдаж буй хам орчны нөхцөл байдлыг ойлгодог байх ёстой. **Асуулгын судалгааны багийн гишүүд хүүхэд хамгааллын чиглэлээр туршлага багатай бол тэдэнд зориулан хамгийн багадаа 3-5 өдрийн сургалт төлөвлөх хэрэгтэй.** Сургалтыг сайн төлөвлөж чадвал энэ нь эргээд асуулгын судалгааны арга хэрэгслийг турших, сайжруулах, мэдээлэл цуглуулагчдыг турших, багийг бэхжүүлэх, мэдээлэл цуглуулах төлөвлөгөө, хуваарийг эцэслэх гэх мэтэд чухал нөлөө үзүүлнэ.

Мэдээлэл цуглуулах багийн ахлагчид болон бусад удирдлагын түвшний ажилтнууд мэдээлэл цуглуулагчидтай хамт сургалтад хамрагдах, ингэснээр мэдээлэл цуглуулах явцад тэдэнд шаардлагатай туслалцаа дэмжлэг үзүүлэх, удирдлагаар хангах боломжтой болно. **Хөтөлбөр, захиргаа, ложистикийн албаны ажилтнуудыг асуулгын судалгааны зорилго, аргуудыг танилцуулах сургалтын хэсгүүдэд хамруулахыг зөвлөж байна.** Үүний учир нь асуулгын судалгаанд тэдний дэмжлэг нэн чухал бөгөөд тэдний хувьд асуулгын судалгаанд туслахын тулд уг судалгааны зорилгыг ойлгосон



**байх ёстой.** Либерид, сургалтын тодорхой хэсгүүдэд жолооч нарыг хамруулсан бөгөөд үүний дүнд тэд судалгааны ажлын үр дүнг гаргахад хувь нэмэр оруулах ёстой хүмүүс гэдгээ илүү сайн ойлгосон. Түүгээр үл барам дараа нь мэдээлэл цуглуулах явцад унаа тээвэртэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцож байжээ.

Асуулгын судалгааны багийн гишүүдэд зориулсан сургалтад дараах сэдвүүдийг оруулах хэрэгтэй:

- ➔ Асуулгын судалгааны мэдээлэл цуглуулах газруудтай холбоотой аюулгүй байдал, хамгааллын асуудал
- ➔ Хүүхдийг Ивээх Сангийн хүүхэд хамгааллын бодлого, түүнийг даган мөрдөх үйл явц
- ➔ Асуулгын судалгааны зорилго, зорилтууд, мэдээлэлд хийх дүн шинжилгээ, судалгааны үр дүнгийн хэрэглээ
- ➔ Асуулгын судалгааны багийн гишүүн тус бүрийн үүрэг хариуцлага
- ➔ Асуулгын судалгааны протокол, арга, түүврийн хүрээ (түүвэр сонгосон шалтгаан, үндэслэл, үүнийг мэдээлэл цуглуулахад хэрхэн ашиглах талаарх мэдээллийг багтаана)
- ➔ Асуулга, маягт, бусад материалын агуулга, хэрэглээ
- ➔ Асуулгад буй асуулт тус бүрийн заавар, алгасалт, тэдгээрийн тайлбар
- ➔ Хариулагчийг сонгох явц
- ➔ Мэдээлэл өгсний үндсэн дээр зөвшөөрөл авах, нууц хадгалах асуудлыг багтаасан судалгааны ёс зүйн асуудал
- ➔ Ярилцах үр чадвар, үүнээс гадна сонсох ба лавлах үр чадвар, хүүхэдтэй ярилцахтай холбоотой бусад тусгай арга техникүүд
- ➔ Мэдээлэл цуглуулах явцын удирдлага, чанарын хяналтын явц
- ➔ Алгасалт хийх, ярилцлага хөтлөх үр өгөөжтэй техникүүд
- ➔ Дүрийн тоглолт, ярилцлага хийх дадлага
- ➔ Ложистикийн асуудлууд

### **Асуулгын судалгааны багийн гишүүдийн сургалтад зориулсан зөвлөгөө: Хариултыг кодлох дүрийн тоглолт**

Мэдээлэл цуглуулагчид асуултын кодыг мэдэх, түүнийг давтах нь нэн чухал. Мэдээлэл цуглуулагчдаас хоёр хүн бүлгийн өмнө гарч, нэг нь асуулгын судалгааны асуултуудыг асуух бөгөөд нөгөө нь хариулна. Бүлгийн бусад гишүүд тэрхүү хоёрыг анхааралтай сонсож, өөрсдөө мэдээлэл цуглуулж буй мэтээр маягтад хариултуудын кодыг бичнэ. Ярилцлага дууссаны дараа мэдээлэл цуглуулагч бүрийн хариултын кодыг харьцуулна. Хариулагчийн хэлсэн зүйлийг өөрийнхөөрөө ойлгосноос ижил мэдээллийг ялгаатайгаар кодолсон байх тохиолдол түгээмэл гардаг. Асуулт тус бүрийг хэлэлцэн, зөв кодыг мэдэж авна. Мэдээлэл цуглуулагчдын дунд энэхүү дасгалыг 2–3 удаа хийснээр хариултыг ялгаатай кодлох асуудал багасаж, улмаар энэ нь мэдээлэл цуглуулах явцад мэдээллийн найдвартай байдлыг хангахад чухал нөлөө үзүүлдэг.

Асуулгын судалгааны багийн гишүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрийн загварыг **Хавсралт 3**-д үзүүлснийг харна уу.

**Асуулгын судалгааны багийн гишүүдэд дүрд тоглох, ярилцлагыг давтах, ярилцлага хийх техникээ сайжруулан давтахад нь зориулан хангалттай хэмжээний цаг гаргаж өгөх нь зөв.** Асуулгын судалгаанд хүүхэд эсвэл хүн амын эмзэг бүлгийн төлөөлөл хамрагдаж байгаа бол тэдэнтэй ярилцахад хэрэглэх нарийн арга техникүүд, хувь хүний төөрөгдөл, эмзэг байдлыг хэлэлцэх тодорхой хэсгийг сургалтын агуулгад багтаах хэрэгтэй.

Сургалтын төгсгөл хэсэгт судалгааны менежер, мэдээлэл цуглуулах багийн ахлагч нар асуулгын судалгааны багийн гишүүдийг эцэслэн сонгож, мэдээлэл цуглуулагчийн үр чадвар, хүйс, ярианы чадварыг харгалзан супервайзоруудыг мөн томилно.

## 4.4. Мэдээлэл цуглуулах

Мэдээлэл цуглуулах ажлыг ложистик болон захиргааны багтай хамтран төлөвлөх хэрэгтэй бөгөөд ингэснээр төлөвлөгөө амжилттай хэрэгжинэ. Хангалттай мэдээлэл бүхий зураглалыг хийсэн бол түүнийг ашиглан мэдээлэл цуглуулах орон нутгийн зураглал гаргах, багийн ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулахад хэрэглэхийг зөвлөө.

Мэдээлэл цуглуулахаас өмнө дараах асуултуудыг асууж, бэлэн байгаа эсэхээ шалгаарай:

### Шалгах асуултууд: Мэдээлэл цуглуулахад бэлэн үү?

- Бодит нөхцөл байдалд асуулгыг туршиж шалгасан үү?
- Чадвар, хүйсийг харгалзсаны үндсэн дээр мэдээлэл цуглуулах багуудын бүтэц, бүрэлдэхүүнийг сонгосон үү?
- Мэдээлэл цуглуулахад хуваарилсан цаг, өдөр хангалттай эсэхийг тооцсон үү?
- Мэдээлэл цуглуулах багийн ахлагч болон мэдээлэл цуглуулагчдад хангалттай тооны асуулга, бусад хэрэгслээр хангасан үү?
- Асуулгын судалгааны протокол, мэдээлэл цуглуулах ажлын удирдамжийг багуудад өгсөн үү?
- Мэдээлэл цуглуулах баг тус бүрийн хонох газруудыг төлөвлөсөн үү?
- Цуглуулсан мэдээллийг программд оруулж байгаа газарт асуулгын судалгааны баг буцаж ирэхгүй бол цуглуулсан мэдээллийг хүргүүлэхээр төлөвлөсөн үү?
- Мэдээлэл цуглуулах баг тус бүр өдрийн ажлаа дүгнэн ярилцах цаг бий юу?

Багийн гишүүдийг мэдээлэл цуглуулах газарт ирэхээс өмнө багийн ахлагч орон нутгийн удирдлагуудтай уулзан, асуулгын судалгааны зорилго, мөн чанарыг тайлбарлах, мэдээлэл цуглуулах явцад тэдний дэмжлэг туслалцаа авах чиглэлээр ярилцвал зохино. Либерийн Хүүхдийг Ивээх Сангийн ажилтнууд орон нутгийн иргэдтэй тогтоосон харилцаа холбоондоо үндэслэн энэхүү ажлыг хийсэн бөгөөд тэдгээр ажилтнууд судалгааны багийнхан ирэхээс өмнө орон нутгийн удирдлагууд, түншлэгчидтэй ярилцаж, холбогдох бэлтгэлийг хангажээ.







## 4.5. Мэдээллийн чанарыг баталгаажуулах

Асуулгын судалгааны явцад, нэн ялангуяа мэдээлэл цуглуулах явцад мэдээллийн чанарт хяналт тавих арга хэмжээ авах нь нэн чухал. Мэдээллийг цуглуулж дууссаны дараа гарсан асуудлуудыг арилгахын тулд дахин мэдээлэл цуглуулах боломжгүй тул мэдээлэл цуглуулах явцад хийх чанарын хяналт нь нэн чухалд тооцогдоно. Баг дотроо мэдээлэл цуглуулагч тус бүрийн цуглуулсан мэдээллийн чанарыг хянах, хангах үүргийг мэдээлэл цуглуулах багийн ахлагч нар хариуцана. Мэдээлэл цуглуулах явцад мэдээллийн чанарт тавих хяналтыг хэд хэдэн аргаар хийж болдог. Үүнтэй холбоотой зарим зөвлөгөөг дор үзүүлсэн схемээс харна уу.

**Мэдээлэл цуглуулах ажлыг эхлүүлэхээс өмнө багийн ахлагч нар мэдээлэл цуглуулагчдыг дэмжих, мэдээлэл цуглуулах явцад гарч болох асуудлуудыг илрүүлэх, цугларсан мэдээлэлд чанарын хяналт хийх удирдамжийг боловсруулсан байна.** Багийн ахлагчдад, тэдний ажлын менежментэд зориулсан тодорхой арга хэрэгслүүдийг гаргаж өгвөл тун зохистой бөгөөд үүнд тээвэр (машин, жолооч, түлш), хангамж (ус, анхны тусламжийн хэрэгсэл, газрын зураг), асуулгын судалгааны материалууд (асуулга, хавчаар, үзэг, харандаа)-тай холбоотой шалгах хуудсууд багтана.



### Мэдээлэл цуглуулах явцад

- Мэдээлэл цуглуулах багийн ахлагч нь гишүүн тус бүрийн ярилцлагыг ажиглаж, ярилцах арга техниктэй холбоотой зөвлөгөө өгнө. Ажиглалт хийхийн өмнө оролцогчоос зөвшөөрөл авах бөгөөд ярилцлагыг ажиглах нь оролцогчид таагүй байдал үүсгэхгүй, түүний хариултад нөлөөлөхгүй байх ёстой.

### Өдрийн төгсгөл буюу мэдээлэл цуглуулж дуусаад тухайн газраас явахын өмнө

- Мэдээлэл цуглуулах багууд өөр хоорондоо туршлагаа хуваалцах, цуглуулсан мэдээллээ ахлагчдаа өгөх зорилгоор бие биетэйгээ уулзах нь зохистой. Ийнхүү уулзахдаа өдрийн ажлаа дүгнэх, түүнийг баримтжуулах тайлангийн загвар гэх мэт хэрэгслийг бэлтгэсэн байвал зохино. Сьерра-Леоне дахь төлөөлөгчийн газрын боловсруулсан загварыг жишээ болгон Хавсралт И-д үзүүлэв.
- Асуулгын судалгааны протоколд тусгасан түүврийн төлөвлөгөөний дагуу мэдээлэл цуглуулж байгаа эсэхийг ахлагч нар баталгаажуулна.
- Асуулга тус бүрийг нэгбүрчлэн шалгаж, дутуу байгаа эсэхийг ахлагч нар хянана.
- Ярилцлагад ямар нэг асуудал гарсан бол тухайн оролцогчтой дахин холбогдож, ярилцлага авах ажлыг хийнэ.

### Мэдээллийг программд оруулах явцад

- Үндсэн цэвэрлэгээ (асуулга тус бүр гүйцэд байгаа эсэх) хийх, асуудал гарвал мэдээлэл цуглуулах багтай дор нь холбогдож, мэдээллийг засварлах ажлыг хийнэ.



# АЛХАМ 5: Мэдээллийн менежмент, дүн шинжилгээ хийх нь

## Үйл ажиллагаа

- 5.1. Мэдээллийг программд оруулах, цэвэрлэх
- 5.2. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- 5.3. Үр дүнг тайлбарлах, танилцуулах
- 5.4. Мэдээллийн чанарыг баталгаажуулах

## Үр дүн

- ✓ Мэдээлэлд дүн шинжилгээ хийх уулзалтаар дамжуулан статистикийн үндсэн дүн шинжилгээнүүдийг хийх чадвартай болсон хөтөлбөрийн ажилтнууд болон түншлэгчид
- ✓ Урьдчилсан үр дүнгийн тайлан, нарийн дүн шинжилгээ хийх санал зөвлөмж
- ✓ Хүүхэд, хөтөлбөрийн үр шим хүртэгчид, асуулгын судалгааны оролцогчид зэрэг бүх түвшний түншлэгчдийг хамруулсан уулзалтаар танилцуулж, баталгаажуулсан судалгааны үр дүн, тайлбар, санал зөвлөмж
- ✓ Асуулгын судалгааны эцсийн тайлан
- ✓ Асуулгын судалгааны протоколд дурдсан бусад материал





# АЛХАМ 5: Мэдээллийн менежмент, дүн шинжилгээ хийх нь



МХД-ын асуулгын судалгааны протокол боловсруулах явцад мэдээллийн менежмент, дүн шинжилгээний төлөвлөгөөг гаргадаг. Мэдээллийг программд оруулах, цэвэрлэх үйл ажиллагаа нь мэдээлэл цуглуулах явцад эсвэл мэдээлэл цуглуулж дуусангуут эхлэх бөгөөд энэ нь цаг хугацаа хэмнэх талтайгаас гадна мэдээллийн чанартай холбоотой асуудал гарвал эргэн тодруулж, засах боломжтой байдгаараа ач холбогдолтой.

## 5.1. Мэдээллийг программд оруулах, цэвэрлэх

Мэдээлэлд дүн шинжилгээ хийх статистикийн программд эсвэл эксел гэх мэт программын хуудас болон мэдээллийг оруулж буй ажилтны хэрэглэж болох бусад программд мэдээллийг шууд оруулдаг.

Экселийг мэдээллийн дүн шинжилгээнд өргөн хэрэглэдэг боловч их хэмжээний мэдээллийг уг программаар боловсруулахад тун төвөгтэй. МХД-ын асуулгын судалгааны 30 минутын асуулга дунджаар 40–50 асуултаас бүрдэх бөгөөд оролцогч нэг бүрийн хариулт нь мэдээллийн баазад ойролцоогоор 50 баганыг үүсгэнэ гэсэн үг. Экселийн хуудсанд оролцогч тус бүрийн 50 баганыг оруулах нь бэрхшээлтэйгээс гадна оруулж буй мэдээлэлд ажилтнаас шалтгаалсан алдаа гарах магадлал ихтэй. Мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ эксел ашиглахаар болсон бол хэрэглэхэд хялбар болгох, хүний хүчин зүйлээс үүдсэн алдааг багасгахын тулд экселийн мэдээлэл оруулах нүүр хуудсыг сайтар боловсруулж, бэлтгэсэн байх ёстой.

Компьютерийн зарим программ нь мэдээллийг оруулах нүүр хуудсыг байгуулах, ингэснээр асуултуудыг дарааллын дагуу зөөх (хөдөлгөх), хариултуудыг автоматаар кодлох, алгасалт, бүрэн дүүрэн байдал, үл нийцлийг шалгах зэргээр асуулгатай яг адил ажиллах боломж өгдөг. Либерид явуулсан судалгаанд “SurveyGizmo” хэмээх интернэттэй тохиолдолд хаанаас ч мэдээллийг оруулах, шалгах боломжтой онлайн программыг ашигласан. Гэхдээ нарийн программ байхын хэрээр мэдээлэл оруулах ажилтнуудыг түүнд сургах, алдааг хэрхэн олох талаар мэдээлэх шаардлагатай болдог.

**Мэдээллийг программд оруулах явцад хүнээс үүдсэн алдааг багасгахын тулд давхар оруулах арга нь хамгийн сайн техник юм.** Давхар оруулна гэдэг нь ижил мэдээллийг хоёр хүн хоёр өөр мэдээллийн баазад оруулах ба дараа нь тэднийг

харьцуулан шалгахыг хэлж байгаа юм. Давхар оруулах арга нь хоёр мэдээллийн баазыг харьцуулах замаар шивэлтийн алдаа, мэдээлэл оруулагч тус бүрийн гаргаж болох алдааны хэмжээ, зөрчилтэй мэдээллийг засах боломж зэргийг тодруулна. Цаг хугацаа хийгээд бусад нөөц хангалттай байгаа бол бүх мэдээллийг давхар оруулах аргаар шалгах нь зөв. Харин нөөц хангалтгүй тохилдолд нийт мэдээллийн 10 хувийг түүвэрлэн, давхар оруулах аргаар шалгаж, мэдээлэл оруулах явцад гарсан алдааны түвшнийг шалгана.

### Мэдээллийн менежмент, дүн шинжилгээ хийх программ: Танд юу хэрэгтэй вэ?

Тоон мэдээллийг нэгтгэх, хөтлөх, дүн шинжилгээ хийхэд хэрэглэж болох компьютерийн олон төрлийн программ байдаг. Ямар түвшний дүн шинжилгээ хийх, ямар үнэ хөлстэй эсэх, одоо ямар үйлдлийн систем хэрэглэж байгаа, хэр хэмжээний хугацаа хэрэгтэй байгаа, программыг ашиглахад хэр хугацаа зарцуулах боломжтой эсэх гэх мэтийг тооцсоны үндсэн дээр ямар программ авахаа шийднэ.

**Эксел** (Excel) бол төсөв тооцох, хүснэгт, диаграм зурах гэх мэтээр өдөр тутам хэрэглэдэг дэлгэгдмэл хуудсан программ юм. Гэвч статистикийн суурь дүн шинжилгээг хийх боломж бүхий томъёо, үйлдэл эксел программд бийг хүн бүр мэдэхгүй байж магад. Эксел программ нь ажлын бүх компьютерт байдаг, олонх ажилтан тодорхой хэмжээнд хэрэглэдэг боловч энэ нь статистикийн суурь дүн шинжилгээ хийхэд төвөгтэйгөөс гадна мэдээллийг оруулах эсвэл дүн шинжилгээ хийх явцад алдаа гарах магадлал маш өндөр, хамгийн гол нь тэрхүү алдааг олоход тун хэцүү байдаг. Бусад статистикийн программтай адилгүйгээр эксел нь санамсаргүйгээр хүчин төгөлдөр бус мэдээлэл оруулах, кодын алдаа гаргах, мастер хуудас устгах, засварлаж байсан хэсгүүдээ олохгүй байх гэх мэт алдаа амархан гардаг.

**Аксес** (Access) бол Микрософт оффисийн программуудтай холбоотой байдаг мэдээллийн баазын программ юм. Мэдээллийн баазын программууд нь мэдээлэл оруулах дэлгэгдмэл хуудсан программтай харьцуулахад сайн ч гэсэн дүн шинжилгээ хийх талаар учир дутагдалтай. Мэдээллийн баазын программ нь мэдээлэл оруулах хуудсыг үүсгэх бөгөөд үүнд мэдээллийг оруулах, кодлох, хүчин төгөлдөр бус кодыг автоматаар таньж, татгалзах байдлаар тохиргоо хийж болно. Гэвч мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ Аксест оруулсан мэдээллээ өөр программ руу шилжүүлж хэрэглэхийг зөвлөж байна.

**Эпи инфо** (Epi Info) бол АНУ-ын Халдварт өвчний хяналтын төв (ХӨХТ)-өөс халдварт өвчний тархвар судлаачдад зориулан хийсэн программ бөгөөд нийгмийн шинжлэх ухааны судалгаануудад хэрэглэж болдог. Асуулга боловсруулах, тайлан бичих вордын үйлдлээс гадна мэдээлэл оруулах, статистикийн үндсэн дүн шинжилгээнүүдийг хийх боломж бүхий бүрэн статистикийн систем юм. Гол давуу тал нь тухайн программ нь үнэгүй, татан авахад хялбараас гадна хэрхэн хэрэглэхтэй холбоотой мэдээлэл ХӨХТ-ийн цахим хуудас (<http://www.cdc.gov/epiinfo/html/downloads.htm>)-т бий.

Хүүхэд хамгааллын санаачилгаас гаргасан Эпи инфо хувилбар 7-г ашиглах талаар товч зөвлөмжийг эндээс үзээрэй: [onenet](http://onenet.org).

**ЭсПиЭсЭс (SPSS, Нийгмийн шинжлэх ухааны статистикийн багц)** бол нийгмийн шинжлэх ухааны судалгаануудад статистикийн дүн шинжилгээ хийхэд түгээмэл хэрэглэдэг программ юм. Энэхүү иж бүрэн программаар бараг бүх төрлийн мэдээлэлд статистикийн үндсэн хийгээд нарийн дүн шинжилгээ хийж болохоос гадна график, диаграмм ч үүсгэж болно. Статистикийн дүн шинжилгээнээс гадна ЭсПиЭсЭс-ийн ажлын талбар нь хялбар талдаа, доошоо урсдаг цэс, текстийн хайрцагтай учраас түүнийг мэдээллийн менежмент хийхэд хэрэглэдэг. Гэхдээ ЭсПиЭсЭс программ үнэтэй, үндсэн багц нь хэдэн зуун ам.доллар бөгөөд мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажилтанд эрх байхгүй бол лицензийг шинэчлэх шаардлагатай болдог. Үүнээс гадна статистикийн ахисан түвшний дүн шинжилгээ хийх шаардлагагүй бол өөр программ сонирхоорой.

**Заавал хийх зүйл:** Программд оруулсан мэдээллээ хувиан, нөөц хэлбэрээр хадгалахаа мартуузай.

### Мэдээллийн хадгалалт, менежмент

**Асуулгын хуудсаар цуглуулсан бүх мэдээллийг программд оруулж дууссаны дараа оролцогчдын хувийн мэдээлэл, нууцыг хадгалахын тулд тэдгээр цаасан хэлбэрээр буй асуулгыг цоожтой, найдвартай газар хийж, тэрхүү мэдээлэлтэй хүн бүр харьцах боломжгүйгээр хадгална.** Үүнтэй адилаар оролцогчдын нууцыг хадгалах, мэдээллийг өөрчлөхөөс сэргийлэн электрон хэлбэрээр хадгалсан мэдээллийг нууц үг үүсгэн түгжиж, хүн бүр харьцах, үзэх боломжийг хаана.

Мэдээллийн файлуудыг хэд хэдэн газарт хувиан байршуулж, мастер файлаа найдвартай газарт хадгалаарай.

### Мэдээллийн цэвэрлэгээ

Мэдээлэлд дүн шинжилгээ хийхээс өмнө алдааг илрүүлж, засахыг мэдээллийн цэвэрлэгээ гэж нэрлэдэг. Буруу алгасалт, хүчингүй хариулт, буруу код, дутуу мэдээлэл зэргийг гараар хийх цэвэрлэгээний явцад олж илрүүлнэ. Асуулга тус бүрийг оруулсан мэдээлэлтэй тулган, алдааг бүртгэж, засварлана. Асуулгын судалгааны менежер эсвэл багийн ахлагч нь мэдээлэл оруулах ажилтан нэг бүрийн ажлыг тодорхой хугацааны давтамжтай хянаж, асуулгын хуудсан дахь мэдээлэл программд хэрхэн орж байгааг шалгах замаар зохих ёсоор ажиллаж буйг баталгаажуулна.

### Бүх мэдээллийг программд оруулж, мэдээллийн бааз үүсгэсний дараа мэдээллийг цэвэрлэх дараах алхмуудыг хэрэгжүүлнэ:

- 1) Асуулт тус бүрээр тоолох (нийт хариулагчийн тоо), давтамж (асуулт нэг бүрийн хариултын хувилбарын нийт тоо)–ийг шалгах замаар хариултын хувилбар дутуу орсон эсэхийг нягтлах. Хачирхалтай хариулт (жишээ нь хэт өндөр эсвэл хэт бага орлого, нас гэх мэт), хариултын хэт бага хувь (өгсөн асуултад хариулсан хүний хувь) эсвэл “мэдэхгүй” гэсэн хариултын хэт их тоо, бүр эсвэл орхигдсон мэдээлэл гэх мэт алдаа олж, засварлана.
- 2) Энгийн түвшний дүн шинжилгээг хийж, зөрчилдөж эсвэл нийцэхгүй байгаа хариултуудыг шалгах. Жишээ нь асуулгын судалгааны хариулагч нь хүйсээ эмэгтэй гэж мэдүүлсэн мөртлөө эрэгтэй оролцогчдод хамаатай асуултуудад хариулсан байгаа бол түүнд алдаа гарсан нь тодорхой. Энэ тохиолдолд хүйсийн тоонд шалгалт хийх, тухайн асуултад хариулах ёстой хүйсийн тоог тодруулах гэх мэтээр хаана нь алдаа гарсныг нягталж болно. Мэдээллийг шалгах, цэвэрлэх зорилгоор хийж буй иймэрхүү энгийн түвшний дүн шинжилгээг мэдээлэлд дүн шинжилгээ хийх ерөнхий төлөвлөгөөнд тусгавал сайн.

## 5.2. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх төлөвлөгөөг хэрэгжүүлэх

МХД–ын асуулгын судалгааг эхлүүлэх үед тавьсан асуултуудын хариуг олох нь дүн шинжилгээний гол зорилго юм. Мэдээллээс гаргаж буй үр дүнгээ тайлбарлах, дүгнэхийн тулд асуулгын судалгааны зорилго, судалгааны асуултуудаа эргэн хараарай. Дүн шинжилгээ хийх төлөвлөгөөний дагуу системтэй ажиллахын зэрэгцээ таамагласан хийгээд таамаглаагүй үр дүнг тайлбарлахад тодорхой цаг үлдээхээ мартуузай.





**Зураг 12. Ажилтнууд болон түншлэгчдийг оролцуулан хийх дүн шинжилгээ**

Мэдээллийг цуглуулан, программд оруулж дууссаны дараа мэдээллийн баазыг асуулгын судалгааны зөвлөх эсвэл статистикчид хүлээлгэн өгөөд, эцсийн тайлан ирэх хүртэл оролцохгүй байх нь элбэг. Гэвч мэдээлэлд дүн шинжилгээ хийх үйл явц нь хөтөлбөрийн ажилтнууд болон хүүхэд, үр шим хүртэгчид гэх мэт бусад түншлэгчдийг судалгаанд дахин татан оролцуулах боломж өгдөг. Үр дүнд нь тэдний дүн шинжилгээ хийх чадварыг нэмэгдүүлэх, судалгааны үр дүнг тайлбарлах, хэрэглэхэд тэдний санал бодлыг харгалзах боломжтой болно. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх үйл явцад түншлэгчдийг хэрхэн оролцуулах талаарх хоёр зөвлөгөөг дор үзүүлэв.

<b>Мэдээллийн дүн шинжилгээний уулзалт-хурал</b>	
Хөтөлбөрийн ажилтнууд болон бусад холбогдох түншлэгчдийг оролцуулсан мэдээллийн дүн шинжилгээний уулзалт-хурлын гол зорилго нь сонгосон программыг ашиглан мэдээллийг цэвэрлэх, статистикийн дүрсэлсэн дүн шинжилгээг хийх, судалгааны үр дүнг тайлбарлах, танилцуулах, дараа дараагийн судалгаагаар судлах ёстой асуудлуудыг гаргаж тавих, илүү гүнзгийн буюу нарийн түвшний дүн шинжилгээ хийх оролцогчдын чадварыг нэмэгдүүлэхэд оршино.	Асуулгын судалгааг явуулах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг гаднын байгууллагаар хийлгэж байгаа тохиолдолд тэрхүү гэрээт ажилд мэдээллийн дүн шинжилгээний уулзалт-хурлыг хийхээр тусгавал сайн.
<b>Судалгааны үр дүнг баталгаажуулах уулзалтууд</b>	
Судалгааны гол үр дүнг танилцуулах, тэдний санал бодол, тайлбар, зөвлөмжийг авах, хэлэлцэж буй асуудалтай холбоотой яриа хэлэлцүүлгийг дэмжих зорилготой янз бүрийн түвшний уулзалтыг хүүхдүүд гэх мэт түншлэгчдийн гол гол бүлгийг оролцуулсан зохион байгуулна. Иймэрхүү уулзалтууд нь судалгааны үр дүнг эцэслэн тайлбарлах, хэрэглэхэд хэрэг болохоос гадна нийгмийн хөдөлгөөн (орон нутгийн түвшинд) болон нөлөөлөл (бүсийн болон үндэсний түвшин)-ийн маш үр дүнтэй платформын үүрэг гүйцэтгэдэг.	Мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд оролцсон ажилтнууд баталгаажуулалтын уулзалтуудыг удирдан хийж болно.

Дүрсэлсэн статистикийн дүн шинжилгээг ашиглан мэдээллийн гол онцлог чанарыг илрүүлнэ. Тодруулбал дараах шинжилгээг хийнэ:

**Давтамж** буюу тухайн хариулт эсвэл интервал хэд дахин давтагдсаныг тоолох шинжилгээ. Жишээ нь эмэгтэй хариулагчийг тоо нь давтамж юм. 18–25 настай хариулагчдын тоо нь мөн давтамж юм. Давтамжийг категоричилсон буюу үргэлжилсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд голчлон хэрэглэдэг.

**Хувь** нь тухайн хариултын эзлэх пропорцыг харуулах арга юм. Ижил хариулт өгсөн оролцогчийн тоог нийт оролцогчийн тоонд хувааж, 100-аар үржүүлэн хувийг гаргана. Жишээ нь 100 оролцогчийн 25 нь 18–25 насныхан байсан бол нийт оролцогчийн 25% нь 18–25 насныхан байсан гэж үзнэ. Түүнчлэн тодорхой хариултаас салбарлуулсан үзүүлэлт гаргахад хувийг ашиглаж болно. Жишээ нь 18–25 насны нийт 25 хариулагчийн 5 нь гэрлэсэн байсан бол судалгаанд хамрагдсан 18–25 насны оролцогчдын 20% нь гэрлэсэн байна гэж хувиар илэрхийлнэ. Хувийг хэрэглэхдээ түүний хэмжээний хуваарьт анхааралтай хандаарай. Өмнөх жишээнд 20% гэж дурдсан нь нэлээд өндөр хувь мэт харагдах боловч энэ нь таван хүн л байгаа гэсэн үг. Хэрэв хуваарь нь тун бага, тодруулбал нь 50-аас доош хүнийг багтаасан бол тоогоор илэрхийлэх нь зөв.

**Харьцаа** нь хоёр бүлгийн хоорондын харилцааг харуулдаг. Жишээ нь дунд сургуульд хамрагдсан охидын тоо 25, хөвгүүдийн тоо 75 бол охид, хөвгүүдийн харьцаа нь 25:75 буюу 1:3 гэсэн үг.

**Дундажийг** тооцох хэмжүүрүүд (дундаж, медиан, моод)-ийг нэлээд түгээмэл хэрэглэнэ.

- Бүх утгын нийлбэрийг түүврийн нийт утгад хуваасныг дундаж гэнэ.
- Хувьсагчийн төв цэг буюу түүний утгатай давхцах тоог медиан гэнэ.
- Тухайн мэдээллийн баазад хамгийн их давтагдаж буй утга буюу тоог моод гэнэ.

Статистикийн дүн шинжилгээ гэдэг нь тоон мэдээллүүдийн хэв шинжийг тодорхойлно гэсэн үг. Түүнчлэн дүрсэлсэн статистикийн дүн шинжилгээний хүрээнд дараах шинжилгээг хийж болно:

➔ **Хүн амын бүлэг хоорондын ялгааг тодруулах.** Хувьсагч тус бүрээр ялгаатай оролцогчдын өгсөн хариултуудын дунд ижил эсвэл ялгаатай тал байгаа эсэхийг тооцно. Жишээ нь хүүхдийн ажил, хөдөлмөртэй холбоотой асуултын хувьд охидын өгсөн хариултыг хөвгүүдийнхтэй эсвэл төрсөн эцэг эхтэйгээ амьдарч буй хүүхдүүдийн хариултыг төрсөн эцэг эхтэйгээ амьдардаггүй хүүхдүүдийнхтэй харьцуулж болно. Тухайн үр дүн хүн амын нийт бүлэгт хамаатай байна уу эсвэл хүн амын тодорхой бүлэг (жишээ нь хүйс, нас, байршил, нийгэм-эдийн засгийн статус, боловсролын түвшин гэх мэтээр ангилсан бүлгүүд) –т л хамаатай байгаа эсэхийг тодруулах хэрэгтэй. Тухайн хувьсагчийн үр дүнд оролцогчдын нийгэм-хүн амын зүйн онцлог чанарууд нөлөөлж байна гэж үзвэл тэдгээрийг хүснэгтээр харьцуулан таамаглалаа шалгаж, ялгааг тодруулна. Жишээ нь хүүхэд хамгааллын олон нийтийн механизмын талаарх мэдлэгийг угсаатны бүлэг, байршил, орлого болон боловсролын түвшнээр харьцуулж болно. Нийт түүвэр дотор тухайн бүлэг нь бага хувийг эзлэх тохиолдолд үр дүн нь статистикийн хувьд ач холбогдолгүй байх, улмаар дүн шинжилгээ нь найдваргүйд тооцогдож болохыг байнга санах хэрэгтэй. Гэсэн хэдий ч дээр дурдсан харьцуулалтууд нь сонирхолтой байж болно.

➔ **Хамаарлыг шалгах.** Хоёр хувьсагчийн хооронд ямар нэгэн хамаарал бий эсэхийг шалгана. Жишээ нь эрт гэрлэлттэй холбоотой асуудалд хандах хандлага, дадалд боловсролын түвшин хамаатай эсэхийг шалгана гэсэн үг. Эсвэл хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэд орлого хамаатай эсэх, үрчилж авсан хүүхдээ асран халамжлах хандлагад хүйс нөлөөлж буй эсэх гэх мэтийг шалгана.



## Хүүхдийн оролцоо

Судалгааны үр дүнг тайлбарлахад хүүхэд, залуусыг идэвхтэй оролцуулах хэрэгтэй. Тэдний бодол санаа, асуудлыг харах өнцөг нь мэдээллийн дүн шинжилгээнд болон тэдэнд нөлөөтэй хөтөлбөр, аргачлалыг төлөвлөхөд хувь нэмэр оруулна.

Судалгааны үр дүнг насны онцлогт тохируулан бэлтгэж (график гэх мэтээс илүү дүрс, зураг харуулан пропорцуудыг харуулах гэх мэт), жижиг бүлгүүдийн хэлэлцүүлэг хийх бөгөөд үүгээр дамжуулан судалгааны үр дүн нь тэдний туршлагыг үнэн зөв харуулж байгаа эсэх, чухам яагаад тийм үр дүн гарсан эсэхийг тогтоохоос гадна авах арга хэмжээний санал зөвлөмж гаргахад тэдний саналыг сонсоно.

### 5.3. Үр дүнг тайлбарлах, танилцуулах

Судалгааны үр дүнг тайлбарлах, дүн шинжилгээг судалгааны асуулт, асуулгын судалгааны зорилготой холбохоос нааш асуулгын судалгааны мэдээлэл бол зүгээр л цуглуулсан тоо юм. Дүн шинжилгээ хийх явцад хөтөлбөрийн ажилтнууд, бусад түншлэгчид оролцохгүй байж болох ч судалгааны үр дүнг тайлбарлах, танилцуулах, хэрэглэх хэсэгт зайлшгүй оролцоно. **Хөтөлбөрийн ажилтнууд болон бусад түншлэгчидтэй уулзалт зохион байгуулах замаар гол хувьсагчдын дүн шинжилгээг хянах, тэдгээрийн тайлбарыг хэлэлцэн зөвшөөрөх, нэмэлт дүн шинжилгээ эсвэл чанарын судалгаа шаардлагатай асуудлыг хэлэлцэнэ.**

Ийнхүү хөтөлбөрийн түвшний ажилтнуудыг оролцуулснаар судалгааны үр дүнг хөтөлбөрт тусгах, тэдгээрийг аргачлал, шийдвэр гаргалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хэрэглэхэд анхаарч эхэлнэ. Эдгээр уулзалтаас гарсан дүгнэлтүүдийг судалгааны эцсийн тайлан болон олон нийтэд түгээх бусад материалд хэрэглэнэ.

Мэдээллийн бүхий л дүн шинжилгээг эхнээс нь хүснэгтээр гаргах нь тун хэрэгтэй (мэдээлэлд дүн шинжилгээ хийх төлөвлөгөө гаргах ажлын хүрээнд хоосон хүснэгтүүдийг хийсэн бол тэдгээрийг бөглөнө гэсэн үг). Мэдээллийг хянах, таамаглалаа шалгах, үр дүнг тайлбарлах гэх мэт үйлдлийн дараа тэдгээрийг сонирхогч талуудад тохиромжтойгоор бэлтгэн харуулах хэрэгтэй болно. Өөрөөр хэлбэл хүмүүсийн сонирхох үр дүнг сонгох, тэдгээрийг танилцуулахдаа ойлгомжтой, тодорхой болгон хүмүүст хүргэх үйл явцыг хэлж байгаа юм.

### 5.4. Мэдээллийн чанарыг баталгаажуулах

Асуулгын судалгааны гол давуу тал нь түүвэр бүлгээс гарсан үр дүнг зорилтот хүн амын том бүлэг (эх олонлог)–т тархаан хэрэглэх болох итгэлцэл, боломж юм. Итгэлцлийг статистикийн дүн шинжилгээний тодорхой зэрэг эсвэл түвшнээр хэмжинэ (жишээ нь итгэлцлийн интервал гэх мэт). Асуулгын судалгааг шинжлэх ухааны шаардлагад нийцүүлэн төлөвлөх, асуулгын судалгааны арга хэрэгслийн найдвартай байдал эсвэл үр дүнгийн нийцлийг үнэлэхэд итгэлцлийн асуудал мөн хөндөгдөж болно. Цуглуулсан мэдээллийн итгэлцлийн зэрэг өндөр байх тул үр дүн төдий чинээ нарийн гарч, хэрэглэгдэнэ гэсэн үг.

Эсрэгээр нь мэдээллийн болон дүн шинжилгээний чанарт ямар нэгэн эргэлзээ байгаа бол судалгааны үр дүн нь үнэ цэнээ алдана гэсэн үг. Иймэрхүү асуудалтай үр дүнг хөтөлбөрийн төлөвлөлт, аливаа шийдвэр гаргалтад хэрэглэх боломжгүй. **Чанар сайтай мэдээлэл гэдэг нь үнэн (зөв бүртгэгдсэн), бүрэн, шинэ, нийцэлтэй (бодит байдлыг илэрхийлсэн) байна.** “Хог оруулбал хог л гарна” хэмээх хэлц байдаг. Цуглуулсан мэдээлэл ямар байна үр дүн тийм л байна гэсэн үг.

Асуулгын судалгааны арга зүй, тодруулбал мэдээлэл цуглуулах арга хэрэгслүүд (жишээ нь асуулт тавьж байгаа байдал, хариултын хувилбарууд, код), түүвэр, түүвэрт багтсан өрх эсвэл оролцогчид, эсвэл ярилцлага хийж буй орчин нөхцөл зэргээс хамааран алдаа, төөрөгдөл гарч болно. Түүнчлэн мэдээлэл цуглуулах явцад үүссэн болон таамаглаагүй зүйлээс үүдсэн алдаанаас гадна мэдээллийг программд оруулах явцад гарсан алдаа зэргээс хамааран мэдээллийн чанар буурна. **Төөрөгдөл эсвэл алдаа гарч болох нөхцөлүүдийг урьдчилан тооцоолох, тэдгээр алдааг асуулгын судалгааг гүйцэтгэх явцад байж болох хамгийн дээд хэмжээгээр багасгахыг хичээх нь тун чухал.**

**Найдвартай байдал гэдэг нь мэдээлэл болон үнэлгээний нийцэл, түүнд итгэж болох байдлаар тодорхойлогдох бөгөөд энэ нь мэдээллийг цуглуулах, тайлбарлахад ашигласан арга хэрэгсэл, үйл явц, дүн шинжилгээний чанартай холбогдоно.**



МХД-ын асуулгын судалгааны үйл явцын ялгаатай шатуудад гарч болох мэдээллийн чанарыг бууруулах алдаа, эрсдэл, түүнийг бууруулах, багасгах зөвлөмжийг доорх хүснэгтэд үзүүлэв.

	Мэдээллийн чанарт нөлөөлж болох эрсдэл, алдаа	Алдааг багасгах зөвлөмж
Төлөвлөх	Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг муу боловсруулсан; асуултын хариултын хувилбарууд нь буруу ойлгогдохоор эсвэл “зөв” хариултад хөтөлсөн; алгасалт нь ойлгомжгүй, үүнээс үүдэн алдаа гарсан.	<ul style="list-style-type: none"> <li>Нарийн төлөвлөж, сайтар хийсэн урьдчилсан судалгаанд үндэслэн асуулгыг боловсруулж, үг хэллэгийн сонголтыг тодорхойлох</li> <li>Асуулгыг сайтар туршиж, сайжруулах</li> <li>Асуултуудын хорондын уялдааг шалгах (нэг нэгнээ шалгаж баталгаажуулах асуултууд)</li> <li>Мэргэжлийн орчуулагч ажиллуулах, бүх арга хэрэгслийг давхар орчуулах</li> </ul>
	Түүврийн дизайн эсвэл түүврийн аргаас үүдсэн алдаа (аль нэг бүлгийн хүн ам хэт их эсвэл бага хэмжээгээр сонгогдох гэх мэт)	<ul style="list-style-type: none"> <li>Зорилтот бүлгийн хүн амын гишүүдийг тодорхой хувьсагч (жишээ нь байршил, үйлчилгээний хүртээмж, боловсролын түвшин гэх мэт)-аар болон дэд хүн амын бүлгээр ялган зураглаж, түүвэр хийх</li> <li>Хүүхэд, насанд хүрэгчдийг тус тусад нь түүвэрлэх</li> <li>Түүврийн шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох</li> <li>Хүмүүсийн амьдралын хэмнэл (сургууль, ажил, бусад), шилжилт хөдөлгөөн, бусад улирлын чанартай үйл явдлууд гэх мэт түүвэрт хамрагдсан хүмүүст нөлөөлж болох зүйлийг тооцох</li> <li>Асуулгын судалгааны багийн гишүүд цөмөөрөө түүврийн үндэслэл, үйл явцыг ойлгосон байхад анхаарах</li> <li>Түүвэрлэлтийн процессыг багтаасан асуулгын судалгааны протоколыг мэдээлэл цуглуулах бүх багт өгөх</li> </ul>
Мэдээлэл цуглуулах	Мэдээлэл цуглуулагчид хариултыг буруу кодлох эсвэл дутуу хариулсан асуулгыг хүлээлгэн өгөх алдаа	<ul style="list-style-type: none"> <li>Мэдээлэл цуглуулагчдад зориулсан сургалтын явцад ярилцлагын асуултууд, тэдгээрийн хариултуудын хувилбаруудыг кодлоход хангалттай цаг гаргах, тэдэнд тодорхой удирдамж чиглэл өгөх</li> <li>Үйл явцын менежмент: Шалгах асуултууд, чиглүүлэг, ажиглалт, дүнэлт гэх мэт арга хэрэгсэл гарган, үйл ажиллагааны процедурыг хянах</li> <li>Бүх тоон хариултыг хэмжих нэгж нь асуулгын хуудсанд байх</li> </ul>
	Ярилцлага хийсэн орчин, нөхцөл хариултуудад нөлөөлөх алдаа	<ul style="list-style-type: none"> <li>Оролцогчидтой ярилцах үеэр аль болох хөндлөнгийн хүн байлгахгүйг хичээх</li> <li>Ярилцлагын явцад оролцогчид тухтай, тайван байх нөхцөл бүрдүүлэх</li> <li>Асуулга нь “тест” биш гэдгийг хүүхдүүдэд ойлгуулах</li> </ul>
	Хамгийн зохистой гэж үзэн “таалагдахыг хүссэн” хариултыг өгөх алдаа	<ul style="list-style-type: none"> <li>Асуултуудыг боловсруулахдаа аль болох объектив байдлаар томъёолох, асуултыг сөргөөр дүрслэхгүй байх</li> <li>Ярилцлагын өмнө оролцогчдод асуулгын судалгааны зорилгыг тодорхой тайлбарлах, асуултуудад зөв эсвэл буруу хариулт байхгүй, ямар нэгэн шагнал байхгүй гэдгийг хэлж ойлгуулах</li> </ul>
Мэдээллийг програмд оруулах, цэвэрлэх, дүн шинжилгээ хийх	Буруу бичих, хасах, давхар оруулах, форматыг өөрчлөх гэх мэт мэдээлэл оруулах явцад хүний хүчин зүйлээс үүдэлтэй алдаа	<ul style="list-style-type: none"> <li>Мэдээлэл оруулах ажилтнуудад зориулсан сургалт, чиглүүлэг гэх мэтийг багтаасан мэдээллийн менежментийн үйл явцыг хэрэгжүүлэх</li> <li>Мэдээллийн бүрэн эсвэл хүчин төгөлдөр байдлыг автоматаар шалгах хүчин чадал бүхий програм ашиглах (жишээ нь хүчин төгөлдөр бус мэдээлэл оруулбал хүлээж авдаггүй эсвэл засахаас нааш үргэлжлүүлэн ажиллах боломжгүй тохиргоо бүхий программ)</li> <li>Асуулгын давхар оруулан, баталгаажуулах</li> </ul>
	Цэвэрлээгүй, давхардсан эсвэл өөрчлөгдсөн мэдээлэлд дүн шинжилгээ хийх алдаа	<ul style="list-style-type: none"> <li>Мэдээллийн менежмент: Мэдээллийг хянах, нууц үгээр цоожлох боломжтой программ сонгон хэрэглэх</li> <li>Асуулга тус бүрийг тусгай дугаараар кодолж, асуулгын хуудас бүрд уг дугаарыг тавих, ингэснээр мэдээлэл давхардахаас сэргийлэх</li> <li>Мэдээллийг цуглуулах явцад эсвэл цуглуулж дуусмагц программд оруулж, цэвэрлэх</li> </ul>

Мэдээллийн чанарыг хангах нь туршлагатай судлаачийн хувьд ч хүндхэн сорилт байдаг бөгөөд хянаж үл болох эрсдэлүүд ч мэдээллийн чанарт сөргөөр нөлөөлж болно. **Тийм учраас асуулгын судалгааны тайлангийн хязгаарлалын хэсэгт үр дүнгийн чанар, хүчин төгөлдөр байдалд нөлөө үзүүлсэн эрсдэл, алдааны талаар дурдах нь нэн чухал.** Мэдээллийн хүчин төгөлдөр байдал, үр дүнгийн нийцэлтэй холбоотой асуудлыг нуух эсвэл өөрчлөн тайлбарлахаас зайлсхийх хэрэгтэй. Энэ нь ёс зүйгүй хэрэг бөгөөд дараа нь асуудал илэрвэл хийсэн судалгаа болон байгууллагад итгэх итгэлтэй холбоотой ноцтой асуудал үүснэ.



# АЛХАМ 6: Асуулгын судалгааны үр дүнг хэрэглэх нь

## Үйл ажиллагаа

- 6.1. Үр дүнг танилцуулах, хэрэглэх
- 6.2. Үр дүнг хөтөлбөрийн төлөвлөлтөд хэрэглэх
- 6.3. Үр дүнг түгээх

## Үр дүн

- ✓ Холбогдох ажилтнууд, түншүүдэд зориулан бэлтгэсэн гол үр дүнгийн танилцуулга
- ✓ Асуулгын судалгааны протоколд тусгасан түгээлт, харилцааны бусад материал
- ✓ Уулзалт, хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал, хэвлэлээр хэлэлцэн, түгээсэн үр дүн





# АЛХАМ 6: Асуулгын судалгааны үр дүнг хэрэглэх нь

Асуулгын судалгааны үр дүнг үйл ажиллагаа болгон хувиргахын тулд асуулгын судалгааны зорилго, зориултуудыг эргэн харах хэрэгтэй. Асуулгын судалгааны үр дүнг мэдээж хэрэг шинжилж, эцсийн тайланд тусгах хэрэгтэй, гэхдээ тайлан бол дөнгөж эхлэл. Тайлан бол бусад бүтээгдэхүүн, үйл ажиллагаа салбарлан гарах мастер баримт бичиг юм.



## 6.1. Үр дүнг танилцуулах, хэрэглэх

Асуулгын судалгааны менежер эсвэл судалгааг удирдаж буй зөвлөх нь асуулгын судалгааны урьдчилсан дүн шинжилгээнээс гарсан үр дүнгүүдийг хөтөлбөрийн багийнханд дараах зорилгоор аль болох хурдан танилцуулна: а) судалгааны үр дүнг хөтөлбөрт хэрэглэх үүрэг бүхий хүмүүсээс мэдээллийг тайлбарлах, илүү гүнзгий эсвэл нарийн дүн шинжилгээ шаардсан асуултуудыг тогтоохтой холбоотой саналыг нь сонсох, б) хөтөлбөрийн ажилтнуудтай үнэ цэнтэй мэдээллийг хуваалцах, улмаар тэдгээр мэдээлэл нь мэргэжлийн үйлдэл, шийдвэр, нөөцийн хуваарилалт, нөлөөлөлд хэрхэн нөлөөлж болохыг бодож тунгаах, хэлэлцэх сэдлийг үүсгэх, в) хөтөлбөрийн зорилго, түүний чанарыг сайжруулахад судалгааны үр дүнг ашиглах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах.

**Урьдчилсан болон нарийн дүн шинжилгээ дууссан үед тэрхүү үр дүнгээр бүтээгдсэн “зураг” нь эцсийн тайланд бүхлээрээ буусан байх ёстой бөгөөд тайланд асуулгын судалгааны үйл явцаас гадна үр дүнг мөн багтаасан байна.**

Судалгааны үр дүнг график, зураг болон текстээр дүрслэх бөгөөд шаардлагатай тохиолдолд зөвлөмжийг багтаана. Асуулгын судалгааны тайланг сонирхох, мэдээлэл авах хүмүүсийг тодорхойлон, түүнд үндэслэн тайлангийн формат, агуулга, гол саналыг гаргана. Хавсралт Й-д МХД-ын асуулгын судалгааны тайлангийн агуулгыг үзүүлсэн бөгөөд тоон шинжилгээг тайлбарлах, танилцуулахтай холбоотой нөөцийг нэмж судлах материалын жагсаалтад оруулсан.



## 6.2. Үр дүнг хөтөлбөрийн төлөвлөлтөд хэрэглэх

### Баримт нотолгоонд суурилсан нөлөөллийн үйл ажиллагаанд зориулан:

- ➔ МХД-ын статистикийг хүүхэд хамгааллын мэдээллийн материалууд болон хэвлэлийн багцад оруулах
- ➔ Улс төрийн удирдагчдыг сургах, хүүхэд хамгааллын асуудлыг олон нийтийн анхаарлын төвд хүргэхэд нь тэднийг дэмжих
- ➔ Хэрэгцээтэй газар нь нөөцийг хуваарилах эсвэл хууль, эрх зүйн орчныг бий болгохыг уриалах
- ➔ Ямар мэдлэг шаардлагатай байгааг харуулах эсвэл тусгай хэрэгцээтэй эсвэл эмзэг бүлгийг тодорхойлох

### Мэдээлэл харилцаанд зориулан:

- ➔ Гол санааг тусгасан мессэж бэлтгэх, түүнийг хамгийн олон хүнд хүрдэг мэдээллийн болон бусад хэрэгслээр түгээх
- ➔ Орон нутгийн онцлогт тохирсон боловсрол, сургалтын материалууд боловсруулах

### Нийгмийн хөдөлгөөнд зориулан:

- ➔ Хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлаар ойлголт нэмэгдүүлэхэд зориулсан хамгийн үр ашигтай платформ (үйл ажиллагаа, фоум, байгууллага гэх мэт)-ыг тодорхойлох
- ➔ Асуудлыг тодруулсан, түүнийг шийдвэрлэх аргыг санал болгохуйц баримтыг олон нийтийн бүлгүүд эсвэл хүүхэд хамгааллын зөвлөлүүдэд танилцуулах

### МХД-ын асуулгын судалгааны мэдээллийг тайлбарлах нь:

#### Учир шалтгаан, үр дагаврыг ойлгох нь

Мэдээллийг тайлбарлах үед анхаарах ёстой нэг чухал зүйл нь МХД-ын асуулгын судалгаа бол хоёр хувьсагч хоорондын учир шалтгаан, үр дагаврын холбоог тайлбарладаггүй гэдгийг онцлох нь чухал. Хүүхэд хамгааллын асуудлын талаарх мэдлэг болон тодорхой зан үйл хоёрын хооронд сонирхолтой хамаарал байгааг асуулгын судалгаагаар илрүүлж болох ч тэрхүү мэдлэг, зан үйл хоорондоо шууд хамааралтай гэж таамаглах нь ихэнхдээ буруу байдаг.

- ➔ Жишээ нь өөрт буй нэг “мүү” зуршлаа бодоорой. Мүү зуршил гэдгийг нь та мэднэ. Тэр зуршлаа яагаад орхихгүй байгаагаа өөрөөсөө асуу. Яавал орхих вэ?

Эерэг урамшуулал? Мүү үр дагавраас айх айдас? Ичгүүр? Таны зуршилд хандах нийгмийн хандлага? Хууль бус гэдгийг нотлох хууль эсвэл бодлого? Нөхцөл байдал?

Мэдлэг бол зан үйлд нөлөөлөх нэг л хүчин зүйл бөгөөд МХД-ын асуулгын судалгаа (бүтэцчилэгдсэн асуулга) болон түүний үр дүнд олж авсан мэдээлэл нь хүний зан үйлийн цаана буй механизм, логикийг тайлбарлахгүй. Судалгааны үр дүнг илүү сайн тайлбарлахын тулд МХД-ын асуулгын судалгааны үр дүнг чанарын судалгаа гэх мэт бусад эх сурвалжийн үр дүнтэй харьцуулж, хамтад нь авч үзэх хэрэгтэй (**Лауниала, 2009**).

## 6.3. Үр дүнг түгээх

Асуулгын судалгааны эцсийн тайланг бэлтгэн, хүүхдүүд болон бусад холбогдох хүмүүст түгээнэ. Үр дүнг түгээх уулзалтууд нь судалгааны үр дүнг ашиглан гол түншлэгчдэд нөлөөлөх үр өгөөжтэй платформ юм. Форумын иймэрхүү төрөл нь хэлэлцүүлэгт дуудах, олон талын экспертүүдийг оролцуулах бөгөөд энэ нь эргээд таны хэрэгжүүлж буй хөтөлбөрт эерэг нөлөө үзүүлж, бусад хамтрагч талын дэмжлэг, нөлөөг нэмэгдүүлнэ.

### Хүүхдийн оролцоо

Хүүхэд, залууст өөрсдийн судалгааны тайлангаа бэлтгэх, судалгааны үр дүнг үе тэнгийнхэндээ болон чухал гэж үзсэн насанд хүрэгчдэд хэрхэн танилцуулах төлөвлөгөө гаргах боломж олгоно.

Судалгааны үр дүнг тайлбарлах, баталгаажуулахын тулд хүүхдийн бүлгүүдийн дунд хэлэлцүүлэг хийх гэж байгаа бол хүүхдэд ээлтэй тайлан бэлтгэх, түгээх үйл ажиллагааг төлөвлөх үйл ажиллагааг хэлэлцүүлгийн хөтөлбөрт оруулаарай.

**Нээлттэй, хариуцлагатай байдлын үүднээс асуулгын судалгаанд цаг заваа зарцуулан, хувийн мэдээллээ хуваалцсан, цаашид хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр шимийг хүртэх магадлал бүхий хүмүүсийг судалгааны үр дүнг түгээх уулзалтад оруулах нь чухал.**

Судалгааны үр дүнг танилцуулахдаа түүнийг тэдгээр оролцогчдод ойлгомжтой байхаар бэлтгэнэ. Олон нийтийн бүлгийн уулзалт болон бусад үйл ажиллагаагаар дамжуулан судалгааны үр дүнг түгээх нь хүүхэд хамгааллын үйл ажиллагаа, үйлчилгээний төлөвлөлт, хэрэгжилтийн үр шимийг хүртэгч хүмүүсийг оролцуулах чухал хэрэгсэл болдог.

Судалгааны үр дүнг олон нийтэд түгээх нь тайлан гаргах, түүнийг тараахаар хязгаарлагдах ёсгүй. Хүүхэд хамгааллын МХД-ын асуулгын судалгааны үр дүнг түгээх зарим бүтээлч санааг дор үзүүлье:

- Богино хэмжээний кино хийх
- Судалгааны үр дүнг түгээх олон нийтийн театр, дууг бэлтгэхэд нь хүүхэд, насанд хүрэгчдийг дэмжих
- Судалгааны үр дүнд түшиглэн комик буюу түүнтэй төсөөтэй зурган тайлан гаргах
- Сэтгүүлчидтэй хамтран нийтлэл бичиж, сонинд хэвлүүлэх
- Радиод зориулсан мессэж эсвэл дуу гаргаж цацах
- Гол мессэжүүдийг хотын чанга яригчаар явуулах эсвэл орон нутгийн удирдагчдаар дамжуулан түгээх
- Зурагт хуудас, тараах материал бэлтгэх

МХД-ын асуулгын судалгааны үр дүнг хэвлэх эсвэл орон нутаг, үндэсний, олон улсын эрдэм шинжилгээний хуралд танилцуулж, илүү олон хүнд хүргэх, хүүхэд хамгааллын асуудлаар шинжлэх ухааны үндэстэй мэдээлэл, баримт нотолгоо бий болгоход хувь нэмэр оруулах талаар мөн бодолцох ёстой. Хүүхэд хамгаалал бол олон улсын хэмжээнд мэдээлэл, баримт дутмаг салбар учраас өөрсдийн бий болгосон чанар сайтай асуулгын судалгааны үр дүнг аль болох олон сувгаар түгээх нь чухал юм. Түүнчлэн асуулгын судалгааны үр дүнд үндэслэн эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, шинжлэх ухааны сэтгүүлд хэвлүүлж ч болно. Хэрвээ эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлье гэвэл асуулгын судалгаандаа ёс зүйн зөвшөөрөл авсан байх ёстой бөгөөд өгүүлэл бичих удирдамж авах, өгүүллийг бичих, хүргүүлэх талаар дэмжлэг хэрэгтэй бол ХХС-тай холбоо бариарай.

Асуулгын судалгааны үр дүнг Хүүхдийг Ивээх Сан дотор түгээх олон арга бас бий. Судалгааны тайлан, бусад бүтээгдэхүүнийг “OneNet”-д оруулж болохоос гадна Хүүхдийг Ивээх Сангийн Мэдээллийн нөөцийн төвд тайланг вэбсайтад нийтлүүлэхээр хүргүүлж болно. Хүүхдийг Ивээх сангийн сүлжээн дотор асуулгын судалгааны үр дүнгээ түгээхийг хүсвэл Нөөцийн төв (<http://resourcecentre.savethechildren.se/contact>)-тэй холбогдоорой.



# Нэмж судлах материал





## Судалгааны аргууд (МХД-ын асуулгын судалгааг оролцуулан)

1. **Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. (2008).** Сүрьеэгийн хяналтад авах нөлөөлөл, харилцаа, нийгмийн хөдөлгөөн: мэдлэг, хандлага, дадлын асуулгын судалгаа хийх удирдамж. Женев: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ). Холбоос: [http://whqlibdoc.who.int/publications/2008/9789241596176\\_eng.pdf](http://whqlibdoc.who.int/publications/2008/9789241596176_eng.pdf)  
МХД-ын асуулгын судалгааны арга зүйн ДЭМБ-ын цогц зөвлөмж. Сүрьеэг хянах хөтөлбөрт МХД-ын асуулгын судалгааг хэрхэн хэрэглэх талаар анхаарсан ч уг асуулгын судалгааны алхмууд болон аргуудын талаар тодорхой мэдээлэл багтаасан байдаг.
2. **Медесинс ду Монде. (2011, 1-р сар).** МХД-ын асуулгын судалгааны загвар (Мэдлэг, хандлага, дадал). Холбоос: <http://www.medecinsdumonde.org/Publications/Guides-a-l-usagedes-professionnels-de-l-humanitaire/Guide-Collecte-de-donneesMethodologies-qualitatives>  
Медесинс ду Монд-ийн боловсруулсан эрүүл мэндийн хөтөлбөрт МХД-ын асуулгын судалгааг хэрхэн явуулах тухай арга зүйн зөвлөмж
3. **Трохим, В. М. (2006, 10-р сарын 20).** Судалгааны аргуудын талаарх суурь мэдлэг, 2 дахь хэвлэлээс 2012 оны 11-р сарын 5-нд татан авсан. Холбоос: <http://www.socialresearchmethods.net/kb/>  
Судалгааны үндсэн үзэл баримтлал, зарчмууд болон судалгааны үйл явцыг бүрэн багтаасан вэбэд суурилсан, цогц мөртлөө хялбар гарын авлага
4. <http://gsociology.icaap.org/methods/>  
Хөтөлбөрийн үнэлгээ, нийгмийн шинжлэх ухааны судалгааны аргуудын талаар үнэ төлбөргүй нөөц материалууд бүхий вэбсайт. Хөтөлбөрийн үнэлгээ болон нийгмийн судалгааг хэрхэн хийх вэ гэдэгт анхаарсан бөгөөд фокус бүлэг, түүвэр, ярилцлага, бусад аргуудыг тайлбарласан
5. **Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвсэл. (2011).** Үнэлгээний гарын авлага. Лондон: Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвсэл. Холбоос: <http://resourcecentre.savethechildren.se/node/5459>  
Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвслээс гаргасан хөтөлбөрийн үнэлгээний зөвлөмж. Хөтөлбөрийн үнэлгээнд хүүхдийг оролцуулах арга, зохион байгуулалт (зөвлөх авах асуудлыг багтаасан), босго стандарт, санал зөвлөмж

## Ёс зүй, хүүхэд хамгааллын бодлого

1. **Шенк, К., Виллиамсон, Ж. (2005).** Олон улсын нөхцөлд хүүхэд, өсвөр насныхнаас мэдээлэл цуглуулах ёс зүйн арга хандлага: Удирдамж, нөөц. Вашингтон: Хүн амын зөвлөл. Холбоос: <http://www.popcouncil.org/pdfs/horizons/childrenethics.pdf>  
Хүүхэд, өсвөр насныхныг судалгаанд хамруулахад баримтлах ёс зүйн зарчмууд, түүнийг хэрэглэх талаарх маш сайн практик зөвлөгөө бүхий гарын авлага. Мөн олон төрлийн хэрэгсэл, жишээ маягт болон бусад нөөц гарын авлагад багтсан.
2. **СП МЕРГ. (2012).** Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээлэл цуглуулахад баримтлах ёс зүйн зарчмууд, хоёрдмол байдал, эрсдэл: Хоёрдогч баримтад суурилсан дүгнэлт судалгаа. Статистик, хяналт-шинжилгээний алба/Бодлого, стратегийн алба, НҮБ-ын Хүүхдийн Сан, Нью-Йорк. Холбоос: <http://resourcecentre.savethechildren.se/node/6777>  
Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдээлэл цуглуулахад гардаг ёс зүйн асуудлуудыг тусгасан системтэй дүгнэлт судалгаа. Хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй холбоотой асуудлаар МХД-ын асуулгын судалгаа хийх гэж байгаа бол анхаарах ёстой ёс зүйн асуудлуудыг кейс жишээгээр өгсөн байдаг.
3. **Алдерсон, П., Морров, В. (2004).** Ёс зүй, нийгмийн судалгаа, хүүхэд, залуусыг оролцуулах нь. Лондон: Барнардо. Холбоос: [www.barnardos.org.uk/resources/research\\_and\\_publications/ethicssocial-research-and-consultingwith-children-and-young-people/publication-view.jsp?pid=PUB-1158](http://www.barnardos.org.uk/resources/research_and_publications/ethicssocial-research-and-consultingwith-children-and-young-people/publication-view.jsp?pid=PUB-1158)



## Түүвэр ба статистик

1. **Еспеут, Д. (2001, 8-р сар).** Мэдлэг, дадал, тархалтын асуулгын судалгаа 2000+ Мэдээлэл цуглуулах удирдамж 2001. Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийг дэмжих төслөөс 2012 оны 11-р сарын 2-нд татаж авсан. Холбоос: [http://www.enonline.net/pool/files/ife/annex-4-kpc-surveyfield-guide-\(care\)\(1\).pdf](http://www.enonline.net/pool/files/ife/annex-4-kpc-surveyfield-guide-(care)(1).pdf)  
МХД-ын асуулгын судалгаатай хийхэд түүвэр хэрхэн сонгох болон кластер түүврийн талаар маш дэлгэрэнгүй хийгээд сайн тайлбар 5-р бүлэг (65-107-р хуудас)-т бий. Мөн 107-р хуудсанд түүврийн нөөцийн жагсаалт байгаа.
2. **Трохим, В. М. (2006, 10-р сарын 20).** Судалгааны аргуудын талаарх суурь мэдлэг, 2 дахь хэвлэлээс 2012 оны 11-р сарын 5-нд татан авсан. Холбоос: <http://www.socialresearchmethods.net/kb/sampling.php>  
Гарын авлагад түүврийн гол үзэл баримтлалын талаар энгийн мөртлөө тодорхой мэдээлэл багтсан.





## Хүүхэд хамгааллын мэдээлийн сан

- 1. Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа**  
Холбоос: [http://www.unicef.org/statistics/index\\_24302.html](http://www.unicef.org/statistics/index_24302.html)  
Бие махбодын болон сэтгэл санааны шийтгэл, хүүхдийн хөдөлмөр, эрт гэрлэлт, бэлэг эрхтнийг зэрэмдэглэх практик гэх мэт хүүхэдтэй холбоотой асуудлаар олон төрлийн мэдээлэл цуглуулах үндэсний судалгаа, НҮБ-ын Хүүхдийн Сангаас удирддаг.
- 2. ОУ-ын Хөдөлмөрийн Байгууллагын судалгаанууд**  
Холбоос: <http://www.ilo.org/ipecc/ChildlabourstatisticsSIMPOC/>  
Хүүхдийн хөдөлмөрийн хэлбэрүүд, тархалтын талаар үндэсний хийгээдбүс нутгийн хэмжээний судалгаануудыг ОУ-ын Хөдөлмөрийн Байгууллага тогтмол хийдэг.
- 3. Хүн ам зүй, эрүүл мэндийн судалгаа**  
Холбоос: <http://www.measuredhs.com/>  
Улс бүрд 2–5 жилд нэг удаа хийгдэх судалгаа бөгөөд үүнд гэр бүл төлөвлөлт, асрамж халамжийн асуудлууд, гэр бүлийн хүчирхийлэл, эрт гэрлэлт, өсвөр насныхны жирэмслэлт болон хүүхэд хамгаалалтай холбоотой сэдвүүд багтдаг.
- 4. ХДХВ/ДОХ-ын үзүүлэлт судалгаа**  
Холбоос: <http://www.measuredhs.com/What-We-Do/Survey-Types/AIS.cfm>  
ХДХВ/ДОХ-той холбоотой мэдээлийг олон улс орон тогтмол цуглуулдаг. Гэр бүлийн бүтэц, хагас болон бүтэн өнчин хүүхэд, ХДХВ/ДОХ-ын вирүстэй хүүхдэд үзүүлэх суурь үйлчилгээний хүртээмж гэх мэт хүүхэд хамгаалалд хэрэглэж болох мэдээллүүд уг судалгаанд бий.
- 5. Хүүхдийг Ивээх Сангийн Мэдээллийн нөөцийн төв**  
Холбоос: <http://resourcecentre.savethechildren.se/content/child-protection>
- 6. Дэлхийн Банкны Өгөгдлийн сан**  
Холбоос: <http://data.worldbank.org/topic>
- 7. НҮБ-ын Дүрвэгсдийн Асуудал Хариуцсан Дээд Комиссарын Газрын статистик**  
Холбоос: <http://www.unhcr.org/pages/49c3646c4d6.html>
- 8. Бэлгийн хүчирхийллийн судалгааны санаачилга**  
Холбоос: <http://www.svri.org/>
- 9. СПС суралцахуйн сүлжээ**  
Холбоос: <http://www.cpcnetwork.org/>
- 10. Африкийн Хүүхдийн бодлогын форум**  
Холбоос: <http://www.africanchildforum.org/site/>

## Хүүхдийг асуулгын судалгаанд хамруулах нь

1. **Боргерс, Н., де Лееув, Е. Д., & Хокс, Ж. (2000).** Хүүхэд асуулгын судалгааны оролцогч болох нь: Танин мэдэхүйн хөгжил ба хариултын чанар. Методологие Социологикиа бюлетин, 60–75. <http://joophox.net/publist/bms66.pdf>  
Асуулгын судалгаанд хариултын чанарт хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн үзүүлэх нөлөөг хэлэлцсэн эрдэм шинжилгээний өгүүлэл
2. **де Лееув, Е. Д. (2011).** Хүүхэд, өсвөр насныхныг асуулгын судалгаанд хамруулах үед тэдний өгсөн мэдээлийн чанарыг сайжруулах нь: Танин мэдэхүйн болон нийгмийн хөгжил ба асуулгыг боловсруулах, туршихад түүний үүрэг. [http://www.aka.fi/Tiedostot/Tiedostot/LAPSET/Presentations%20of%20the%20annual%20seminar2010-12%20May%202011/Surveying%20Children%20and%20adolescents\\_de%20Leeuw.pdf](http://www.aka.fi/Tiedostot/Tiedostot/LAPSET/Presentations%20of%20the%20annual%20seminar2010-12%20May%202011/Surveying%20Children%20and%20adolescents_de%20Leeuw.pdf)  
Асуулгын судалгааны оролцогчоор ялгаатай насны хүүхдүүдийг оролцуулахтай холбоотой гол асуудлууд, мэдээллийн чанарыг сайжруулахын тулд асуулгыг боловсруулах, туршихад анхаарах санал зөвлөмжийг багтаасан тайлан.
3. **Хүүхдийн оролцооны практик стандарт, 2005**  
Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвсэл  
<http://www.savethechildren.org.uk/resources/online-library/practicestandards-children's-participation>
4. **Хүүхэд ба оролцоо: Судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээг хүүхэд, залуустай хамтран хийх нь**  
<http://www.savethechildren.org.uk/resources/online-library/children-andparticipation-researchmonitoring-and-evaluation-children-and>
5. **Манн, Г., Толфрее, Д. (2003).** Судалгаанд хүүхдийг оролцуулах нь: Онцгой нөхцөл байдлын үед гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхдүүдийг асрах, хамгаалах төслийг хэрэгжүүлсэн эргэцүүлэл. Стокгольм: Шведийн Хүүхдийг Ивээх Сан. <http://resourcecentre.savethechildren.se/node/2740>
6. **Еннев, Ж., Платеау, Д. П. (2004).** Хүүхдэд үзүүлэх бие махбод, сэтгэл санааны шийтгэлийн асуудлыг хэрхэн судлах вэ? Бангкок: Зүүн өмнөд, Зүүн Ази, Номхон далайн бүсийн Хүүхдийг Ивээх Сан. <http://resourcecentre.savethechildren.se/node/3207>
7. **Хүүхдүүдтэй ярилцахыг хүсэв үү? Сайн туршлагын багц**  
Хүүхдийг Ивээх Сан, 2004. Стокгольм: Шведийн Хүүхдийг Ивээх Сан.  
<http://resourcecentre.savethechildren.se/node/2553>
8. **Хүүхдийг судалгаанд хамруулахыг хүсэв үү?** Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой судалгаанд хүүхдийн учир утгатай, ёс зүйтэй оролцоог хангахад дэмжлэг үзүүлэх багц  
Хүүхдийг Ивээх Сан, 2004. Стокгольм: Шведийн Хүүхдийг Ивээх Сан.  
<http://resourcecentre.savethechildren.se/node/2437>
9. **Ворралл, С. (2000).** Өсвөр насныхан судлаач болох нь: Суралцахуйн нөөцийн багц.  
Их Британий Хүүхдийг Ивээх Сан, Жозеф Роунтрее Сан  
<http://www.savethechildren.org.uk/resources/online-library/young-peopleresearchers-learningresource-pack>



# Нэр томьёоны тайлбар





# Нэр томъёоны тайлбар

НЭР ТОМЬЁО	ТОДОРХОЙЛОЛТ	ЭХ СУРВАЛЖ
<b>Хураангуй</b>	Судалгаа болон үнэлгээний тайлангийн товч	
<b>Дүн шинжилгээ</b>	Судалгааны асуултад хариулахын тулд цуглуулсан мэдээллийг задлан шинжлэх үйл явц	
<b>Суурь үзүүлэлт тогтоох мэдээлэл</b>	Төсөл эсвэл ямар нэг үйл ажиллагааны үр дүнд зорилтот хүн амд ирээдүйд гарах өөрчлөлтийг хэмжих зорилгоор суурь буюу урьдчилсан нөхцөл байдлын талаар цуглуулсан мэдээлэл	Хүүхдийг Ивээх Сан
<b>Алдаа</b>	Аливаа хэмжилтийн аргыг хэтрүүлэн эсвэл сул үнэлэх байдлаас үүдэлтэй гардаг алдаа. Харьцуулж буй бүлгүүдийн ялгаа (сонголтын алдаа), үйлчилгээний хүртээмж, бусад арга хэмжээ (үйлчилгээ)-нд хамрагдсан байдал, судалгаанд оролцохоор зөвшөөрсөн хүмүүс явцын дунд татгалзаж, гарсан байдал (хасагдлын алдаа), урьд өмнөх зүйлээ мартсан байдал (эргэн санахтай холбоотой алдаа), “зөв байх” буюу нийгэмд таалагдах хариулт өгөх алдаа (нийгэмд таалагдах хариулт өгөх алдаа), үр дүнг шалгахад гарах алдаа (илрүүлэлтийн алдаа) гэх мэт алдаа судалгааны явцад гардаг.	КПС2000+ Мэдээлэл цуглуулах зөвлөмж <a href="http://www.cochrane.org">www.cochrane.org</a>
<b>Кейс судалгаа</b>	Нэг нөхцөл байдал, нэг хувь хүн, нэг кейс эсвэл тодорхой газар, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй нэг төслийг дүрслэн харуулах арга зүйн чиг хандлага. Тэмдэглэл: Кейс судалгаа нь судалгаанд хамрагдах газрыг зориудын түүврийн аргаар сонгосон эсвэл түүврийн хэмжээ багатай байх бөгөөд бусад судалгаатай харьцуулахад судалгааны үр дүнг тархаан хэрэглэх боломж багатайгаараа ялгаатай.	Хүүхдийг Ивээх Сан
<b>Ангилсан мэдээлэл</b>	Мэдээллийг хоёр эсвэл түүнээс дээш үл давхардах ухагдахуун (хэмжүүр)-аар ангилсан байдал. Хэрэв тухайн мэдээлэл зөвхөн хоёр ухагдахуунд ангилагдсан бол түүнийг хоёр ангилалт мэдээлэл гэнэ.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Үр дагаврын нөлөө</b>	Тодорхой арга хэмжээнээс гарсан үр дагавар. Тэмдэглэл: Үр дагаврын дүн шинжилгээ нь судалж буй үзэгдэлд тухайн арга хэмжээ (интервенц)-ний үзүүлсэн нөлөөллийг тогтооход л чиглэх бөгөөд үзэгдлийн бүх учир шалтгаан, үр дагаврыг илрүүлдэггүй. “Үр нөлөө” гэх нэр томъёог үнэлж буй арга хэмжээ буюу интервенцэд л хэрэглэдэг.	Хүүхдийг Ивээх Сан
<b>Учир шалтгаан, үр дагаврын хамаарал</b>	Нэг хувьсагчийн байгаа эсвэл байхгүй байдал (хамааралтай хувьсагч) нь нөгөө хувьсагчийн байгаа эсвэл байхгүй байдал (хамааралгүй хувьсагч)-аар тодорхойлогддог хоёр хувьсагчийн хоорондын хамаарал.	<a href="http://writing.colostate.edu/guides/">http://writing.colostate.edu/guides/</a>

НЭР ТОМЬЁО	ТОДОРХОЙЛОЛТ	ЭХ СУРВАЛЖ
<b>Хүүхдийн оролцоо</b>	Үзэл бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргахад нөлөөлөх, өөрчлөлт авчрах хүүхдийн боломж. Бүх хүүхэд, нэн ялангуяа эмзэг бүлгийн, нас болон чадварын ялгаа бүхий хүүхдүүд, тэдэнд шууд, шууд бусаар нөлөөлөх асуудлуудад мэдээлэлтэй хийгээд сайн дураар оролцоно. Энэ нь гэр бүлээс Засгийн газар хүртэлх, орон нутгаас олон улсын түвшин хүртэлх бүхий л үйл ажиллагаанд баримтлах ёстой зарчим юм.	Хүүхдийг Ивээх Сан
<b>Бүлэгчилсэн (кластер) түүвэр</b>	Хувь хүмүүсээс биш харин хүн амын тодорхой бүлгүүдээс санамсаргүйгээр сонгон түүвэрлэх арга. Зорьсон түүврийн хэмжээндээ хүрэхийн тулд сонгосон бүлэг тус бүрээс тодорхой тооны хүнтэй ярилцана.	КПС2000+ Мэдээлэл цуглуулах зөвлөмж
<b>Итгэлцлийн интервал</b>	Тархалтын итгэж болох далайц. Интервал их байх тусам нарийвчлал (precision) бага, харин интервал бага байх тусам нарийвчлал их байна.	<a href="http://writing.colostate.edu/guides/">http://writing.colostate.edu/guides/</a>
<b>Итгэлцлийн хязгаар</b>	Итгэлцлийн интервалийн дээд, доод хязгаар	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Нууц хадгалах</b>	Хувь хүний нууцыг хамгаалах үйл явцыг нууц хадгалах гэнэ. Өгсөн мэдээллийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр бусдад задлахгүй гэх итгэлцлийн үндсэн дээр хувь хүний өгсөн мэдээлэлд хандахыг нууц хадгалах гэж ч болно. Хүний хувийн мэдээллийг хадгалах хэрэгцээ нь нийтийн сайн сайхны төлөө хувийн нууцыг задлах хэрэгцээний эсрэг байнга тавигдаж байдаг.	<a href="http://ccnmtl.columbia.edu/projects/cire/pac/foundation/#1_2">http://ccnmtl.columbia.edu/projects/cire/pac/foundation/#1_2</a>
<b>Эргэлзээ</b>	Арга хэмжээ буюу интервенц, түүний үр дүн хоорондын хүчин зүйл. Жишээ нь амьдрах ухааны сургалтад хамрагдсан хүүхдүүдийн хувьд БЗДХ-ын талаарх мэдлэг сайтай байсан бөгөөд тэдгээр хүүхдийн хувьд сургалтад хамрагдаагүй хүүхдүүдээс насаар ахмад байж таарсан. БЗДХ-ын мэдлэг сайтай эсвэл тааруу байх нь хүүхдийн настай холбоотой бөгөөд энэ тохиолдолд хүүхдүүдийн мэдлэгт гарсан өөрчлөлт нь сургалтын үр дүн байсан уу эсвэл наснаас болсон гэдгийг тодорхойлоход төвөгтэй болж, эргэлзээ үүсдэг. Нас нь эргэлзээ үүсгэгч хувьсагч болж байна гэсэн үг. Зориудын түүвэр бүхий судалгаанд эргэлзээт хувьсагчийн асуудал их гардаг.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрлийн маягт</b>	Судалгааны зорилго, аргын талаар судлаачийн өгсөн мэдээлэлд үндэслэн судалгаанд оролцохоор зөвшөөрч буй хүнээс авсан бичмэл баримт.	

НЭР ТОМЬЁО	ТОДОРХОЙЛОЛТ	ЭХ СУРВАЛЖ
<b>Үргэлжилсэн мэдээлэл</b>	Өгөгдсөн хүрээ, далайц доторх тодорхой бус тоон мэдээлэл. Биеийн өндөр, жин, нас зэрэг нь үргэлжилсэн хувьсагчийн жишээ юм.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Хялбар түүвэр</b>	Амар хялбар хүрч болох бүлгийг судалгаанд хамруулахаар сонгохыг хэлнэ. Энэ нь нийт хүн амын бүлгээс санамсаргүйгээр сонгосон түүвэр биш учраас тухайн хүн амыг төлөөлж чадахгүй. Арга хэмжээ буюу интервенцэд хамрагдсан бүх хүүхдийг сонгон судалгаанд хамруулах нь хялбар түүврийн жишээ юм. Мэдээж хэрэг тэдний хувьд тухайн арга хэмжээ буюу интервенцэд хамрагдаагүй бусад хүүхдээс илт ялгаатай байна.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Хамаарал</b>	Хувьсагч хоорондын холбоо хамаарал. Статистикт хоёр хувьсагч хоорондын шугаман харилцааг хамаарал гэж үзэх бөгөөд үүнийг хамаарлын коэффициентээр илэрхийлдэг. Хамаарлын коэффициент нь (-1) – (+1)-ийн хооронд хэлбэлзэх ба (-1) нь төгс сөрөг, (+1) нь төгс эерэг хамаарлыг илтгэнэ (төгс гэдэг нь хувьсагчийн заалт нь шулуун шугамд зэрэгцсэн байхыг хэлнэ). 0 хамаарлын коэффициент нь хувьсагчуудын хооронд шугаман хамаарал байхгүйг илтгэнэ.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Найдвартай байдал</b>	Судалгааны арга зүйд үндэслэн үнэн зөв тодорхойлж, дүрсэлсэн судлах зүйлийг харуулах судлаачийн чадвар	<a href="http://writing.colostate.edu/guides/">http://writing.colostate.edu/guides/</a>
<b>Мэдээлэл</b>	Цуглуулсан тоон болон чанарын мэдээлэл, баримт (ажиглалт)	Хүүхдийг Ивээх Сан
<b>Мэдээллийн цэвэрлэгээ</b>	Цуглуулсан мэдээллүүдэд буй алдааг олж, залруулах үйл явц	
<b>Мэдээлэл цуглуулах</b>	Мэдээллийн эх сурвалжийг тодорхойлж, мэдээлэл үүсгэх үйл явц, үйл ажиллагаа	Хүүхдийг Ивээх Сан
<b>Мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл</b>	Мэдээллийн эх сурвалжийг тодорхойлж, мэдээлэл цуглуулахад ашиглах аргууд. Тэмдэглэл: Албан ба албан бус асуулга, шууд ба оролцоот ажиглалт, олон нийтийн ярилцлага, фокус бүлэг, экспертийн санал бодол, кейс судалгаа, бичиг баримтын хайлт гэх мэт нь мэдээлэл цуглуулах аргуудын жишээ юм.	Хүүхдийг Ивээх Сан
<b>Хамааралтай хувьсагч</b>	Хамааралгүй хувьсагчийн өөрчлөлтөөс хамааран гарч буй үр дүн буюу хариу үйлдэл	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Дүрсэлсэн статистик</b>	Давтамж, хувь, дундаж утгаар түүврээс цугларсан мэдээллийн онцлогийг дүрслэх, дүгнэх дүн шинжилгээ. “Дүгнэсэн статистик” гэсэн тайлбарыг харна уу.	
<b>Дизайн эффект</b>	Энгийн санамсаргүй түүврийн нарийвчлалтай адил түүврийн хэмжээг бүрдүүлэхийн тулд бүлэгчилсэн санамсаргүй түүвэр хийх гэх мэт судалгааны дизайнд хэр их түүвэр хэрэгтэй болохыг харуулсан тоо	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>



НЭР ТОМЬЁО	ТОДОРХОЙЛОЛТ	ЭХ СУРВАЛЖ
<b>Нарийвчилсан ангилал</b>	Түүврийн доторх тодорхой хувьсагчууд эсвэл бүлгүүд хоорондын ялгааг харуулах зорилгоор ялгаатай хэмжүүрээр ангилсан мэдээллийн дүн шинжилгээ	Хүүхдийг Ивээх Сан
<b>Олон нийтэд түгээх</b>	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, судалгааны үр дүнг холбогдох хүмүүс (уншигч, үзэгч, сонирхогч)-т хүргэх үйл явц. Холбогдох хүмүүст гэдэгт нэн ялангуяа бидний ажиллаж буй хүүхэд, орон нутаг, засгийн газар гэх мэт үр шим хүртэгчдийг хамруулан ойлгоно.	Хүүхдийг Ивээх Сан
<b>Нөлөөллийн хэмжээ</b>	Хоёр хувьсагчийн хоорондын харилцан холбооны далайц (хэмжээ, хүрээ)	
<b>Мэдээлэл цуглуулагч</b>	Судалгаанд хамрагдаж буй газар, хүмүүсээс мэдээлэл цуглуулж буй хүн	
<b>Ёс зүйн стандарт</b>	Судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээнд шууд хамрагдаж буй хувь хүн эсвэл бүлгийг хамгаалахтай холбоотой ёс зүйн стандарт, зарчим. Нэн ялангуяа энэ нь тэдгээр хувь хүн, бүлэгт буй эрх мэдлийн зохистой хэрэглээтэй холбоотой.	Хүүхдийг Ивээх Сан
<b>Үнэлгээ</b>	Үргэлжилж буй эсвэл хэрэгжиж дууссан төсөл, хөтөлбөр, бодлого, түүний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд хийх системтэй болоод объектив шалгалт. Зорилгодоо хүрсэн байдал, нийцэл, үр ашиг, үр өгөөж, үр нөлөө, тогтвортой байдлыг тодорхойлох нь үнэлгээний гол зорилго юм. Үнэлгээ нь найдвартай хийгээд ашиглагдахуйц мэдээллийг сургамжийн хамт хүлээн авагч болон донорын аль алиных нь шийдвэр гаргах үйл явцад зориулан гаргадаг. Түүнчлэн үйл ажиллагаа, бодлого, хөтөлбөрийн ач холбогдол, үнэ цэнийг тодорхойлох үйл явц үнэлгээнд мөн хамаарагдана.	Хүүхдийг Ивээх Сан
<b>Гадаад хүчин төгөлдөр байдал</b>	Үр дүнг тархаан хэрэглэх болон бусад нөхцөлд хэрэглэж болох үнэн зөв суурийг гаргах үр дүнгийн зэрэг (үүнийг мөн тархаалт, ашиглалт гэж нэрлэдэг)	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Урьдчилсан судалгаа</b>	Судалгаа эсвэл асуулгын судалгааг төлөвлөхөд хэрэг болох мэдээллийг цуглуулах үндсэн зорилгоор явуулж байгаа судалгаа буюу мөрдлөг	
<b>Давтамж</b>	Нэг хувьсагчийг давтагдаж буй тоогоор харуулсан илэрхийлэл	
<b>Үр дүнг тархаан хэрэглэх</b>	Тухайн судалгааны үр дүн нь зөвхөн түүврийн хэмжээнд биш харин нийт зорилтот хүн амд ижил буюу үнэн байх түвшин буюу зэрэг. Үр дүнг тархаан хэрэглэхийн тулд мэдээлэл болон түүврийг арга зүйн тодорхой стандартад нийцүүлсэн байх хэрэгтэй.	Хүүхдийг Ивээх Сан

НЭР ТОМЬЁО	ТОДОРХОЙЛОЛТ	ЭХ СУРВАЛЖ
<b>Саарал эх сурвалж</b>	Хялбар хүртээмж бүхий, сэтгүүл эсвэл мэдээллийн баазад хэвлэгдээгүй эх сурвалж, материалуудыг саарал эх сурвалж гэдэг. Үүнд хурлын илтгэлийн хураангуй, хэвлэгдээгүй судалгааны ажил гэх мэт эх сурвалжийг оруулдаг.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Таамаглал</b>	Судалгаагаар шалгах ёстой батлагдаагүй онол. Таамаглалыг оновчтой шалгахын тулд түүнийг урьдчилан, маш тодорхой гаргасан байх, мөн тэрхүү таамаглалыг шалгах судалгааг сайтар төлөвлөж, хэрэгжүүлэх ёстой.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Хамааралгүй (бие даасан) хувьсагч</b>	Хамааралтай хувьсагчид нөлөө үзүүлэх харилцаа холбоотой болох нь тогтоогдсон үзүүлэлт, хүчин зүйл. Үнэлгээний судалгаанд үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь хамааралтай хувьсагч, харин арга хэмжээ буюу интервенц дэх орролцоо нь хамааралгүй хувьсагч байж болно. Нийгэм-хүн ам зүйн үзүүлэлтүүд нь хамааралгүй нэмэлт хувьсагчууд болж болно.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Индекс</b>	Судалгаанд оролцогчдыг үргэлжилсэн болон харьцангуй шкалд оруулахын тулд ялгаатай олон хувьсагчуудыг нэгтгэн гаргасан холимог хэмжүүрийг индекс гэнэ. Жишээ нь өрхийн орлогын мэдээлэл байхгүй эсвэл амьдралын стандартын хүчин төгөлдөр хэмжүүр байхгүй тохиолдолд өрхийн амьдралын ерөнхий стандартыг гаргах зорилгоор эд хөрөнгийн индексийг олон асуулгын судалгаанд хэрэглэдэг. Өрхийн эд хөрөнгө, орон байраа барихад ашигласан материал, ус болон ариун цэврийн байгууламжийн хүртээмжийн хэлбэр гэсэн мэдээлэлд үндэслэн эд хөрөнгийн индексийг тооцдог.	
<b>Шалгуур үзүүлэлт</b>	Арга хэмжээ буюу интервенцтэй холбоотой өөрчлөлтийг харуулсан үр дүнг хэмжих энгийн хэрнээ найдвартай үзүүлэлтийг харуулдаг тоон болон чанарын хүчин зүйл эсвэл хувьсагч	Хүүхдийг Ивээх Сан
<b>Дүгнэсэн статистик</b>	Түүврээс хүн амын тухайн бүлэгт тархаах зорилготой ашигладаг статистик дүн шинжилгээнүүд. Дүгнэсэн статистик нь таамаглал эсвэл хоёр хувьсагч хоорондын харилцаа холбоог шалгах гэх мэтээр цуглуулсан мэдээлэлд хийх дүгнэлт хийх өргөжүүлсэн дүн шинжилгээ хийх статистикуудын тест юм.	
<b>Мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрөл</b>	Судалгаатай холбоотой мэдээлийг авч, хангалттай ойлголттой болсны дараа уг судалгаанд оролцохоор зөвшөөрсөн хувь хүний мэдэгдэл. “Зөвшөөрөл” гэдэг нь судалгааны талаар бүрэн дүүрэн ойлголт, мэдээллийг авсан (өгсөн) эсэхийг дурдаагүй, зөвхөн сайн дураар зөвшөөрсөн гэсэн санааг агуулдаг. Харин мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрөл гэдэг нь тухайн хувь хүн судалгааны талаар хангалттай мэдээлэл авсны дараа оролцох эсэхээ шийдэж, зөвшөөрөл өгдөг үйл явц юм.	

НЭР ТОМЬЁО	ТОДОРХОЙЛОЛТ	ЭХ СУРВАЛЖ
<b>Дотоод хүчин төгөлдөр байдал</b>	Судалгааны дизайн болон судалгааг хийх явц нь гарч болох алдаанаас урьдчилсан сэргийлсэн байх байдал	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Ярилцлага</b>	Судлаач буюу мэдээлэл цуглуулагч нь судалгаанд оролцогч хүнд асуулт тавьж, хариулт авах хэлбэрээр явагддаг судалгааны арга хэрэгсэл	<a href="http://writing.colostate.edu/guides/">http://writing.colostate.edu/guides/</a>
<b>Ярилцлагыг хөтөлгөч</b>	Ярилцлагын явцад асуулт тавьж буй хүн. Мэдээлэл цуглуулагч гэсэн нэр томьёог харна уу.	
<b>Лайкертын шкал</b>	Өгөгдсөн бодомжуудтай хэр зэрэг санал нийлж эсвэл нийлэхгүй байгааг оролцогчдоос асуудаг хэмжүүрийн шкал	
<b>Хязгаарлал</b>	Судалгааны үр дүнгийн тайлбар, хэрэглээнд нөлөө үзүүлдэг дизайн болон арга зүйн онцлог. Судалгааны дизайн болон дотоод, гадаад хүчин төгөлдөр байдлыг хангахаар хэрэглэсэн арга зэргээс хамааран судалгааны үр дүнг тархаах, хэрэглэхтэй холбоотой гардаг хүндрэл.	
<b>Баримт бичгийн дүн шинжилгээ</b>	Тухайн сэдвийн талаарх бүхий л мэдээллийг хэвлэгдсэн эх сурвалжуудаас олж, судлах системтэй үйл явц	
<b>Зөрүүгийн харьцаа (боломжийн харьцаа)</b>	Нэг бүлэг дэх зүйлийн зөрүү, нөгөө бүлэг дэх зүйлийн зөрүү хоорондын харьцаа. Эмчилгээний нөлөөллийн талаарх судалгаанд эмчилгээний бүлгийн зөрүү нь хяналтын бүлгийн зөрүүд хуваагддаг. Зөрүү харьцаа 1 бол харьцуулж буй бүлгүүдэд ялгаа байхгүй гэсэн үг. Харин 1-ээс бага байвал тухайн арга хэмжээ буюу интервенц нь эрсдэлийг бууруулах үр нөлөө үзүүлсэн гэсэн үг. Эрсдэл тун бага үед зөрүү харьцаа нь эрсдэлийн харьцаатай бараг ижил байна.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Дараалсан шкал</b>	Мэдээллийг эрэмбэлж байрлуулсан үзүүлэлтээр хэмждэг шкал	
<b>Оролцогч</b>	Түүврийн нэг хэсэг болон судалгаанд оролцож буй хувь хүнийг судалгаанд оролцогч гэдэг (Хариулагч гэдэг хэсгийг харна уу). Хөтөлбөр, төслийн хувьд оролцогч гэдэг нь төслийн арга хэмжээ буюу интервенцийн үр шимийг хүртэгчийг хэлдэг.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Нарийвчлал</b>	Судалгааны үр дүн эсвэл хэмжүүрт гарч болох санамсаргүй алдаанд хийх хэмжилт. Нарийвчлал хэр сайн байна, төдий чинээ санамсаргүй алдаа бага гарна. Итгэлцлийн интервал нь нарийвчлалыг харуулах нэг арга бөгөөд уг интервал нарийсах тусам нарийвчлал өндөр байгааг заана.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Тархалт</b>	Хүн амын өгсөн хариулт эсвэл үзэгдлийн пропорц. Тархалтын түвшнийг нэг хариултын категорийг нийт хүн амд хуваасан тооны үзүүлэлтээр тооцоологдох хувь юм.	
<b>Магадлал</b>	Ямар нэг зүйлийн тохиолдох боломж эсвэл эрсдэл	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Протокол</b>	Судалгаа хийхэд дагах ёстой төлөвлөгөө эсвэл алхмуудын багц	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>



НЭР ТОМЬЁО	ТОДОРХОЙЛОЛТ	ЭХ СУРВАЛЖ
<b>Чанарын</b>	Олон нийтийн гишүүдтэй хийсэн уулзалт эсвэл ажиглалтын тэмдэглэл гэх мэт тоон хэлбэрээр тайлбарлаж, гаргаж болохгүй зүйл	Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан/Хүүхдийг Ивээх Сан
<b>Чанарын судалгаа</b>	Тоон мэдээллээс биш харин тесктэн (бичмэл) мэдээлэл ашиглан үзэгдэл хоорондын харилцаа холбоог тодруулахад чиглэсэн судалгаа. Чанарын судалгааны үр дүнг ерөнхийдөө тархаан хэрэглэдэггүй, харин “шилжүүлж” хэрэглэх боломжтой. Кейс судалгаа, ажиглалт, этнографийн судалгаа нь чанарын судалгааны жишээ юм.	<a href="http://writing.colostate.edu/guides/">http://writing.colostate.edu/guides/</a>
<b>Тоон</b>	Тоогоор илэрхийлэгдсэн буюу илэрхийлж болохуйц эсвэл хэмжигдсэн, хэмжиж болохуйц зүйл	Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан/Хүүхдийг Ивээх Сан
<b>Тоон судалгаа</b>	Тоон мэдээлэл ашиглан үзэгдлийн хоорондын харилцаа холбоог илрүүлэх судалгаа. Хэдийгээр судалгааны дизайнаас хамаарах боловч тоон судалгааны үр дүнг тархаан хэрэглэж болдог. Асуулгын судалгаа, сорил нь чанарын судалгааны аргууд юм.	<a href="http://writing.colostate.edu/guides/">http://writing.colostate.edu/guides/</a>
<b>Санамсаргүй түүвэр</b>	Нэгж бүр сонгогдох тэгш боломжоор хангагдсан байх, эх олонлогийг аль болох бүрэн төлөөлөх түүврийг сонгох зорилготой түүврийн арга. Хялбар түүврийн аргатай харьцуулахад энэ түүврийн арга нь алдаа бага гарахад нөлөөлдөг.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Хүрээ, далайц</b>	Тархалтын хамгийн бага, хамгийн өндөр оноо хоорондын ялгаа	<a href="http://writing.colostate.edu/guides/">http://writing.colostate.edu/guides/</a>
<b>Эргэн санахтай холбоотой алдаа</b>	Ой санамж муудсанаас эсвэл болсон зүйлийн талаар үзэл бодол нь өөрчлөгдөх гэх мэтээр өмнө болсон зүйлийн эргэн санахтай холбоотой гардаг алдаа. Тиймээс хүмүүс 2 жилийн өмнө тохиолдсон зүйл, түүний талаар юу бодож байсныг эргэн санахаас илүү яг одоо тохиолдож зүйлийн талаар илүү үнэн зөв мэдээллийг өгдөг.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Найдвартай байдал</b>	Судалгааны арга хэрэгсэл, мэдээлэл цуглуулах процедур, цугларсан мэдээллийг тайлбарлах, дүн шинжилгээ хийх арга зүй зэргийн чанараар тодорхойлогдсон мэдээллийн нийцэл, итгэлтэй байдал	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Хүүхдийг Ивээх Сан
<b>Хариулагч</b>	Асуулгын судалгаа, ярилцлага, фокус бүлгийн ярилцлагын асуултуудад хариулж буй хүн. Оролцогч гэсэн нэр томьёоны тайлбарыг харна уу.	
<b>Хариултын түвшин</b>	Судалгаан дахь оролцооны түвшин	
<b>Шинжлэх ухааны судалгааны шалгуур</b>	Ач холбогдол бүхий үр нөлөөг мэдэх, түүнийг хянахын тулд судалгааны аргуудыг үнэн шударгаар хэрэглэх зэрэг	<a href="http://writing.colostate.edu/guides/">http://writing.colostate.edu/guides/</a>
<b>Түүвэр</b>	Зорилтот хүн амын нэг хэсэг. Нийт зорилтот хүн амын онцлог, параметруудийг тодорхойлох зорилгоор түүвэр сонгодог. Нийт зорилтот хүн амаас түүнийг төлөөлөх хэсгийг сонгох үйлдлийг түүвэр гэнэ.	Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан/Хүүхдийг Ивээх Сан

НЭР ТОМЬЁО	ТОДОРХОЙЛОЛТ	ЭХ СУРВАЛЖ
<b>Түүврийн хэмжээ</b>	Нийт зорилтот хүн амаас судалгаанд хамруулахаар сонгосон нэгж (хувь хүн, өрх гэх мэт)-ийн тоо	КПС2000+ Мэдээлэл цуглуулах зөвлөмж
<b>Түүвэрлэлтийн хүрээ</b>	Түүвэрт хамрагдах нийт зорилтот бүлгийн гишүүн/ нэгжийн жагсаалт (үүнд тухайн зорилтот бүлэгт хамрагдахгүй хүмүүс орохгүй)	<a href="http://writing.colostate.edu/guides/">http://writing.colostate.edu/guides/</a>
<b>Ач холбогдлын түвшин</b>	Үзэгдлийн хоорондын харилцаа холбоо нь тохиолдлынх байх магадлал. Жишээ нь 0,5 ач холбогдлын түвшин нь тухайн харилцаа холбоо нь тохиолдлын байх магадлал 100-аас 5 хувийн магадлалтай гэсэн үг.	
<b>Статистикийн дүн шинжилгээ</b>	Түүврийн тодорхой аргыг ашиглан эх олонлогоос түүвэрлэн цуглуулсан мэдээлэлд үндэслэн тухайн ухагдахууныг дүрслэх, илрүүлэх, ойлгох, батлах, тааварлах арга техникүүдийн олон төрлийн багтаасан статистикийн дүн шинжилгээ	
<b>Статистикийн хувьд ач холбогдолтой</b>	Тохиолдлоор гараагүй байх магадлалтай үр дүн. Хэрэв тэг таамаглал зөв бол магадлалын боломж нь 0.05-аас бага байх босгыг статистикийн ач холбогдолтой гэж үздэг. Үүнийг хэмжихэд ашигладаг p тоог статистикийн шинжилгээгээр гаргана.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Үечлэл</b>	Нас, хүйс, бүлэг, нийгэм-эдийн засгийн статус гэх мэт онцлогоороо адил дэд бүлгүүдэд хүн амын бүлгийн хуваах үйл явц. Ямар нэг үйлчлэлийн нөлөө нь ялгаатай дэд бүлгүүдэд ялгаатай илэрч байгаа эсэхийг харахын тулд иймэрхүү ялгаатай үечлэлийг хэрэглэн харьцуулах боломжтой.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>
<b>Судалгаа</b>	Тодорхой хүн амын бүлэг эсвэл сэдвийн талаар нарийн мэдээлэл олж авах зорилгоор хийдэг судалгааны болон үнэлгээний ажлын цогц. Ялгаатай мэдээллийг цуглуулж, ялгаатай түвшний дүн шинжилгээ хийх үүднээс судалгаа нь нэг эсвэл хэд хэдэн аргыг хослуулан хэрэглэдэг.	
<b>Асуулгын судалгаа</b>	Тодорхой цаг хугацаанд хүн амын тодорхой бүлгийн онцлог чанарыг хэмжихэд хэрэглэдэг тоон судалгааны арга. Асуулгын судалгаа нь нээлттэй эсвэл хаалттай төгсгөлтэй асуултуудыг багтаах бөгөөд эдгээр асуултын хариултыг амаар эсвэл бичгээр авна. Асуулгын судалгааны зорилго нь тодорхой хүн амын бүлэг эсвэл тухайн бүлгийн хүн амын түүвэр бүлгээс нарийн мэдээлэл олж авах явдал. Голдуу тодорхой бүлгийн хүн амын хандлага, итгэл үнэмшил, мэдлэг эсвэл зан үйлийг ойлгоход уг судалгааг хэрэглэнэ.	<a href="http://writing.colostate.edu/guides/">http://writing.colostate.edu/guides/</a>
<b>Асуулгын судалгааны хүн ам</b>	Тухайн асуулгын судалгаанд хамаарагдах зорилтот хүн амын нийт бүлэг (эх олонлог)	<a href="http://writing.colostate.edu/guides/">http://writing.colostate.edu/guides/</a>

НЭР ТОМЬЁО	ТОДОРХОЙЛОЛТ	ЭХ СУРВАЛЖ
<b>Шилжүүлэн хэрэглэх боломж</b>	Судалгааны үр дүнг ижил нөхцөл байдал бүхий өөр хам орчинд шилжүүлэн хэрэглэх боломж. Мөн судалгааны элементүүд болон өөрсдийн туршлагаа холбон үзэхийг уншигчдаас хүсэх байдал.	<a href="http://writing.colostate.edu/guides/">http://writing.colostate.edu/guides/</a>
<b>Харьцуулалт (triangulation)</b>	Тухайн нөхцөл байдлыг хэмжих, үнэлэхийн тулд гурав болон түүнээс дээш онол, мэдээллийн эх сурвалж эсвэл дүн шинжилгээний арга ашиглахыг харьцуулалт гэнэ. Тэмдэглэл: Олон талын эх сурвалж, арга, дүн шинжилгээ, онолыг хослуулах замаар нэг эх сурвалж, нэг арга, нэг ажиглагч эсвэл нэг онолоос гарах алдааг даван туулах оролдлого. Хүчин төгөлдөр байдал гэдгийг харна уу.	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Хүүхдийг Ивээх Сан
<b>Хүчин төгөлдөр байдал</b>	Нэг хяналт-шинжилгээний аргаар дамжуулан олсон мэдээлэл нөгөө аргаар олсон мэдээлэлтэй тохирч байгаа эсэхийг харьцуулах үйл явц.	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Хүүхдийг Ивээх Сан
<b>Хүчин төгөлдөр</b>	Мэдээлэл цуглуулах стратеги, арга хэрэгсэл нь хэмжихийг зорьсон зүйлээ хэмжиж байгаа байдлын зэрэг эсвэл түвшин	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Хүүхдийг Ивээх Сан
<b>Хувьсагч</b>	Хувь хүмүүсийн дунд ялгаатай байх ажиглагдахуйц онцлог шинж чанарууд	<a href="http://writing.colostate.edu/guides/">http://writing.colostate.edu/guides/</a>
<b>Хувьсагч</b>	Онцлог, шинж чанар, үр дүн, үзүүлэлт	
<b>Хувьсагч</b>	Хүн амын ялгаатай бүлгүүдийн дотор болон хооронд өөр өөр байх хүчин зүйл. Нас, хүйс, боловсрол, гэрлэлтийн байдал зэрэг онцлог шинж, булчингийн тойрог, хөрөнгийн эсвэл мэдлэгийн индекс гэх мэт хэмжүүр, эсвэл төслийн тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг ч хувьсагч гэдэг. Хүн амын бүлэг эсвэл түүвэр дэх хувьсагчийг тархалт гэнэ.	<a href="http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf">http://www.cochrane.org/sites/default/files/uploads/glossary.pdf</a>



# Хавсралт

**Хавсралт А:** Асуулгын судалгааны ажлын даалгаврын загвар

**Хавсралт Б:** Төсвийн загвар

**Хавсралт В:** МХД-ын асуулгын судалгааны зөвлөхийн ажлын даалгавар

**Хавсралт Г:** Мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрлийн маягт

**Хавсралт Д:** Ажлын төлөвлөгөөний жишээ

**Хавсралт Е:** Асуулгын жишээ

**Хавсралт Ё:** Мэдээлэл цуглуулах багийн ахлагчийн ажлын даалгавар

**Хавсралт Ж:** Мэдээлэл цуглуулагчийн ажлын даалгавар

**Хавсралт З:** Асуулгын судалгааны багийн гишүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр

**Хавсралт И:** Мэдээлэл цуглуулах явцад өдөр тутмын дүгнэлт тэмдэглэх хэрэгсэл

**Хавсралт Й:** МХД-ын асуулгын судалгааны тайлангийн агуулга



# Хавсралт А: Асуулгын судалгааны ажлын даалгаврын загвар

## Ажлын даалгавар

**Жендэр, Зүүн болон Өмнөд Ази, Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар МХД-ын асуулгын судалгаа**  
**[Төсөл, хөтөлбөрийн нэр, улс орны төлөөлөгчийн газрын мэдээллийг оруулах]**

- 1) Үндсэн мэдээлэл**  
[Хүүхдийг Ивээх Сангийн хөтөлбөртэй холбоотой тулгамдаж буй асуудлыг баримт нотолгоогоор дүгнэн бичих, МХД-ын асуулгын судалгаагаар судалж шинжлэх гол асуудлууд, мэдээллийн хэрэгцээг дурдах]
- 2) МХД-ын асуулгын судалгааны хүрээ, зорилго**  
[МХД-ын асуулгын судалгааны хүрээ, зорилгыг танилцуулах]
- 3) Судлах үндсэн асуудлууд**  
[Төсөл, хөтөлбөрийн логик хүрээнд буй тодорхой шалгуур үзүүлэлтүүд гэх мэтийг багтаасан МХД-ын асуулгын судалгаагаар судлах ёстой үндсэн асуудлуудыг жагсаан бичих]
- 4) Дизайн, арга зүй**  
[Асуулгын судалгааны арга зүйг дүрслэх, үүнд судлагдсан байдал, урьдчилсан болон нэмэлт судалгаа зэргийг багтаах]
- 5) Менежмент, үүрэг хариуцлага**  
[Асуулгын судалгааг хэрхэн явуулахыг бичих, асуулгын судалгаанд тухайн байгууллага болон ажилтнуудын үүрэг, оролцоог тодорхойлох, уг судалгаанд гаднаас эсвэл дотоодоос ашиглах мэргэжлийн дэмжлэгийн талаар холбогдох мэдээллийг оруулах]
- 6) Үр дүн (бүтээгдэхүүн)**  
[Асуулгын судалгааны эцэслэсэн протокол, туршиж сайжруулсан мэдээлэл цуглуулах хэрэгслүүд, цэвэрлэж, баталгаажуулсан болвсруулалт хийгдээгүй мэдээллийн бааз, сургалтын материалууд, урьдчилсан болон эцсийн дүн шинжилгээ, санал зөвлөмжийг багтаасан МХД-ын асуулгын судалгааны тайлан, танилцуулга, тойм мэдээлэл, тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл, харилцааны гэх мэт тараах, түгээх материалууд зэрэг үр дүн буюу бүтээгдэхүүнийг дурдах]
- 7) Хугацаа**
- 8) Төсөв ба бусад нөөц**
- 9) Асуулгын судалгааны үр дүн, найдвартай байдал суралцахуйг түгээх төлөвлөгөө**  
[Үр дүнг хэрхэн хэрэглэх, түгээх талаар бичих]

# Хавсралт Б: Төсвийн загвар

Нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ (А)	Тоо (Б)	Нийт төсөв (АхБ)	Тэмдэглэл
<b>1. Хүн</b> Гадаад зөвлөх Дотоодоос авах мэргэжлийн дэмжлэг Мэдээлэл цуглуулах багийн ахлагчид Мэдээлэл цуглуулагчид Мэдээлэл оруулах ажилтнууд Хүнтэй холбоотой төсвийн дэд дүн					
<b>2. Нислэг</b> (олон улсын мэргэжлийн дэмжлэг ба зөвлөхтэй холбоотой) Олон улсын нислэг Орон нутгийн нислэг Нислэгтэй холбоотой төсвийн дэд дүн					
<b>3. Асуулгын судалгааны багийн сургалт</b> Унаа Байр, томилолт Сургалтын танхим Сургалттай холбоотой төсвийн дэд дүн					
<b>4. Тоног төхөөрөмж</b> (принтер, хувилагч, зөөврийн компьютер, дуу хураагуур, утас гэх мэт) Тоног төхөөрөмжтэй холбоотой төсвийн дэд дүн					
<b>5. Материал</b> Хэвлэх, хувилах Самбар Бал, бичиг хэрэгсэл Материалтай холбоотой төсвийн дэд дүн					
<b>6. Мэдээлэл цуглуулах хэрэгслийг боловсруулах</b> Мэдээлэл цуглуулах хэрэгслийг турших Мэдээлэл цуглуулах хэрэгслийг орчуулах Мэдээлэл цуглуулах хэрэгслийн боловсруулалттай төсвийн дэд дүн					
<b>7. Мэдээлэл цуглуулах</b> Унаа Томилолт Байр Харилцаа холбоо Мэдээлэл цуглуулалттай холбоотой төсвийн дэд дүн					
<b>8. Мэдээллийг программд оруулах, дүн шинжилгээ хийх, тайлан бичих</b> Мэдээллийн менежмент, дүн шинжилгээ хийх программ, гарын авлага Мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үр дүнг баталгаажуулах уулзалт зохион байгуулах Мэдээлэлд дн шинжилгээ хийхтэй холбоотой төсвийн дэд дүн					
<b>9. Түгээх</b> Материалуудыг боловсруулах, орчуулах Хэвлэх Уулзалт Түгээхтэй холбоотой төсвийн дэд дүн					
<b>10. Гэнэтийн, урьдчилан тооцоогүй зүйлийн төсөв</b>					
<b>НИЙТ ТӨСӨВ</b>					



# Хавсралт В: МХД-ын асуулгын судалгааны зөвлөхийн ажлын даалгавар

## Ажлын даалгавар

### МХД-ын асуулгын судалгааг удирдах зөвлөх

[Төсөл, хөтөлбөрийн нэр, улс орны төлөөлөгчийн газрын мэдээллийг оруулах]

**Ажлын хугацаа:** [Өдрөөр эсвэл долоо хоногоор оруулах]

**Ажлыг эхлэх хугацаа:**

**Ажлыг дуусгах хугацаа:**

- 1. Үндсэн мэдээлэл**  
[Асуулгын судалгааны ажлын даалгавраас үндсэн мэдээллийг хуулан оруулах]
- 2. МХД-ын асуулгын судалгааны зорилго**  
[Асуулгын судалгааны ажлын даалгавраас зорилгыг хуулан оруулах]
- 3. Зөвлөх ажлын үндсэн зорилго**  
[Гаднаас зөвлөх авах шалтгаан, асуулгын судалгааг хийхэд хэрэгтэй болсон мэдлэг туршлага гэх мэтийг багтаасан зөвлөх ажлын үндсэн зорилгыг жагсаах]
- 4. Арга зүй, ажлын төлөвлөгөө**  
[Асуулгын судалгааны арга зүйг бичих, зөвлөхийн хийх ёстой ажил, түүнийг гүйцэтгэх хугацаа зэргийг багтаасан ажлын төлөвлөгөө гаргах. Асуулгын судалгааны арга зүйг боловсруулах эсвэл сайжруулах ажлыг зөвлөх хийх нь түгээмэл бөгөөд зөвлөх ажлаа эхлэнгүүт дээрх төлөвлөгөөнд бага зэргийн өөрчлөлт оруулж болно. Төлөвлөгөө гаргахад дараах загварыг ашиглаж болно.]

ҮЙЛ АЖИЛЛАГАА	ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА	АЖЛЫГ ДУУСГАХ ХУГАЦАА
Жишээ нь бичиг баримтын шинжилгээ		
Нийт		

- 5. Хүлээлгэж өгөх бүтээгдэхүүн**  
[Зөвлөхийн хүлээлгэж өгөх бүтээгдэхүүний жагсаалтыг гаргах, үүнд асуулгын судалгааны протокол, мэдээлэл цуглуулах бүх хэрэгсэл, тайлан, сургалтын материалууд гэх мэтийг багтаана]
- 6. Зөвлөхийн болон Хүүхдийг Ивээх Сангийн үүрэг, хариулага**  
[Хүүхдийг Ивээх Санг төлөөлөн асуулгын судалгааг хэн хариуцан зохицуулах, менежмент болон шийдвэр гаргалтыг ямар байдлаар зохион байгуулахыг бичих. Асуулгын судалгааны багийн бүрэлдэхүүнийг дурдах, асуулгын судалгааг мэргэжлийн дэмжлэг, материалаар хангах, Хүүхдийг Ивээх Сангаас гаргах мэдээлэл, хэрэглэгдэхүүн, нөөц гэх мэтчилэн зөвлөхийн болон Хүүхдийг Ивээх Сангийн хувь нэмэр, оролцоог тодруулах. Жишээ нь төслийн баримт бичиг, орчуулгын үйлчилгээ, захиргаа, ложистик, баг сонгон шалгаруулахад үзүүлэх дэмжлэг, ажлын өрөө, хурлын танхим, харилцаа холбоо гэх мэт]

## 7. Нөхцөл

## 8. Зөвлөхөд тавих шаардлага

[Зөвлөхөд байх ёстой мэргэжлийн чадамжуудыг тодруулан бичих, ингэхдээ дараах зөвлөмжөөс санаа авах]

### Мэргэжлийн чадамж

- Хөгжиж буй улс орнууд, нэн ялангуяа бүсийн түвшний улс орнуудын хүүхэд хамгааллын асуудлаар арвин мэдлэг, туршлагатай
- Тоон болон чанарын аргуудыг хэрэглэн судалгааны ажил эрхэлж байсан хамгийн багадаа таван жилийн туршлагатай
- Асуулгын судалгааны дизайн, түүвэр хийх чадвартай
- Мэдээллийн менежмент, дүн шинжилгээ хийх чадвартай
- ЭсПиЭсЭс, СТАТА гэх мэт статистикийн програмуудыг сайн ашигладаг
- Сургалт хийх чадвартай
- Бүх түвшинд ялгаатай олон багийг зохицуулах, хувь хүн эсвэл бүлэгтэй харилцах чадвартай
- Шинжлэн дүгнэх, танилцуулах, бичих үр чадвартай

### Мэргэшил

- Хүүхэд, нийгмийн хамгаалал, статистик, нийгмийн ухаан болон бусад холбогдох мэргэжлийн чиглэлээр мастер эсвэл доктор зэрэгтэй
- Олон улсын төслийн менежмент, ялангуяа нийгмийн ухааны судалгаанд ажиллаж байсан туршлагатай
- Олон улсын хүүхэд хамгааллын хөтөлбөрийн талаар туршлагатай

### Бусад

- Хүүхдийг Ивээх Сангийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлийг хүндэтгэн, хүлээн зөвшөөрч, даган мөрдөх хүсэл эрмэлзэлтэй
- Хүүхдийн эрхийн хөтөлбөрүүдэд ажиллаж байсан туршлагатай бол давуу тал
- Соёл, жендэр, шашин шүтлэг, арьс өнгө, яс үндэс, насны ялгааг хүлээн зөвшөөрөх, Хүүхдийг Ивээх Сангийн хүүхэд хамгааллын бодлогыг бүрэн дүүрэн мөрдөх

# Хавсралт Г: Мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрлийн маягт

## Мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрөл

### “Хүүхэд хамгааллын мэдлэг, хандлага, дадлын асуулгын судалгаа”

Хүүхдийг Ивээх Сан [Төсөл, хөтөлбөрийн нэр, улс орны төлөөлөгчийн газрын мэдээллийг оруулах]

Сайн байна уу? Миний нэрийг [нэрээ бичих] гэдэг. Би Хүүхдийг Ивээх Санд ажилладаг бөгөөд [хэрэгжүүлж буй төсөл эсвэл асуулгын судалгааны гол чиглэлийг бичих]-тэй холбоотой асуудлаар таны амьдардаг дүүргийн хүүхэд, гэр бүлд тусалж дэмжих боломжийг тодруулахаар зорьж буй багийн гишүүн. Бид энэхүү судалгааг [газруудын нэр бичих] явуулж байгаа. Судалгаагаар цуглуулсан мэдээлэл нь [судалгааны гол зорилгыг бичих, жишээ нь хөтөлбөрийн үйл ажиллагааг төлөвлөх, хөтөлбөрийн суурь үзүүлэлтийг тогтоох, хөтөлбөрийг үнэлэх, баримт нотолгоо бүрдүүлэх гэх мэт]-д Хүүхдийг Ивээх Санд тусална.

Танай гэр бүлийг энэ судалгаанд хамруулахаар сонгосон юм. Хэрэв та судалгаанд оролцохоор зөвшөөрвөл танд асуулт тавьж, хариултыг тэмдэглэж авах болно. Гэр бүлдээ болон олон нийтийн орчинд хүүхдийг асран халамжлах талаарх таны туршлага болон хүүхдээ асран хамгаалахад нь гэр бүлүүдэд хэрхэн туслах тухайн таны санал бодлыг асууна. Ярилцлага нь ойролцоогоор [хугацаа бичих] минут үргэлжилнэ.

Таны өгсөн аливаа мэдээллийг нууцлах бөгөөд ярилцлагын явцад манай багийн ахлагч намайг ажлаа зөв хийж байгаа эсэхийг шалгах учраас тэр хүн л таны мэдээллийг мэдэх боломжтой. Энэхүү судалгааг хийж дууссаны дараа тайлан бичнэ. Энэхүү тайланд таны нэрийг эсвэл таныг оролцсон гэдгийг бичихгүй. Ярилцлагад орох эсэхээ, мөн бүх асуултад хариулах эсэхээ та өөрөө шийднэ. Хэрэв та оролцохгүйгээр шийдвэл энэ нь таны Хүүхдийг Ивээх Сантай тогтоосон харилцаа холбоонд огт нөлөөлөхгүй. Ярилцлагад оролцохоор шийдвэл хариулахыг хүсээгүй асуултаудаа алгасаж болохоос гадна ярилцлагын явцад судалгаанд оролцохоос татгалзаж болно. Энэхүү судалгаанд оролцсоноор ямар нэгэн сөрөг нөлөө танд учрахгүй гэдгийг судалгааны баг баталж байна. Судалгаанд оролцвол мөнгө эсвэл өөр ямар нэг урамшуулал танд өгөхгүй бөгөөд харин та судалгаанд оролцсоноор хүүхэд, гэр бүлд тохиолдож буй асуудлуудын талаар ойлгоход бидэнд буюу Хүүхдийг Ивээх Санд тусална.

Ярилцлагын явцад энэхүү судалгааны талаар лавлаж болно. Судалгааны талаар нэмэлт асуулт байвал судалгааны багтай [хаяг бичих] хаягаар холбогдоорой. Танд одоо асуулт байна уу?

### Ярилцлагыг үргэлжлүүлж болох уу?

Тийм 1  
Үгүй 2

### Зөвшөөрөл авч байгаа хүний мэдэгдэл:

Энэхүү судалгааны талаар оролцогчтой ярилцсан бөгөөд оролцогчийн бүх асуултад түүний мэдэх хэлээр хариулсан. Оролцогч миний тайлбарыг ойлгож, судалгаанд оролцох шийдвэрээ өөрөө гаргасан болно.

Оролцогчийн нэр

Огноо

Оролцогчийн гарын үсэг

Огноо

Зөвшөөрөл авсан хүний гарын үсэг

Огноо

Зөвшөөрөл авсан хүний нэр

Огноо



# Хавсралт Д: Ажлын төлөвлөгөөний жишээ

Үйл ажиллагаа	Долоо хоног																Тэмдэглэл
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	
<b>Бэлтгэл ажил (3-5 долоо хоног)</b>																	
Суурь мэдээллийг цуглуулж, судлах, хянах	●	●															
Урьдчилсан судалгаа хийх			●	●													
Асуулгын судалгааны ажлын даалгавар гаргах			●	●													
Зөвлөх авах, дотоодын мэргэжлийн зөвлөх авах				●													
Асуулгын менежментийн багийг бүрдүүлэх				●													
Зөвлөх хороо байгуулах, уулзалт хийх					●												
<b>Асуулгын судалгааны протокол боловсруулах (2-4 долоо хоног)</b>																	
Асуулгын судалгааны зорилгыг тодорхойлох, судалгааны асуулт гаргах					●												
Зорилтот хүн амыг тодорхойлох					●												
Түүврийн хүрээ, аргыг сонгох					●	●											
Асуултуудыг боловсруулах, өөрийн орны нөхцөлд тохируулан өөрчлөх						●	●										
Дүн шинжилгээний төлөвлөгөө гаргах						●	●										
Асуултуудыг орчуулах, давхар орчуулга хийх										●							
Асуултуудыг турших										●							
Мэдээлэл оруулах баазыг бүтээх										●	●						
Асуулгын судалгааны протоколийг баталгаажуулах уулзалт хийх													●				
Ёс зүйн зөвшөөрөл авах																●	
<p>Асуулгын судалгааны протоколыг ёс зүйн зөвшөөрөл авахаар хүргүүлсэн бол үүнд нэлээд хэдэн сарын хугацаа шаардагдаж магад.</p>																	
<b>Мэдээлэл цуглуулахад бэлтгэх (1-3 долоо хоног)</b>																	
Асуулгын судалгааны менежментийн хэрэгсэл бэлтгэх										●							
Байршил, холбоо тогтоох мэдээллийг тодруулах										●							
Мэдээлэл цуглуулах хуваарийг эцэслэх										●							
Хэрэг болох нөөцийг тогтоох, ажлын даалгавруудыг боловсруулах										●							
Хүний нөөцийг тодорхойлох, ажлын даалгавруудыг боловсруулах										●							
Мэдээлэл цуглуулагч, багийн ахлагч, мэдээлэл оруулах ажилтнуудыг олох, сургах												●					
Асуулгыг турших												●					
<b>Мэдээлэл цуглуулах (1-3 долоо хоног)</b>																	
Багуудыг хуваарилан байршуулах												●					
Орон нутгийн түвшний зөвшөөрөл авах												●	●				
Асуулгын судалгааны протоколын дагуу ярилцлага хийх													●	●			
Мэдээллийг оруулах																	
<b>Мэдээлэлд дүн шинжилгээ хийх (2-3 долоо хоног)</b>																	
Мэдээллийг программд оруулах, цэвэрлэх													●	●			
Урьдчилсан дүн шинжилгээ хийх														●	●		
Мэдээлэлд дүн шинжилгээ хийх уулзалт хийх															●		
Үр дүнг баталгаажуулах уулзалтуудыг түншлэгчдийг оролцуулан хийх															●	●	
Дүн шинжилгээ хийж дуусгах, тайлан бичих															●	●	
<b>Үр дүнг түгээх, хэрэглэх (үргэлжилсэн)</b>																	
Түгээх материалуудыг боловсруулах																	
Үр дүнг түгээх уулзалт, хурал, бусад форумыг зохион байгуулах																	
Хөтөлбөрийн төлөвлөлт, дизайн гаргах																	

## Хавсралт Е: Асуулгын жишээ

Асуулгыг хэрхэн боловсруулах, бүтэц, хэлбэрт хэрхэн оруулахыг харуулах зорилгоор энэхүү жишээг үзүүлж байна. Энэ нь тодорхой сэдвээр хийсэн бүрэн дүүрэн асуулга биш гэдгийг анхаарна уу. Хүүхдийг Ивээх Сангийн улс орны хөтөлбөрүүд, НҮБ-ын Хүүхдийн Сан болон хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг бусад байгууллагын хэрэглэж байсан асуулгыг шууд болон өөрчлөн авч энэхүү асуулгыг хийсэн болно. Асуулгад байж болох ялгаатай асуултуудын төрлүүдийг харуулах үүднээс эдгээр асуултуудыг сонгосон бөгөөд эдгээр асуултыг өөрийн орны нөхцөлд тохируулан, туршиж, хүчин төгөлдөр байдлыг нь шалгалгүйгээр хэрэглэж болохгүйг анхааруулья.

### ХЭСЭГ А. АСУУЛГЫН МЭДЭЭЛЭЛ

- A1. Асуулгын дугаар: \_\_\_|\_\_\_|\_\_\_
- A2. Ярилцлагыг хөтлөгчийн нэр:
- A3. Ярилцлагыг хөтлөгчийн код: \_\_\_|\_\_\_|\_\_\_
- A4. Багийн ахлагчийн нэр:
- A5. Багийн ахлагчийн код: \_\_\_|\_\_\_|\_\_\_
- A6. Мэдээллийг оруулагчийн нэр:
- A7. Мэдээллийг оруулсан огноо: (Өдөр/Сар/Он) \_\_\_\_/\_\_\_\_/\_\_\_\_

### ХЭСЭГ Б. ӨРХИЙН МЭДЭЭЛЭЛ

- B1. Кластерийн дугаар: \_\_\_|\_\_\_|\_\_\_
- B2. Өрхийн дугаар: \_\_\_|\_\_\_|\_\_\_
- B3. Ярилцлага хийсэн огноо: (Өдөр/Сар/Он) \_\_\_\_/\_\_\_\_/\_\_\_\_
- B4. Өрхөд буй асуулгыг бөглөх асран хамгаалагчийн тоо: \_\_\_\_
- B5. Эхэлсэн цаг: \_\_\_|\_\_\_ (цаг) \_\_\_|\_\_\_ (мин)
- B6. Дууссан цаг: \_\_\_|\_\_\_ (цаг) \_\_\_|\_\_\_ (мин)
  
- B7. Дүүрэг (Дүүргийн нэр, дугаарыг дугуйлна уу.)

1 Улаан	2 Улбар шар	3 Шар
4 Шаргал	5 Ягаан	6 Ногоон
7 Номин	8 Магента	
  
- B8. Асран хамгаалагчийн ярилцлагын үр дүн

1 Бүрэн дууссан	2 Тал нь дууссан	3 Асран хамгаалагч гэртээ байхгүй
4 Гэрийнхэн бүгдээрээ эзгүй	5 Татгалзсан	6 Бусад (бичнэ)

### ХЭСЭГ В. ХАРИУЛАГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ

Мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрлийг хариулагчид уншиж өгнө. Хариулагч зөвшөөрч, маягтад гарын үсэг зурахаас нааш ярилцлагыг эхлүүлж болохгүй.

- B1. Мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрөл дээр гарын үсэг зурах эсэх
  - 1 Тийм (Хэсэг Г рүү явах)
  - 2 Үгүй (Ярилцлагыг зогсоох)

Мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрөлд доорх мэдээлэл дурдагдаагүй бол уншиж өгнө:

**“Таны амьдардаг орчин тойронд хүүхдийг хэрхэн асран хамгаалах талаар тантай ярилцахыг хүсэж байна. Энэхүү ярилцлага нь ойролцоогоор (х) минут үргэлжилнэ. Таны өгсөн мэдээллийг нууцлах бөгөөд төслийн багийнхнаас өөр хэн ч таны өгсөн мэдээлэлтэй танилцахгүй.”**

## ХЭСЭГ Г. ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ӨРХИЙН МЭДЭЭЛЭЛ

Асуултаа эхлэхээс өмнө Б5-д ярилцлага эхэлсэн цагийг нөхөж бичнэ.

**“Эхлээд таны болон тантай хамт амьдардаг хүмүүсийн тухай мэдэхийг хүсэж байна.”**

- |   |   |  |
|---|---|--|
| Г1. Хариулагчийн хүйс<br>(асуулгүйгээр харж тэмдэглэнэ)   | 1 Эрэгтэй   | 2 Эмэгтэй  |
| Г2. Төрсөн он, сар?   | ___/___<br>(сар)  | ___/___<br>(он)  |
| Г3. Хэдэн настай вэ?<br>(төрсөн онтой нь насыг харьцуулах)  | ___ ___ настай  |  |
| Г4. Сургуульд сурсан уу?  | 1 Тийм  | 2 Үгүй   |
| Г5. Боловсролын дээд түвшин?  | 1 Сургуулийн өмнөх<br>2 Бага боловсролд хамрагдаж байсан (х-х анги)<br>3 Бага боловсрол эзэмшсэн (х анги)<br>4 Бүрэн дунд боловсролд хамрагдаж байсан (х-х анги)<br>5 Бүрэн дунд боловсрол эзэмшсэн (х анги)<br>6 Дээд боловсрол эзэмшсэн |  |
| Г6. Та гэрлэсэн үү эсвэл хамтран амьдрагчтайгаа амьдарч байна уу?   | 1 Гэрлэсэн  | 1, 2 → эрэгтэй оролцогч бол Г8 руу очих<br>2 Хамтран амьдрагчтайгаа<br>3 Гэрлээгүй |
| Г7. Таны хамтрагчид танаас өөр эхнэр эсвэл хамтрагч бий эсэх эсвэл тэр өөр эмэгтэйтэй гэрлэсэн мэт хамт амьдардаг уу? | 1 Тийм  | 2 Үгүй   |
| Г8. Таны гэрлэлтийн байдал одоо ямар статустай байна вэ?  | 1 Салсан/Тус тусдаа амьдардаг<br>2 Бэлэвсэрсэн  |  |
| Г9. Таны угсаа?   | 1 Угсаа А<br>2 Угсаа Б<br>3 Угсаа В<br>4 Угсаа бусад (бичих) _____  |  |
| Г10. Ямар шашин шүтдэг вэ?  | 1 Муслим  | 2 Христ<br>3 Уламжлалт   |
|   | 5 Бусад (бичих) _____   | 4 Шашингүй   |



## ХЭСЭГ Г. ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ӨРХИЙН МЭДЭЭЛЭЛ

- Г11. Танай өрхийн орлогын эх үүсвэр юу вэ?
- 1 Ферм
  - 2 Сарын цалин
  - 3 Бизнес, худалдааны ажил (ферм, загасчлалтай холбоогүй)
  - 4 Мөнгө шилжүүлэг, гуйвуулга
  - 5 Бусад (бичих) \_\_\_\_\_

### “Одоо тантай хамт амьдардаг хүмүүс, хүүхдүүдийн тухай хэдэн асуулт асууя.”

- Г12. Та өрхийн тэргүүлэгч мөн үү?
- 1 Тийм
  - 2 Үгүй
- 1 → Г15 рүү очих
- Г13. Өрхийн тэргүүлэгчтэй та ямар хамааралтай вэ?
- 1 Хамтрагч (нөхөр/эхнэр эсвэл найз бүсгүй/найз залуу)
  - 2 Хүү/охин
  - 3 Эцэг/эх
  - 4 Бусад (бичих) \_\_\_\_\_
- Г14. Өрхийн тэргүүлэгч нь хэн бэ? Эрэгтэй юу, эмэгтэй юу?
- 1 Эрэгтэй
  - 2 Эмэгтэй
  - 3 Хүүхэд тэргүүлсэн өрх
- Г15. Энэ өрхөд хэдэн хүн нэг тогооноос хоол идэж байна вэ? “Хүүхэд” гэж хэлбэл 18-аас доош насны хүнийг хэлж байна гэж ойлгоорой. (Жагсаалтыг уншиж өгөөд, хувилбар тус бүрийн ард хүний тоог нь бичих)
- (а) Энэ өрхөд төрсөн хүүхдүүд \_\_\_\_
  - (б) Энэ өрхөөс гадуур төрсөн, гэхдээ одоо энэ өрхөд буй хүүхдүүд \_\_\_\_
  - (в) Бусад хүүхэд \_\_\_\_
  - (г) Насанд хүрэгчид \_\_\_\_
- Г16. Тантай хамт амьдарч байгаад одоо өөр газар амьдарч буй хүүхэд бий юу?
- 1 Тийм
  - 2 Үгүй
- 2 → Дараагийн хэсэг рүү очих
- Тэд одоо хаана байна вэ? (Чанга уншиж болохгүй, холбогдох хариултыг дугуйлна. Хувилбар бүрд хүүхдийн тоог бичих)
- (а) Төрсөн эцэг/эхтэйгээ амьдарч байгаа
  - (б) Хамаатантайгаа амьдарч байгаа
  - (в) Хамаатны биш хүнтэй амьдарч байгаа
  - (г) Хүүхдийн асрах газарт амьдарч байгаа
  - (д) Хамтран амьдрагчтай амьдарч байгаа
  - (е) Сургууль дээрээ амьдарч байгаа
  - (ё) Мэдэхгүй
  - (ж) Бусад (бичих)
- Тэдний тантай хамт амьдрахгүй байгаагийн шалтгаан юу вэ? (Чанга уншиж болохгүй, өмнө дурдсан хүүхэд тус бүрээр холбогдох хариултыг дугуйлах)
- 1 Сургуульд суралцуулахаар үлдээсэн
  - 2 Гэр бүл, найз нараа дэмжихээр явсан
  - 3 Гэртээ тэжээж чадахгүй
  - 4 Тусгай хэрэгцээг нь хангаж чадахгүй (хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт)
  - 5 Хамтран амьдрагчтайгаа амьдруулах гэж үлдээсэн
  - 6 Ажиллахаар явсан
  - 7 Гэрээсээ зугатсан
  - 8 Мэдэхгүй
  - 9 Бусад (бичих) \_\_\_\_\_

## ХЭСЭГ Д. МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДАЛ<sup>1</sup>

	Үнэн	Худал	Мэдэхгүй	Хамааралгүй		
Д1. Дараах бодомжууд таны хувьд үнэн эсвэл худал эсэхийг хэлнэ үү.						
(а) Эцэг эх нь хүүхдээ асран хамгаалж чадахгүй бол хуулийн дагуу тэр хүүхдийг өнчин хүүхдийг асрах газарт байлгах хэрэгтэй.	1	2	88	99		
(б) Өнчин хүүхдийг асрах газарт амьдарч байгаа ихэнх хүүхдийн аав ээж нь нас барсан.	1	2	88	99		
(в) Хүүхдийг өнчин хүүхдийн асрах газарт өгсөн л бол тухайн хүүхдийн эцэг эхийн хүүхдийн өмнө хүлээсэн эрх, үүрэг байхгүй болно.	1	2	88	99		
(г) Манай улсын өнчин хүүхдийг асрах газрууд бүгдээрээ төрөөс эрхээ авсан.	1	2	88	99		
	Санал бүрэн нийлнэ	Санал нийлнэ	Санал нийлэхгүй	Санал огт нийлэхгүй	Мэдэхгүй	Хамааралгүй
Д2. Дараах бодомжуудтай санал нийлж байгаа эсвэл нийлэхгүй байгаа эсэхээ, мөн хэр хүчтэй мэдэрч байгаагаа бидэнд хэлнэ үү. (Бодомжуудыг чанга уншиж өгөөд, зөвшөөрөх эсвэл зөвшөөрөхгүй байгааг нь тэмдэглэнэ. Дараа нь хэр хүчтэй гэдгийг нь асууж тэмдэглэнэ)						
(а) Эцэг эхтэйгээ хамт амьдардаггүй хүүхдүүд гэртээ байснаас өнчин хүүхдийн асрах газарт байвал илүү сайн асран хамгаалал хүртэнэ.	1	2	3	4	88	99
(б) Эцэг эхтэйгээ хамт амьдардаггүй хүүхдүүд өөрсдийн шинэ асран хамгаалагчийн шашин шүтлэг, соёлыг дагах ёстой.	1	2	3	4	88	99
(в) Эцэг эхтэйгээ хамт амьдардаггүй хүүхдүүдээс хаана амьдрах хүсэлтэй байгааг нь асуух ёстой.	1	2	3	4	88	99
Д3. Хүүхдийг зөв өсгөн хүмүүжүүлэх, сургахын тулд түүнийг зодох ёстой гэдэгт та итгэдэг үү?	1 Тийм	2 Үгүй				

<sup>1</sup> Эдгээр нь МХД-ын асуулгын судалгааны асуулт, бүтэц, кодыг харуулах үүднээс хүүхэд хамгааллын өөр асуудлаар боловсруулсан асуултууд юм. Логик дэс дараалал, асуулгын ойлгомжтой байдал, төлөвлөсөн дүн шинжилгээний дагуу асуултуудыг хүүхэд хамгааллын тодорхой сэдвүүдээр эсвэл мэдлэг, хандлага, дадалд хамаарах асуултуудыг тус тусад нь тавихыг зөвлөж байна. Шинэ сэдэв эсвэл хэсэг гарах бүрт удиртгал текст хийнэ. Өмнө дурдсанаар эдгээр асуулт болон бусад судалгааны асуултыг хэрэглэхийг хүсвэл заавал тухайн орон нутгийн онцлогт тохируулан өөрчилж, турших хэрэгтэй.

## ХЭСЭГ Д. МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДАЛ

<p>Д4. Эцэг эхдээ зодуулсан эсвэл гэрээсээ зугатсан хүүхдүүд очих боломжтой газар энэ хавьд бий юу?</p>	<p>1 Тийм 2 Үгүй</p>	<p>1 → Д5 руу очих 2 → Д6 руу очих</p>
<p>Д5. Тийм бол хаана? (Чанга уншиж болохгүй, өгсөн хариултуудыг дугуйлах)</p>	<p>1 Орон нутгийн аль нэг өрхийн гэрт 2 Орон нутгийн удирдлагын гэрт 3 Нийгмийн ажилтан 4 Сүм хийд 5 Төрийн байгууллага 6 Төрийн бус байгууллага 7 Өнчин хүүхдийн асрах газар 8 Бусад (бичих) _____ 88 Мэдэхгүй</p>	
<p>Д6. Хүүхэд хүчирхийлэлд өртөж буйг мэдвэл та юу хийх вэ?</p>	<p>1 Мэдээлнэ 2 Хүчирхийлэгчтэй тулна 3 Хүүхдийг салгаж авна 4 Чимээгүй өнгөрнө/Юу ч хийхгүй 5 Бусад (бичих) _____ 88 Мэдэхгүй</p>	<p>1 → Д7 руу очих → Д8 руу очих</p>
<p>Д7. Хүүхдийн хүчирхийллийн мэдээллийг хэнд өгөх вэ? (Гурав хүртэлх хариултыг өгч болно гэдгийг оролцогчид хэлэх)</p>	<p>1 Хүүхдийн гэр бүлийн гишүүнд 2 Орон нутгийн удирдлага 3 Хүүхэд хамгааллын зөвлөл 4 Шашны удирдлага 5 Сургууль 6 Нийгмийн болон эрүүл мэндийн ажилтан 7 Төрийн байгууллага 8 Төрийн бус байгууллага 9 Цагдаа 10 Бусад (бичих) _____ 88 Мэдэхгүй</p>	
<p>Д8. Хүчирхийллийг мэдээлэхгүй гэсний шалтгаан юу вэ? (Чанга уншиж болохгүй, өгсөн хариултуудыг дугуйлах)</p>	<p>1 Хаана, хэнд мэдээлэхээ мэдэхгүй 2 Мэдээлсэн ч арга хэмжээ авахгүй байх 3 Миний оролцох хэрэг биш 4 Иймэрхүү зүйл болж л байдаг ш дээ 5 Өс санахаас айх 6 Хүчирхийлэгчтэй эхлээд ярих хэрэгтэй 7 Бусад (бичих) _____</p>	



## ХЭСЭГ Д. МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДАЛ

Цаг заваа гарган ярилцсанд талархлаа илэрхийлж, оролцогчийн мэдээллийг нууцална гэдгээ дахин хэлнэ.

**\*Ярилцлага дууссан цагийг асуулгын эхэнд буй холбогдох хэсэгт бичнэ. Асуулгыг гүйлгэн харж, дутуу зүйл үлдсэн эсэхийг шалгана. Хэрэв ямар нэгэн асуултын хариулт үнэн зөв биш юм шиг санагдвал тухайн асуултын дугаар болон яагаад ингэж бодож буйгаа доорх хэсэгт бичээрэй.**

Ярилцлагыг хөтлөгчийн тэмдэглэл

Багийн ахлагчийн тэмдэглэл

**\*Багийн ахлагч нь ярилцлагыг хөтлөгчтэй хамт суун, асуулгыг шалгах бгөөд дутуу зүйл буй эсэхийг хянана. Асуулгыг бүрэн бөглөсөн бол огноо тавьж, гарын үсэг зурна.**

Ярилцлага хөтлөгчийн гарын үсэг, огноо

Багийн ахлагчийн гарын үсэг, огноо

\_\_\_\_/\_\_\_\_/\_\_\_\_

\_\_\_\_/\_\_\_\_/\_\_\_\_

# Хавсралт Ё: Мэдээлэл цуглуулах багийн ахлагчийн ажлын даалгавар

## Ажлын даалгавар

### Мэдээлэл цуглуулах багийн ахлагч

#### Мэдлэг, хандлага, дадал (МХД)-ын асуулгын судалгаа

[Төсөл, хөтөлбөрийн нэр, улс орны төлөөлөгчийн газрын мэдээллийг оруулах]

**Ажлын хугацаа:** [Өдрөөр эсвэл долоо хоногоор оруулах]

**Ажлыг эхлэх хугацаа:**

**Ажлыг дуусгах хугацаа:**

#### 9. Үндсэн мэдээлэл

[Асуулгын судалгааны ажлын даалгавраас үндсэн мэдээллийг хуулан оруулах]

#### 10. МХД-ын асуулгын судалгааны зорилго

[Асуулгын судалгааны ажлын даалгавраас зорилгыг хуулан оруулах]

#### 11. Арга зүй

#### 12. Үүрэг хариуцлага

[Асуулгын судалгааны багийн бүрэлдэхүүн, өмнө дурдсан асуулгын судалгааны арга зүйн дагуу хийх ажлуудыг дурдан бичих.] Багийн ахлагч нь мэдээлэл цуглуулах явцын туршид асуулгын мэдээлэл цуглуулах багийн өдөр тутмын ажлыг шууд хариуцан, чиглүүлнэ. Асуулгын судалгааны менежер болон багийн гишүүдийн дэмжлэгтэйгээр мэдээлэл цуглуулах багийн ахлагч нь дараах үүргийг хүлээнэ:

- Хөтөлбөрийн ажилтнуудтай хамт асуулгын судалгааны зорилго, зорилт болон мэдээлэл цуглуулах хуваарийг мэдээлэл цуглуулах баг тухайн газарт ирэхээс өмнө орон нутгийн удирдах ажилтнуудад танилцуулах
- Асуулгын судалгааны багийн гишүүдэд зориулсан сургалтын бэлтгэл ажилд туслах (ложистик, материалын худалдан авалт, хоол унд гэх мэт)
- Багийн гишүүдэд зориулсан сургалтад бүрэн хамрагдах
- Асуулгыг боловсруулах, туршихад туслах, турших явцад асуулгын судалгааны багийг удирдах, туршилтаас ажигласан, сурсан зүйлээ хуваалцах
- Мэдээлэл цуглуулах багийг удирдаж, өдөр тутмын ажлыг чиглүүлэх, асуулгын судалгааны протоколын дагуу мэдээллийг цуглуулж байгаа эсэх, ёс зүйн стандартыг баримталж байгаа эсэхийг хянах
- Мэдээлэл цуглуулах явцад ярилцлага хөтлөгчдөд буюу мэдээлэл цуглуулагчдад тусламж дэмжлэг үзүүлэх
- Хувилсан асуулгууд хангалттай байгаа эсэх, мэдээлэл цуглуулагчид цагтаа тайлангаа тавьж буй эсэх, зохион байгуулалт, ложистиктой холбоотой зүйл бэлэн байгаа эсэх, асуулгын судалгааны хуваарийн дагуу ажиллаж байгаа эсэхийг хянах
- Асуулга тус бүрийг нарийн шалгах, өдөр тутмын явцын тайланг хэлэлцэх, мэдээлэл цуглуулах явцад гарч буй асуудлыг шийдэх, асуудлыг бүртгэж баримтжуулах, мэдээлэл цуглуулахтай холбоотой гарч болох асуудлуудыг тэмдэглэх гэх мэтээр өдөр тутам цуглуулж байгаа мэдээллийн чанарыг баталгаажуулах
- Бөглөсөн асуулгуудыг программд оруулах хэсэг рүү тээвэрлүүлэх асуудлыг зохицуулах
- Асуулгад багтаагүй боловч судалгааны үр дүнг тайлбарлахад чухлаар нөлөөлж магадгүй мэдээллийг тэмдэглэж авах, бүртгэх, хуваалцах
- Асуулгын судалгааны явцад мэдээлэл цуглуулагчид ёс зүйн стандарт болон хүүхэд хамгааллын бодлогыг ягштал мөрдөж буй эсэхийг хянах
- Мэдээллийг программд оруулах явцад судалгааны менежерийн даалгасан ажлыг хийх, мэдээллийг цэвэрлэх, дүн шинжилгээ хийх, баталгаажуулах уулзалтуудыг зохион байгуулах

### 13. Нөхцөл

### 14. Ахлагчид тавих шаардлага

[Ахлагчид байх ёстой мэргэжлийн чадамжуудыг тодруулан бичих, ингэхдээ дараах зөвлөмжөөс санаа авах]

#### Мэргэжлийн чадамж

- МХД-ын асуулгын судалгаа эсвэл өөр бусад түүвэрлэлт бүхий тоон судалгаанд оролцож байсан туршлагатай
- Ярилцлага хөтөлж байсан туршлагатай
- Баг удирдах туршлагатай
- Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, чадвартай
- Асуудал шийдвэрлэх, ачаалал даах чадвартай
- Нягт нямбай
- Харилцааны маш сайн чадвартай
- Орон нутгийн хэлээс гадна гадаад хэлний мэдлэгтэй байх

#### Мэргэшил

- Дээд боловсролтой байх



# Хавсралт Ж: Мэдээлэл цуглуулагчийн ажлын даалгавар

## Ажлын даалгавар

### Мэдээлэл цуглуулагч

#### Мэдлэг, хандлага, дадал (МХД)-ын асуулгын судалгаа

[Төсөл, хөтөлбөрийн нэр, улс орны төлөөлөгчийн газрын мэдээллийг оруулах]

**Ажлын хугацаа:** [Өдрөөр эсвэл долоо хоногоор оруулах]

**Ажлыг эхлэх хугацаа:**

**Ажлыг дуусгах хугацаа:**

#### 15. Үндсэн мэдээлэл

[Асуулгын судалгааны ажлын даалгавраас үндсэн мэдээллийг хуулан оруулах]

#### 16. МХД-ын асуулгын судалгааны зорилго

[Асуулгын судалгааны ажлын даалгавраас зорилгыг хуулан оруулах]

#### 17. Арга зүй

[Асуулгын судалгааны ажлын даалгавраас арга зүйг хуулан оруулах]

#### 18. Үүрэг хариуцлага

[Асуулгын судалгааны багийн бүрэлдэхүүн, өмнө дурдсан асуулгын судалгааны арга зүйн дагуу хийх ажлуудыг дурдан бичих.] Мэдээлэл цуглуулагч нь МХД-ын асуулгын судалгааны багийн нэг гишүүн юм. Асуулгын судалгааны протоколд дурдсан арга зүй, мэдээллийн чанар, ёс зүйн стандартын дагуу сонгосон газар, зорилтот хүн амын бүлгээс урьдчилан боловсруулсан асуулгын дагуу мэдээлэл цуглуулах үүргийг мэдээлэл цуглуулагч хүлээнэ. Зарим үүргийг дор үзүүлэв:

- МХД-ын асуулгын судалгааны багийн гишүүдэд зориулсан сургалтад хамрагдах
- Асуулгын судалгааны протоколд буй арга зүй, чанарын хяналт, ёс зүйн стандартыг ягштал мөрдөх
- Турших, хянах замаар асуулгыг эцэслэх ажилд дэмжлэг үзүүлэх
- Асуулгыг ашиглан түүврийн хүрээний дагуу мэдээлэл цуглуулах
- Асуулгыг бүрэн дүүрэн бөглөх, ярилцлагын явцад цуглуулсан нэмэлт үр дүнгүүдийг тэмдэглэх, бүртгэх
- Асуулгын судалгааны протоколд заасны дагуу бөглөсөн асуулгуудтай харьцах, бөглөсөн асуулгуудыг багийн ахлагчид заасан хугацаанд хүлээлгэн өгөх
- Өдөр бүр ажлын эхлэл, төгсгөлийг багийн ахлагчид мэдээлэх
- Мэдээллийг цэвэрлэх, баталгаажуулах ажилд оролцох, багийн ахлагчийн хүсэлтийн дагуу судалгааны үр дүнг баталгаажуулах уулзалтуудад оролцох

## 19. Нөхцөл

## 20. Мэдээлэл цуглуулагчид тавих шаардлага

[Мэдээлэл цуглуулагчид байх ёстой мэргэжлийн чадамжуудыг тодруулан бичих, ингэхдээ дараах зөвлөмжөөс санаа авах]

### Мэргэжлийн чадамж

- Иргэд, олон нийт, нэн ялангуяа хүүхэдтэй ажиллаж байсан туршлагатай
- Орон нутгийнхны харилцдаг хэлийг аман болон ярианы түвшинд маш сайн эзэмшсэн
- Ярилцлага хийх чадвартай, өрхийн судалгааны ажилд оролцож байсан туршлагатай
- Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар зохих мэдлэгтэй
- Харилцааны үр чадвар сайтай
- Зохион байгуулах чадвартай
- Мэдээлэл цуглуулах чадвар ма сайн эзэмшсэн
- Багаар ажиллах чадвартай
- Хүүхэд хамгааллын бодлогыг даган мөрдөх

### Мэргэшил

- Бүрэн дунд боловсрол эзэмшсэн байх

# Хавсралт 3: Асуулгын судалгааны багийн гишүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр

## МХД-ын асуулгын судалгааны багийн гишүүдэд зориулсан сургалт

Хөтөлбөр (хуваарийг цаг, минутаар харуулсан, шаардлагатай бол завсарлага оруулж болно)

Оролцогч: Асуулгын судалгааны менежер, багийн ахлагчид, мэдээлэл цуглуулагчид

ЦАГ	СЭДЭВ	СУРГАГЧ БАГШ	ТЭМДЭГЛЭЛ, АРГА
<b>ӨДӨР 1</b>			
15 мин	Бүртгэл		
30 мин	Сургалтын нээлт, танилцуулга		
15 мин	Сургалтын зорилго, баримтлах зарчим		
20 мин	Хүүхэд хамгааллын тухай ерөнхий асуудлууд, тухайн орон нутаг дахь хүүхэд хамгааллын асуудлууд		
20 мин	Хүүхдийг Ивээх Сангийн төлөөлөгчийн газрын танилцуулга Хэрэгжүүлдэг хөтөлбөрүүд болон МХД-ын судалгаа хийх болсон хөтөлбөр, төслийн нөхцөл байдал		Хөтөлбөрийн ажилтнуудыг эхний өдрийн сургалтад суухыг урих, ингэснээр тэд асуулгын судалгааны талаар мэдлэгтэй болж, судалгааг дэмжих чадвартай болно.
1 цаг	МХД-ын асуулгын судалгааны танилцуулга <ul style="list-style-type: none"> <li>МХД-ын асуулгын судалгаа гэж юу вэ?</li> <li>нэ удаагийн МХД-ын асуулгын судалгаагаар ямар ямар гол асуудлуудыг судлах вэ?</li> <li>Асуулгын судалгааны гол үе шатууд, гол үр дүн</li> <li>Асуулгын судалгааны баг: Багийн бүрэлдэхүүн, үүрэг хариуцлага</li> </ul>		
3 цаг	Асуулгын судалгааны арга зүй: Протокол <ul style="list-style-type: none"> <li>Асуулгын судалгааны хүрээ, зорилтот хүн ам</li> <li>Түүвэрлэлтийн стратеги</li> </ul>		
1 цаг	Судалгааны ёс зүйн асуудал <ul style="list-style-type: none"> <li>Зарчим</li> <li>Практик: Мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрөл, нууц хадгалах</li> <li>Хүүхэд, залуустай ярилцахад анхаарах зүйл</li> </ul>		
<b>ӨДӨР 2</b>			
30 мин	Өдөр 1-ийн сургалтын агуулгыг сэргээн санах, дүгнэх		
2 цаг	Асуулгын судалгааны арга зүй: Арга хэрэгсэл буюу асуулгыг танилцуулах <ul style="list-style-type: none"> <li>Асуулга (асуултууд, тэдгээрийг боловсруулсан, баталгаажуулсан, бүтцэд оруулсан явц)</li> <li>Асуулгыг асуулт тус бүрээр, зааврын хамт танилцуулах</li> <li>Мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрөл</li> </ul>		Дүрийн тоглолт Дүрийн тоглолт
2 цаг	Ярилцах техникүүд		
3 цаг	Дадлага ажил <ul style="list-style-type: none"> <li>Асуулгын дагуу ярилцлагыг явуулах дадлага</li> <li>Асуулгыг хянах, санал бодлоо хэлэх</li> </ul>		



ЦАГ	СЭДЭВ	СУРГАГЧ БАГШ	ТЭМДЭГЛЭЛ, АРГА
ӨДӨР 3			
30 мин	Өдөр 2-ын сургалтын агуулгыг сэргээн санах, дүгнэх		
2 цаг	Асуулгын судалгааны арга зүй: Мэдээлэл цуглуулах <ul style="list-style-type: none"> <li>• Мэдээлэл цуглуулахаар сонгосон газарт очих</li> <li>• Хариулагчийг сонгох</li> <li>• Мэдээлэл цуглуулах (ярилцлага хийх)</li> <li>• Өдрийн ажлаа дүгнэн танилцуулах</li> </ul>		
1 цаг	Хүүхэд хамгаалах бодлого <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийг Ивээх Сангийн хүүхэд хамгааллын бодлого</li> <li>• Бодлогыг мөрдөх явц</li> </ul>		Дадлага
1 цаг	Мэдээллийн чанар <ul style="list-style-type: none"> <li>• Чанарын баталгаажуулалт, мэдээллийн чанарыг чухалчлахын ач холбогдол</li> <li>• Мэдээлэл цуглуулах явцад гардаг мэдээллийн чанарт нөлөөлөхүйц эрсдэлүүд</li> <li>• Мэдээллийн чанарыг баталгаажуулах үйл явц, санал зөвлөмж</li> </ul>		
2 цаг	Төлөвлөлт, ложистик <ul style="list-style-type: none"> <li>• Байршил, багийн үүрэг даалгавар</li> <li>• Шалгах асуултууд</li> </ul>		Энэ хэсэгт ложистикийн ажилтнууд, жолооч нарыг оролцуулах
1 цаг	Дүгнэлт, хаалт		



# Хавсралт Й: МХД-ын асуулгын судалгааны тайлангийн агуулга

## МХД-ын асуулгын судалгааны тайлангийн агуулга

**Гарчиг** – Төсөл, хөтөлбөр, асуулгын судалгааны нэр, байршил, асуулгын судалгааг сайтар тодорхойлсон нэг мөрт багтах нэр

**Агуулга, Товчилсон үгийн жагсаалт, Талархал  
Хураангуй  
Удиртгал**

1. **Танилцуулга**
2. **Үндэсний болон бүсийн хам орчин:** Хөгжлийн эсвэл хүмүүнлэгийн үйл ажиллагаа, хүүхэд хамгааллын асуудал, үүнд хууль эрх зүйн орчин, бодлогыг дүрслэн бичих
3. **Хөтөлбөр эсвэл төслийн хам орчин:** Хүүхдийг Ивээх Сангийн төлөөлөгчийн газар, үйл ажиллагаа, гол зорилго, зориотот хүн амын бүлэг, МХД-ын асуулгын судалгааг хийж буй хөтөлбөрийн талаар дурдах

### Үндэслэл

Асуулгын судалгааг хийх болсон үндэслэлийг тайлбарлах, зорилго, судалгааны асуултуудыг бичих

### Арга зүй

Асуулгын судалгааны протоколд тусгасан дараах зүйлийг энэ хэсэгт бичнэ:

1. Зорилтот хүн ам, байршил: Асуулгын судалгаанд хамрагдсан хүн ам, хүн амын дэд бүлэг, тэднийг сонгосон шалтгааныг бичих, түүврийн шалгуур үзүүлэлтийг тайлбарлах
2. Түүврийн дизайн: Түүврийн хэмжээ болон хариулагчийг сонгосон аргачлал
3. Мэдээлэл цуглуулалт: Арга хэрэгслүүд, тэднийг сонгосон үндэслэл, мэдээллийг цуглуулсан явцын талаар дүрслэх, түүнчлэн хүүхэд хамгааллын бодлого, ёс зүй, чанарын баталгаажуулалтын асуудлуудыг дурдах
4. Мэдээллийн менежмент, дүн шинжилгээ: Судалгааны явцад мэдээллийг хэрхэн хадгалсан, мэдээлэлд ямархуу байдлаар менежмент хийсэн, мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн хүрээг танилцуулах
5. Хязгаарлал: Асуулгыг судалгаа, дүн шинжилгээ, үр дүнг тайлбарлахад явцад гарсан хүндрэл бэрхшээлийг дурдах (асуулгын судалгааны дизайн болон мэдээлэл цуглуулах нөхцөлтэй холбоотойгоор мэдээллийн чанар нөлөөлөхүйц алдаа гарсан эсэхийг мөн дурдах)

Тэмдэглэл: Урьдчилсан судалгаа явуулсан бол асуулгын судалгааны эцсийн дизайн гаргахад нөлөөлсөн гэдэг үүднээс энэ талаар арга зүй хэсэгт дурдах



## **Үр дүн**

Асуулгын судалгааны гол үр дүнгүүдийг хүснэгт, схем, текстээр дамжуулан танилцуулах:

1. Нийгэм-хүн ам зүйн үр дүн: Асуулгын судалгаанд хамрагдсан хүн амын бүлгийн нийгэм-хүн ам зүйн мэдээллийг танилцуулах
2. МХД-ын үр дүн: Мэдлэг, хандлага, дадалтай холбоотой гол хувьсагчуудад хийсэн дүрсэлсэн дүн шинжилгээ (боломжтой бол хүн амын дэд бүлэг тус бүрээр нарийвчлах)
3. Нэмэлт үр дүн: МХД-ыг харьцуулсан үзүүлэлтээр гаргаж, судалгааны асуултуудын дагуу хийсэн нарийн дүн шинжилгээг танилцуулах, асуулгын судалгааны болон урьдчилсан судалгааны явцад илэрсэн огт хөндөгдөөгүй асуудлуудыг дурдах

## **Дүгнэлт**

Түншлэгчид болон асуулгын судалгаанд оролцсон зорилтот бүлгийн хүн амтай хамтран хийсэн дүн шинжилгээ, баталгаажуулалтаар гарсан асуулгын судалгааны үр дүнг тайлбарлан бичих

## **Санал зөвлөмж**

Хүүхдийг Ивээх Сан, хүүхэд хамгааллын асуудал хариуцсан олон нийтийн зөвлөл, түншлэгчид, хүүхэд хамгаалах үүрэгтэй хүмүүст зориулсан санал зөвлөмжийг үүнд тусгах, мөн цаашид хийх судалгааны чиглэлээр зөвлөмж гаргах

## **Ном зүй**

## **Хавсралтууд**

Асуулгын судалгааны ажлын даалгавар, мэдээлэл өгсний үндсэн дээр авах зөвшөөрлийн маягт, мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл буюу асуулгыг хавсаргах

**Бангурах, Р. (2012, 10-р сарын 31).** Хүүхдийг Ивээх Сан Либери.  
(А. Холман, Ярилцлагыг хөтлөгч)

**Бензансон, С. (2012, 10-р сарын 19).** Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн менежер,  
Сиарра Лион. (А. Холман, Ярилцлагыг хөтлөгч)

**Боргерс, Н., де Лееув, Е. Д., & Хокс, Ж. (2000).** Хүүхэд асуулгын судалгааны оролцогч болох нь: Танин мэдэхүйн хөгжил ба хариултын чанар. Методологие Социологикиа бюлетин, 60-75. <http://joophox.net/publist/bms66.pdf>

**Каппа, С. (2012, 10-р сарын 23).** Статистик, хяналт-шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, ЮНИСЕФ. (А. Холман, Ярилцлагыг хөтлөгч)

**Халдварт өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн төв. (2009, 7-р сар).** Үнэлгээний товч: Үнэлгээ хийх зорилгоор цуглуулсан тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх нь. 2012 оны 10-р сарын 28-нд <http://www.cdc.gov/healthyouth/evaluation/pdf/brief20.pdf>-аас татан авсан.

**Колумбын их сургууль. (огноогүй).** Хувийн нууц болон мэдээллийн нууц: КАЙРЕ Судалгааны ёс зүйн асуудлууд. 2012 оны 11-р 05-нд татан авсан: [http://ccnmtl.columbia.edu/projects/cire/pac/foundation/#1\\_2](http://ccnmtl.columbia.edu/projects/cire/pac/foundation/#1_2)

**де Лееув, Е. Д. (2011).** Хүүхэд, өсвөр насныхныг асуулгын судалгаанд хамруулах үед тэдний өгсөн мэдээлийн чанарыг сайжруулах нь: Танин мэдэхүйн болон нийгмийн хөгжил ба асуулгыг боловсруулах, туршихад түүний үүрэг.

**Еспеут, Д. (2001, 8-р сар).** Мэдлэг, дадал, тархалтын асуулгын судалгаа 2000+ Мэдээлэл цуглуулах удирдамж 2001. Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийг дэмжих төслөөс 2012 оны 11-р сарын 2-нд татаж авсан. Холбоос: [http://www.enonline.net/pool/files/ife/annex-4-kpc-surveyfield-guide-\(care\)\(1\).pdf](http://www.enonline.net/pool/files/ife/annex-4-kpc-surveyfield-guide-(care)(1).pdf)

**Лауниала, А. (2009).** Хүмүүсийн мэдлэг, хандлага, дадлын талаар МХД-ын асуулгын судалгаа хэр ихийг хэлж чадах вэ? Малавийн хумхаа өвчтэй жирэмсэн Малави эмэгтэйчүүдийн дунд хийсэн эрүүл мэндийн антропологийн судалгаанаас хийсэн зарим ажиглалт. Антропологи, 11-р цуврал, 1 дэх дугаар

**Медесинс ду Монде. (2011, 1-р сар).** МХД-ын асуулгын судалгааны загвар (Мэдлэг, хандлага, дадал). 2012 оны 11-р сарын 04-нд татаж авсан. Холбоос: <http://www.medecinsdumonde.org/Publications/Guides-a-l-usagedes-professionnels-de-l-humanitaire/Guide-Collecte-de-donneesMethodologies-qualitatives>

**Морров, В., & Ричардс, М. (1996).** Хүүхэд, залуусыг оролцуулан хийх нийгмийн судалгааны ёс зүйн асуудал: Дүгнэлт. Хүүхэд ба нийгэм, дугаар 10, 90-105.

**Оят, Г. (2012, 10-р сарын 26).** Хүүхдийг Ивээх Сан Либери.  
(А. Холман, Ярилцлагыг хөтлөгч)

**Руйз-Касарес, М. (2011).** Баруун болон төв Либери хүмүүсийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадал: Судалгааны эцсийн тайлан. Хүүхдийг Ивээх Сан Либери.

**Руйз-Касарес, М. (2012, 10-р сарын 19).** Либерт хийсэн МХД-ын асуулгын судалгааны бие даасан зөвлөх. (А. Холман, Ярилцлагыг хөтлөгч)

**Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвсэл. (2011).** Үнэлгээний гарын авлага. Лондон: Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвсэл.

**Хүүхдийг Ивээх Сан Сьерра-Леоне. (2011).** Жендэр, бэлгийн мөлжлөг, зүй бус харьцаа, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар Сиарра Лионий Пүжэхүн дүүргийн хүн амын мэдлэг, хандлага, дадал.

**Шарп, Л., & Фречлинг, Ж. (1997, 8-р сар).** Бүлэг I. Холимог аргаар үнэлгээ хийх танилцуулга. Холимог аргаар үнэлгээ хийх гарын авлагаас 2012 оны 11-р сарын 4-нд татан авсан. <http://www.nsf.gov/pubs/1997/nsf97153/start.htm>

**Шенк, К., Виллиамсон, Ж. (2005).** Олон улсын нөхцөлд хүүхэд, өсвөр насныхнаас мэдээлэл цуглуулах ёс зүйн арга хандлага: Удирдамж, нөөц. Вашингтон: Хүн амын зөвлөл. 2012 оны 11-р сарын 14-нд татан авсан. Холбоос: <http://www.popcouncil.org/pdfs/horizons/childrenethics.pdf>

**Трохим, В. М. (2006, 10-р сарын 20).** Судалгааны аргуудын талаарх суурь мэдлэг, 2 дахь хэвлэлээс 2012 оны 11-р сарын 5-нд татан авсан. Холбоос: <http://www.socialresearchmethods.net/kb/>

**Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. (2008).** Сүрьеэгийн хяналтанд авах нөлөөлөл, харилцаа, нийгмийн хөдөлгөөн: мэдлэг, хандлага, дадлын асуулгын судалгаа хийх удирдамж. Женев: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ).

**Дэлхийн Эрүүл Мэндийн Холбооны Хельсинкийн тунхаглал. (1964, 6-р сар).** Хельсинк, Финлянд: Дэлхийн эрүүл мэндийн холбооны ерөнхий ассемблейн 18-р чуулган.





WE ARE the world's leading independent organisation for children.

OUR VISION is a world in which every child attains the right to survival, protection, development and participation.

OUR MISSION is to inspire breakthroughs in the way the world treats children, and to achieve immediate and lasting change in their lives.



Child Protection Initiative  
December 2012  
<http://resourcecentre.savethechildren.se>  
cpi@rb.se